



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 9

- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль нэмэлт оруулах тухай Монгол Улсын хууль
- Гэрээ соёрхон батлах тухай Монгол Улсын хууль
- Хүн амын орлогын албан татварын хууль өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хууль
- Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуульд өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хууль
- Нийслэлийн эрх зүйн байдалын тухай Монгол Улсын хууль
- Жагсаал, цуглаан хийх журмын тухай Монгол Улсын хууль

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар

1994 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

(ХУУЛЬ, ТОГТООЛ, ЗАРЛИГ,
ШИЙДВЭР, НИЙТЛЭЛ—ХУУЛИЙН
ТАЙЛБАР)

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар

№

1994 оны 9 сар

№ 9 (28)

ГАРЧИГ

I. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- | | | |
|----|---|-----|
| 1. | Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай | 753 |
| 2. | Гэрээ соёрхон батлах тухай | 754 |
| 3. | Гэрээ соёрхон батлах тухай | 754 |
| 4. | Гэрээ соёрхон батлах тухай | 755 |
| 5. | Гэрээ соёрхон батлах тухай | 755 |
| 6. | Хүн амын орлогын албан татварын хуульд өөрчлөлт оруулах тухай | 756 |
| 7. | Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуульд өөрчлөлт оруулах тухай | 757 |
| 8. | Нийслэлийн эрх зүйн байдалын тухай | 758 |
| 9. | Жагсаал, цуглаан хийх журмын тухай | 766 |

II. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | |
|-----|--|-----|
| 10. | Ж. Чойжаланцанг Үндсэн хуулийн цэцгийн гишүүний үүрэгт ахлахс нөлөөлөх тухай № 51 | 776 |
| 11. | Үндсэн хуулийн цэцгийн дүгнэлтийн тухай № 52 | 776 |
| 12. | Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан авах зарим арга зэмжээний тухай № 53 | 777 |
| 13. | Р. Одонбаатарыг Байнгын хорооны гишүүнээр батлах тухай № 54 | 778 |
| 14. | Нягтний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим хэсэгт тавьсан хэргийн тухай № 55 | 779 |

15.	Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлал, цэргийн номлол батлах, нийтлэх тухай № 56	780
III. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИГЛӨГЧИЙН ЗАРИМГ		
16.	Ж. Дүгэрт Монгол Улсын гавьяат багш цол олгох тухай № 69	818
17.	Зарим багш, ажилчдыг одон, медалиар шагнах тухай № 70	818
18.	Дүрэм батлах тухай № 71	824
19.	Дээд офицерын албан тушаалын ангилал, цэргийн цолын зэрэглэлийг тогтоох тухай № 72	828
20.	Цэргийн дээд цол олгох тухай № 73	830
IV. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ		
21.	Дүрэм батлах тухай № 75	831
22.	Архидан согуурахтай тэмцэх талаар явах зарим арга хэмжээний тухай № 76	837
23.	Хилийн мөргөжлийн хяналтыг сайжруулах талаар явах зарим арга хэмжээний тухай № 78	847
24.	«Чингис хаан» зочид буудлын барилгын ажлыг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай № 79	852
25.	Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай № 80	853
V. ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ		
26.	Монгол Улсын Ерөнхий Прокурор Үндсэн хууль зөрчсөн, Прокурорын байгууллагын тухай хууль Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг хянан хэлэлцсэн тухай № 07	854
VI. НИЙТЛЭЛ, ТАЯЛБАР ЗӨВЛӨМЖ		
27.	Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, гадаад бодлогын үзэл баримтлал, цэргийн номлолын үндэсний үндсэн агуулга	862

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 06 дугаар
саяны 17-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, мөн зүйлийн 4 дэх хэсгийн 5 дахь заалтад нэмэлт оруулж дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

«2. Аймаг, нийслэлийн хурлын төлөөлөгчдийг сум, дүүргийн Хурлаас нэр дэвшүүлж дөрвөн жилийн хугацаагаар, сум дүүргийн Хурлын төлөөлөгчдийг баг, хорооны хурлаас нэр дэвшүүлж 2 жилийн хугацаагаар саналаа нууцаар гаргаж сонгоно»,

9 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 5 дахь заалт:

«5) сум, дүүргийн хуралд баг, хороо бүрээс 5 төлөөлөгч, аймгийн Хуралд сум бүрээс 3) 10000-аас дээш хүн амтай сумаас 5, 20000-аас дээш хүн амтай сумаас 10, 30000 дээш хүн амтай сумаас 20, 40000-аас дээш хүн амтай сумаас 30, 50000-аас дээш хүн амтай сумаас 40) төлөөлөгч, нийслэлийн Хуралд дүүрэг бүрээс 8 (10000 хүртэл хүн амтай дүүргээс 2) төлөөлөгч тус тус сонгоно,

Хүн амын болон сумдын тоо нь цөөн байгаа тохиолдолд Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн тоо 21-ээс илүүгүй байна.

2 дугаар зүйл. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт дор дурдсан агуулгатай 6 дахь заалт нэмсүгэй:

«6) Энэ зүйлийн 4 дэх хэсгийн 5 дахь заалтын хоёр дахь хэсэгт заасан төлөөлөгчдийн тоог тухайн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид сумдын хүн амын тоог харгалзан тогтооно.»

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 7 дугаар
сарын 4-ний өдөр

Улаанбаатар
хот

ГЭРЭЭ СОЕРХОН БАТЛАХ ТУХАЙ

I дүгээр зүйл. 1993 оны 10 дугаар сарын 22-ний өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан «Гэмт хэрэг үйлдэгсдийг эрүүгийн хариуцлагад татах буюу таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлэхээр шилжүүлэн өгөх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улсын хоорондын Гэрээ»-г Засгийн газраас өргөн мэдүүлсний дагуу соёрхон баталсугай.

Монгол Улсын Их Хурлын
дэргэ

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 7 дугаар
сарын 4-ний өдөр

Улаанбаатар
хот

ГЭРЭЭ СОЕРХОН БАТЛАХ ТУХАЙ

I дүгээр зүйл. 1993 оны 10 дугаар сарын 22-ний өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан «Иргэний болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улсын хоорондын Гэрээ»-г Засгийн газраас өргөн мэдүүлсний дагуу соёрхон баталсугай.

Монгол Улсын Их Хурлын
дэргэ

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 7 дугаар
сарын 4-ний өдөр

Улаанбаатар
хот

ГЭРЭЭ СОЕРХОН БАТЛАХ ТУХАЙ

I дүгээр зүйл. 1993 оны 10 дугаар сарын 22-ний өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан «Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улсын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай Гэрээ»-г Засгийн газраас өргөн мэдүүлсний дагуу соёрхон баталсугай.

Монгол Улсын Их Хурлын
дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 7 дугаар
сарын 4-ний өдөр

Улаанбаатар
хот

ГЭРЭЭ СОЕРХОН БАТЛАХ ТУХАЙ

I дүгээр зүйл. 1994 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан «Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай Гэрээ»-г Засгийн газраас өргөн мэдүүлсний дагуу соёрхон баталсугай.

Монгол Улсын Их Хурлын
дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 7 дугаар
сарын 4-ний өдөр

Улаанбаатар
 хот

ХҮН АМЫН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хүн амын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг дараахь байдлаар өөрчлөн найруулсугай:

«1. Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 3, 4, 7-д заасан болон зөрөнгө түрээслүүлсний орлогын дүнгээс дараахь хэмжээгээр албан татвар ногдуулна:

Албан татвар ногдуулах жидийн орлогын хэмжээ (төгрөгөөр)	Албан татварын хувь, хэмжээ
144001—288000	2 хувь,
288001—576000	2880 төгрөг дээр 288000 төгрөг- нөөс дээш орлогын дүнгийн 5 хувийг нэмнэ,
576001—1152000	17280 төгрөг дээр 576000 төг- рөгнөөс дээш орлогын дүнгийн 15 хувийг нэмнэ,
1152001—2304000	103680 төгрөг дээр 1152000 төг- рөгнөөс дээш орлогын дүнгийн 27 хувийг нэмнэ,
2304001, түүнээс дээш	414720 төгрөг дээр 2304000 төг- рөгнөөс дээш орлогын дүнгийн 40 хувийг нэмнэ.»

2 дугаар зүйл. Хүн амын орлогын албан татварын хуу-
лийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1-д «96000 хүртэл төг-
рөгийн» гэснийг «144000 хүртэл төгрөгийн» гэж өөрчилсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 1995 оны 1 дүгээр сарын 1-ний
өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 7 дугаар
сарын 4-ний өдөр

Улаанбаатар
хот

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ОРЛОГЫН
АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-ийг дараахь байдлаар өөрчлөн найруулсугай:

<1> энэ хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан болон хөдлөх хөрөнгө борлуулсны орлогод:

Албан татвар ногдуулах жилийн орлогын хэмжээ (төгрөгөөр)	Албан татварын хувь, хэмжээ
0—1500000	15 хувь,
1500001—3000000	225000 төгрөг дээр 1500000 төгрөгнөөс дээш орлогын дүнгийн 25 хувийг нэмнэ,
3000001—4500000	600000 төгрөг дээр 3000000 төгрөгнөөс дээш орлогын дүнгийн 35 хувийг нэмнэ,
4500001, түүнээс дээш	1125000 төгрөг дээр 4500000 төгрөгнөөс дээш орлогын дүнгийн 40 хувийг нэмнэ.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 1995 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын
дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 07 дугаар
сарын 03-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙСЛЭЛИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нийслэлийн (цаашид «нийслэл» гэх) чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх эдийн засгийн үндэс, удирдлагын эрх хэмжээ, онцлог, нийслэлтээс аж ахуйн нэгж, байгууллага, иргэд болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгжтэй харилцах эрх зүйн үндсийг тодорхойлж, энэ явцад үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж

Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон бусад хууль, гэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Нийслэл, түүний чиг үүрэг

1. Монгол Улсын Үндсэн хуулийн арван гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Монгол Улсын нийслэл нь Улаанбаатар хот мөн.

2. Нийслэл нь засаг захиргааны хувьд дүүрэгт, дүүрэг өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор бөгөөд тусгай статус бүхий хот мөн.

3. Нийслэл нь засаг захиргааны хувьд дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана.

4. Нийслэл нь эдийн засгийн дэд бүтцийг тэнцвэртэй хөгжүүлэх, хүн амын хэт төвлөрөл болон хотын хангамж, үйлчилгээ, аж ахуйн үйл ажиллагааг зохицуулах, оршин суугчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, байгаль орчны зохистой харьцааг задгалах үүднээс дагуул хот (алслагдсан дүүрэг, хаяа хот)-той байж болно.

5. Нийслэлд Монгол Улсын төрийн дээд болон төв байгууллага, тус улсад байгаа гадаад орны дипломат төлөөлөгчдийн газар байнга төвлөн оршино.

6. Нийслэл нь нутаг дэвсгэртээ байгаа төрийн дээд, төв болон бусад байгууллагын ажиллах хэвийн нөхцөлийг хангах үүрэг хүлээнэ.

7. Төрийн эрх бүхий байгууллага өөрөөр шийдвэрлээгүй бол нийслэлд улсын баяр наадам, төрийн ёслолын арга хэмжээ явагдана.

4 дүгээр зүйл. Нийслэлийн нутаг дэвсгэр, эдэлбэр газар

1. Нийслэл нь Улсын Их Хурлаас баталсан хилийн цэс бүхий нутаг дэвсгэртэй байх бөгөөд түүний дотор хотын эдэлбэр газар байна.

2. Хот байгуулах зорилдалтаар хотын ерөнхий төлөөлөгчөөр тодорхойлогдож, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан гартыг бүхий газрыг нийслэл хотын эдэлбэр газар гэнэ.

3. Нийслэлийн эдэлбэр газарт нийслэлийн хилийн цэсийн дотор оршино буй дагуу хотын эдэлбэр газар хамарна.

4. Нийслэлийн дагуу хотын нутаг дэвсгэр нь нийслэлийн хилийн цэст багтана.

5 дугаар зүйл. Нийслэлийн бэлгэ тэмдэг

1. Нийслэл нь өөрийн туг, сүлд тэмдэгтэй байна.

2. Нийслэлийн туг, сүлд тэмдгийн загвар, хэрэглэх журмыг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтооно.

ХОЕРДУГААР БҮЛЭГ

Нийслэлийн удирдлага

6 дугаар зүйл. Нийслэлийн удирдлага, түүний онцлог

1. Нийслэлийн удирдлагын тогтолцоо нь Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан ёсоор бүрдэнэ.

2. Нийслэлийн Засаг дарга нь Улаанбаатар хотын захирагч байх бөгөөд тэрээр хотын аж ахуйг биечлэн зохион байгуулах, мэргэжлийн албандыг зохицуулан удирдах үүрэг бүхий хотын ерөнхий менежерийг томилон ажиллуулна.

3. Хотын ерөнхий менежер нь Улаанбаатар хотын захирагчийн удирдлага дор ажиллана.

4. Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба нь нийслэлийн Засаг даргын ажлын албанаас тусдаа байна.

5. Нийслэлийн Засаг дарга нь Улаанбаатар хотын захирагчийн хувьд өөртөө зөвлөх эрх бүхий мэргэжлийн орон тооны бус зөвлөлийг байгуулан ажиллуулна.

6. Энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан зөвлөлийн бүрэлдэхүүнийг нийслэлийн нийгэм, эдийн засгийн амьдралд нөлөө бүхий аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, нийслэлийн Засаг даргын ажлын албаны болон холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулан нийслэлийн Засаг дарга батална.

7 дугаар зүйл. Удирдлагын үйл ажиллагааны үндсэн зарчим

1. Нийслэлийн удирдлага нь зохнон байгуулалт, үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон бусад хуульд заасан үндсэн зарчмыг баримтална.

2. Нийслэлийн удирдлагаас чиг үүргээ хэрэгжүүлэхдээ оршин суугчдынхаа хууль ёсны ашиг сонирхлыг эрхэмлэнэ.

3. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга үйл ажиллагаандаа иргэдийн санал бодол, нутаг дэвсгэртээ ажиллаж буй төр, олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгж, сүм хийд, буяны болон сайн саналны байгууллага, олон түмний идэвх оролцоонд тулгуурлах зарчмыг баримтална.

8 дугаар зүйл. Нийслэлийн удирдлагын бүрэн эрх

1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид заасан бүрэн эрх эдлэхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) нийслэлтэй холбогдсон асуудлаар хууль тогтоомжид нийцүүдэн бие даан шийдвэр гаргах;

2) нийслэлд хэв журам сахуулах, хотын аж ахуй, оршин суугчдын нийгэм, соёлын асуудлаар нийтээр дагаж мөрдөх журмыг хууль тогтоомжид нийцүүдэн гаргаж, биелэлтэд хяналт тавих;

3) нийслэл, түүний оршин суугчдын нийтлэг ашиг сонирхлыг хөндсөн, өөрийн эрх хэмжээнд шийдвэрлэх боломжгүй асуудлыг шийдвэрлүүлэхээр Монгол Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, холбогдох бусад байгууллаагад санал тавих;

4) нийслэлийн нийгэм, эдийн засгийн хөгжил, хот байгуулалт, хүрээлэн байгаа орчныг хамгаалах, хүн амын үйл-

чилгээтэй холбогдох асуудлаар төрийн захиргааны төв байгууллагад санал тавьж шийдвэрлүүлэх;

5) нийслэлийн хэмжээнд тэмдэглэлт ой, баяр ёслол тэмдэглэх, байгууллага, гудамж, талбайд нэр өгөх, нэрэмжит Солгох, хөшөө дурсгалын цогцолбор байгуулах асуудлаар өөрийн санаачилгаар болон иргэд, байгууллагын саналыг үндэслэн шийдвэр гаргах.

2. Нийслэлийн Засаг дарга нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид заасан бүрэн эрх эдлэхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) нийслэл хот улсын хэмжээнд суурин соёл иргэншлийн тэргүүлэх байр суурь эзлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор төрийн захиргааны төв байгууллагуудтай нэгдсэн бодлого явуулах асуудлаар Ерөнхий сайдтай шууд харилцах;

2) нийслэлд хүн амын хэт төвлөрөл бий болох, ажла эрхлэлт, нийтийн үйлчилгээ, тээвэр, холбооны хэвийн ачаалал алдагдалхаас сэргийлэх зорилгоор нийслэлд шилжин суурьших асуудлаар хууль тогтоомжийн хүрээнд зохицуулалт хийх;

3) хүн амын эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах ашиг сонирхоод нийцүүлэн хүрээлэн байгаа орчныг бохирдуулах бодисын зөншөөрөгдөх хэмжээг хэтрүүлэхүйц үйлдвэр, объектын барьж байгуулах асуудалд холбогдох байгууллагын дүгнэлтийг үндэслэн хориг тавих, үйлдвэрлэл, үйл ажиллагааг нь түр түдгэлзүүлэх; нийслэлээс нүүлгэн шилжүүлэх тухай асуудлыг зохих байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

4) засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгжээс нийслэлд ажиллах хүчийг зохион байгуулалттайгаар шилжүүлэх асуудлыг зохицуулах;

5) нийслэлийг хөгжүүлэх асуудлаар төсөл санаачлах, төсөлд санал, дүгнэлт өгөх, түүнийг хэрэгжүүлэхэд Засгийн газраас дэмжлэг хүсэх;

6) дотоод, гадаад харилцаанд нийслэлийг төлөөлөх.

3. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захиргагч бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ Засгийн газрын гишүүнтэй адил баталгаагаар хангагдана.

ГУРАВДУГААР ЗҮНЛ

Нийслэлийн удирдлага, иргэд, байгууллагын хоорондын харилцаа

9 дүгээр зүйл. Төрийн захиргааны төв байгууллагатай харилцах

1. Төрийн захиргааны төв байгууллагаас салбарын удирдлагыг хэрэгжүүлэхдээ нийслэл, түүний оршин суугчдын нийтлэг эрх ашигтай холбогдох асуудлаар нийслэлийн Засаг дарга, шаардлагатай гэж үзвэл иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, эсхүл түүний Тэргүүлэгчидтэй зөвшилцөнө.

2. Нийслэлийн удирдлага төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан аливаа шийдвэрийг нийслэлийн эрх ашигт харш хэмээн үзвэл уг шийдвэрийн талаархи санал, дүгнэлтээ Засгийн газар болон холбогдох байгууллагад гаргана.

3. Нийслэлийн удирдлагаас хот тохижилт, хүрээлэн байгаа орчин, хот-нийтийн аж ахуйг хамгаалах талаар гаргасан шийдвэрийг төрийн захиргааны төв байгууллага биедүүлэх үүрэгтэй.

4. Төрийн захиргааны төв байгууллагаас өөрийн болон нийслэлд орших харьяа байгууллагуныхаа хэрэгцээнд нийслэлийн нутаг дэвсгэрт газар эзэмших, түрээслэх тухай асуудлыг нийслэлийн удирдлагад тавьж шийдвэрлүүлнэ.

10 дугаар зүйл. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгжтэй харилцах

1. Нийслэлийн удирдлагаас засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгжийн удирдлагатай нийслэлийн эдийн засаг, нийгэм, соёлын талаар хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллана.

2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгжийн удирдлага нийслэлийн хүн амыг хүнс болон шаардагдах бусад зүйлээр хангах, нийслэлд улсын баяр наадам, төрийн ёслолын арга хэмжээ зохион явуулахад хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн дагуу дэмжлэг үзүүлж, үүрэг хүлээнэ.

3. Нийслэлийн хөгжил, хүн амын хангамж, нийгэм, эдийн засгийн үндэс болох үйлдвэр, аж ахуй, хангалтын зориулалттай бааз газрыг Засгийн газрын шийдвэрээр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгжийн нутаг дэвсгэр дээр байгуулж, тэрээний үндсэн дээр ашиглаж болно.

4. Нийслэл, аймаг, бусад хотын хоорондын эдийн засаг, нийгэм, аж ахуйн харилцааг хуулиар тусгайлан зохицуулна.

11 дүгээр зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагатай харилцах

1. Нийслэлийн удирдлага нийслэлийн нутаг дэвсгэрт байрлаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, ажил үйлчилгээг сайжруулах талаар шаардлага тавина.

2. Нийслэлийн удирдлага хотын аж ахуй, нийтийн үйлчилгээний тоног төхөөрөмж, инженерийн барилга байгууламжийн эзэмших хэмжээг тогтоож, ашиглалт засварыг нь хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр аж ахуйн нэгж, байгууллагад харвууцна.

3. Эрчим хүчний болон нийтийн тээврийн ачааллыг зохицуулах зорилгоор аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээний ажил эхлэх, дуусах цагийг тогтооно.

4. Нийслэлийн нутаг дэвсгэрт байрладаг гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллагатай харилцах асуудлыг тухайн гэрээнд зааснаар буюу Монгол Улсын хууль тогтоомжоор зохицуулна.

12 дугаар зүйл. Төр, олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгжээс нийслэлийн өмнө хүлээх үүрэг

Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төр, олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгж нь өмчийн хэлбэрээс үл хамааран нийслэлийн өмнө дараахь үүрэг хүлээнэ:

1) хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт ийнцүүлэн нийслэлийн удирдлагаас нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрийг ажигласадлаа мэдээлж, биелэлтийг хангах;

2) Нийслэлийн онцлог чиг үүргийг хэрэгжүүлэх талаар нийслэлийн удирдлагаас явуулж буй үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

3) өөрийн эзэмшиж буй эдэлбэр газар, барилга байгууламж болон орчны гудамж, талбайг шаардлагын дагуу зүй зохистой ашиглах.

13 дугаар зүйл. Нийслэл хотын оршин суугч, нийслэлийн өмнө түүний хүлээх үүрэг

1. Нийслэл хотод хууль ёсоор байнга амьдарч буй Монгол Улсад иргэнийг нийслэл хотын оршин суугч гэнэ.

2. Нийслэл хотын оршин суугч нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан үндсэн эрх, эрх чөлөөг баталгалтай эдлэхийн зэрэгцээ нийгэм, эдийн засгийн давуу талыг эдэлж, ажиллаж амьдрах таатай нөхцөлөөр хангагдаж байдгийн хувьд нийслэлийн өмнө дараахь үүрэг хүлээнэ:

1) нийслэл хотын татварыг хугацаанд нь төлөх;

2) нийслэлийн удирдлагаас нийтээр дагивж мөрдөхөөр гаргасан шийдвэр, тогтоосон журмыг сахих, гэмт хэрэг, хэв журмын зөрчилтэй тэмцэх ажилд оролцох;

3) нийслэлийн бүх шатны удирдлагаас зохвож буй ажил, нийслэлийг хөгжүүлэх үйлсэд идэвхтэй оролцож, хотын аж ахуй, нийтийн үйлчилгээний байгууламжийг зориулалтын дагуу эзэмшиж, хайрлан хамгаалах, ариун цэврийг сахих, гудамж талбайг цэвэр байлгах;

4) нийслэл хотын оршин суугчийн хууль ёсны баримт бичгийн зөрчилгүй байх.

3. Нийслэл хотын оршин суугч бин Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн нийслэл хотод амьдарч байх хугацаандаа энэ хууль, бусад хууль тогтоомж, нийслэлийн удирдлагаас гаргасан шийдвэрийг сахин биелүүлэх үүрэгтэй.

14 дүгээр зүйл. Нийслэлийн дүүрэг, хорооны удирдлагаас нийслэлийн өмнө хүлээх үүрэг

Нийслэлийн дүүрэг, хорооны удирдлага тухайн нутаг дэвсгэртээ энэ хуулийн хэрэгжилтийг хариуцна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Нийслэлийн онцлог чиг үүргийг хэрэгжүүлэх эдийн засгийн үндэс

15 дугаар зүйл. Нийслэлийн эдийн засгийн үндэс

Нийслэлийн эдийн засгийн үндэс нь түүнд хууль тогтоомжийн дагуу эзэмшүүлсэн газар, түүний хэвлэл, ой, ус, амьтан, урсгал, байгалийн бусад баялаг, хотын мэдлийн аж ахуй, улсын хөрөнгө оруулалтаар бий болсон өмч хөрөнгө, татвар, нийслэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгөөс бүрдэнэ.

16 дугаар зүйл. Нийслэлийн өмч

1. Нийслэл нь өөрийн мэдлийн өмчтэй байна.

2. Нийслэлийн өмч нь барилга байгууламж, эд хөрөнгө, хотын аж ахуйн болон бусад хөрөнгөөс бүрдэнэ.

17 дугаар зүйл. Нийслэл хотын төсөв

Нийслэл хот нь бие даасан төсөвтэй байна.

18 дугаар зүйл. Нийслэлийг хөгжүүлэх сан

1. Нийслэл нь хотын аж ахуйг өргөтгөх, хот байгуулалт, түүний дэд бүтцийг хөгжүүлэх, хүн амын хангамж, үйлчилгээг сайжруулах, байгаль орчныг хамгаалах зорилгоор Засгийн газраас тогтоосон тусгай зориулалтын сантай байж болно. Энэхүү сангийн хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу зарцуулна.

2. Нийслэлийг хөгжүүлэх зориулалтаар дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс өргөсөн хандив, буцаалтгүй тусламж, бусад орлогоос бүрдсэн сан байж болох бөгөөд сангийн хөрөнгийг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан журмын дагуу нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч захирал зарцуулж, түйцэтгэлийн тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд жил бүр тавина.

19 дүгээр зүйл. Нийслэл хотын татвар

1. Нийслэл хот татвартай байна.

2. Нийслэл хотын татварыг хуулиар тогтооно.

20 дугаар зүйл. Нийслэлийг хөгжүүлэх бодлого

1. Нийслэл хот нь нийгэм, соёлын амьдралын бүхий л хүрээнд тэргүүлэх байр суурь эзлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хот байгуулалт, нийгэм, эдийн засаг, байгаль орчин зохистой тэнцлийг хангах бие даасан бодлого явуулна.

2. Нийслэлийн хот байгуулалт, төлөвлөлт нь үндэсний уран барилгын өв уламжлалыг дээхийн нийслэл хотуудын хөгжлийн нийтлэг жишэгтэй хослуулан хөгжүүлэх бодлогод үндэслэнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

21 дүгээр зүйл. Нийслэлийн хүндэт иргэн ба шагнал

1. Нийслэлийг хөгжүүлэх хэрэгт онцгой хувь нэмэр оруулсан хүнийг «Нийслэл хотын хүндэт иргэн»-д өргөмжлөх болон бусад шагналаар шагнана. «Нийслэл хотын хүндэт ир-

гэн»-д өргөмжлөх асуудлыг нийслэлийн Засаг даргын өргөн мэдүүлснээр нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид шийдвэрлэнэ.

2. «Нийслэл хотын хувьд иргэн»-д өргөмжлөх болон бусад шагналаар шагнах журмыг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

22 дугаар зүйл. Нийслэлийн мэдээлэл, судалгааны байгууллага

1. Нийслэл Улаанбаатар хот нь өөрийн сонин, телевиз болон радиогийн нэвтрүүлэгтэй байж болно.

2. Нийслэлийн удирдлага нь дэргэдээ хотын хөгжлийн түүх, хэгийн төлөвийг тодорхойлох, хот байгуулалт, хүн ам, хүрээлэн байгаа орчны асуудал болон олон нийтийн санаа бодлыг судлах шинжилгээ, судалгааны төвтэй байж болно.

23 дугаар зүйл. Нийслэлийн өдөр

Нийслэлийн өдрийг жил бүр тэмдэглэнэ. Нийслэлийн өдрийг Улсын Их Хурал тогтооно.

Монгол Улсын Их Хурлын
дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ ЖУРМЫН ТУХАЙ

I дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь тайван жагсаал, цуглаан хийх иргэдийн Үндсэн хуулийн эрх чөлөөг баталгаажуулах, жагсаал цуглаан хийх журмыг тогтоох, уул арга хэмжээний үед илгэмийн хэв журам, иргэдийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль тогтоомж

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Жагсаал, цуглаан

1. Монгол Улсын иргэдээс улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон асуудлаар үзэл бодол, санал, шаардлагаа нийтэд илэрхийлэх зорилгоор зохион байгуулж байгаа үйл ажиллагааг цуглаан гэнэ.

2. Иргэд хот суурингийн гудамж таалбайгаар зохион байгуулалттайгаар жагсан ивж, энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан асуудлаар үзэл бодол, санал, шаардлагаа илэрхийлж байгааг жагсаал гэнэ.

4 дүгээр зүйл. Жагсаал, цуглаан зохион байгуулах эрх

1. Жагсаал, цуглааныг Монгол Улсын иргэн, улс төр, олон нийтийн байгууллага зохион байгуулах эрхтэй.

2. Хууль Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гэдвэд улсын иргэн, харьяалаагүй хүн Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаж байгаа жагсаал, цуглаанд оролцох эрхтэй.

5 дугаар зүйл. Хууль үйлчлэх хүрээ

Энэ хууль дараахь арга хэмжээ зохион байгуулахад үйлчлэхгүй:

1) төрийн ёслолын болон төрийн эрх бүхий байгууллагаас зохион байгуулж байгаа жагсаал, цуглаан;

2) иргэд, байгууллага энэ хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан асуудалтай холбогдолгүй сэдвээр зохион байгуулж байгаа спорт, урлаг, уран сайхан, баяр наадмын болон тэдгээртэй адилтгах бусад арга хэмжээ;

3) төрийн болон улс төрийн нам, олон нийтийн байгууллагаас иргэд, сонгогчид, гишүүд, дэмжигчидтэй хийх хурал, уулзалт;

4) аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн ажиллагсдаас тухайн байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбогдолтой асуудлаар зохион байгуулж байгаа хурал, цуглаан, тэдгээртэй адилтгах бусад арга хэмжээ.

6 дугаар зүйл. Жагсаал, цуглаан хийх эрхийн баталгаа

1. Хууль тогтоомжийн дагуу жагсаал, цуглаан зохион байгуулсан буюу түүнд оролцсоны төлөө хэнийг ч мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлах, аливаа хэлбэрээр гадуурхахыг хориглоно.

2. Энэ хуульд зааснаас бусад тохиолдолд жагсаал, цуглаан хийхэд зориуд саад учруулах, түүнчлэн хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаж байгаа жагсаал, цуглааныг тараахыг хориглоно.

7 дугаар зүйл. Жагсаал, цуглаан хийхийг хориглох газар

1. Дараахь байгууллага оршин байгаа газарт энэ хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан асуудлаар жагсаал, цуглаан хийхийг хориглоно:

1) нисэх онгоцны буудал, төмөр замын бүх өртөө, буудал, нийслэлийн зорчигч тээврийн төв буудал;

2) цэрэг, цагдаагийн болон төрийн хамгаалаалтад байгаа газар;

3) радио телевизийн нэвтрүүлэг явуулдаг байгууллага, аймаг, нийслэл дэх төв холбооны газар;

4) олон улсын буюу үндэсний яармаг, үзэсгэлэн зохион байгуулж байгаа байгууллага, хот суурин газрын хүнсний болон барааны зах;

5) эмнэлгийн байгууллага.

2. Нийслэл Улаанбаатар хотын Сүхбаатарын талбайд жагсаал, цуглаан хийхийг хориглоно.

8 дугаар зүйл. Жагсаал, цуглаан болон өлсгөлөн зохион байгуулахыг хориглох

1. Дараахь зорилгоор жагсаал, цуглаан хийхийг хориглоно:

1) дайн сурталчлах, үндэстэн ястны хооронд хагарал гаргах буюу үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, шашин шүтлэгээр ялгаварлан гадуурхах, элдэв, хядлага, хорлон сүйтгэх ажиллагаа явуулах, төрийн эрх мэдлийг хууль бус аргаар авахыг уриалах;

2) үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журамд хоррол учруулж эмх замбараагүй байдал бий болгох.

2. Энэ хуулиар хориглоогүй зорилгоор анх зохион байгуулагдасан жагсаал, цуглааны явцад түүний зорилго өөрчлөгдөж энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан агуулга, шинжтэй

болбол уг жагсаал, цуглааныг цаанид үргэлжлүүлэхийг хориглоно.

3. Улс орны буюу тодорхой нутаг дэвсгэрийн хэмжээнд онц болон дайны байдал зарласан, байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон бол тухайн нутаг дэвсгэрт уг шалтгаан арилтал жагсаал, цуглаан хийхийг хориглоно.

4. Онц болон дайны байдал зарласан шалтгааныг эсэргүүцэх, байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулын үр дагаврыг арилгах зорилгоор зохион байгуулах цуглаанд энэ зүйлийн 3 дахь хэсгийн заалт үл хамаарна.

5. Зохиж журмын дагуу зөвшөөрөгдсөн жагсаал, цуглаан хийх газарт мөн цаг хугацаанд түүний эсрэг агуулга, зорилготой өөр жагсаал, цуглаан давхардуулан хийхийг хориглоно.

6. Гудамж, талбайд өлсгөлөн зартахыг хөндлөнгөөс зориуд зохион байгуулахыг хүний амь нас, эрүүл мэндийг үл хайхарсан хүмүүнлэг бус үйлдэл гэж үзэж хориглоно.

9 дүгээр зүйл. Жагсаал, цуглаан хийх журам

1. Гудамж, талбайд жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдлийг сум, дүүргийн Засаг даргад өгч зөвшөөрөл авна. Жагсаал, цуглаан хийхээр төлөвлөсөн гудамж, талбай нь хоёр буюу түүнээс дээш сум, дүүргийн хвлийн цэст хамаарах газар нутгийг хамарч байгаа бол зөвшөөрлийг аймаг, нийслэлийн Засаг дарга олгоно.

2. Жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдэлд түүний зорилго, эхлэх, дуусах хугацаа, оролцогчдын баримжаа тоо, хэрэглэх техник хэрэгсэл, цуглах, жагсан явах гудамж, талбай зэргийг тодорхой заана.

3. Засаг дарга жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 6 өдрийн дотор түүнийг зөвшөөрсөн эсэхэв бичгээр мэдэгдэнэ.

4. Жагсаал, цуглаан хийхийг зөвшөөрөх эсэх тухай асуудлыг шийдвэрлэхийн тулд нэмж тодруулах буюу зохицуулбал зохиж асуудал гарвал Засаг дарга энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан хугацааны дотор зохион байгуулагчтай харилцаж зохицуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд жагсан явах чиглэлийг өөрчлөх эрхтэй.

5. Засаг дарга энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан хугацааны дотор харну мэдэгдээгүй бол зохион байгуулагч нь мэдэгдэлд дурдсан газарт, түүнд заасан хугацааны дотор жагсаал, цуглааныг зохион байгуулах эрхтэй.

6. Засаг даргаас зөвшөөрөл авсны дараа жагсаал, цуглаан хийх талаар зарлан мэдэгдэнэ. Ийнхүү заалт энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу жагсаал, цуглаан зохион байгуулахад үл хамаарна.

10 дугаар зүйл. Жагсаал, цуглаан хийхийг зөвшөөрөхөөс татгалзах

1. Жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдэл хүлээн авсан Засаг дарга дор дурдсан үндэслэл байвал түүнийг хийхийг зөвшөөрөхөөс татгалзсан шийдвэр гаргаж, энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан хугацаанд жагсаал, цуглаан зохион байгуулагчид бичгээр мэдэгдэнэ:

1) шүүхийн болон эрх бүхий бусад байгууллагын шийдвэрээр үйл ажиллагаа нь зогсоогдсон буюу татан буугдсан, эсхүл албан ёсны бүртгэлгүй улс төрийн нам, олон нийтийн байгууллага жагсаал, цуглаан хийх мэдэгдэл гаргасан бол;

2) энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан газарт жагсаал, цуглаан хийхээр төлөвлөсөн бол;

3) энэ хуулийн 8 дугаар зүйлээр хориглосон жагсаал, цуглаан хийхээр төлөвлөсөн бол.

2. Жагсаал, цуглаан хийхийг зөвшөөрөхөөс татгалзсан шийдвэр хүлээн авсан зохион байгуулагч түүнийг хуульд нийцэхгүй байна гэж үзнэл гомдлоо уг шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 3 өдрийн дотор шүүхэд гаргана.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан гомдлыг шүүгч ажлын 6 өдрийн дотор багтаан хянан шийдвэрлэнэ.

4. Шүүгч жагсаал, цуглаан хийхийг зөвшөөрөхөөс татгалзсан Засаг даргын шийдвэрийг хүчингүй болгосон бол зохион байгуулагч нь шүүгчийн захирамжийг хүлээн авсны дараа энэ тухай тухайн Засаг даргад урьдчилан мэдэгдэж жагсаал, цуглаан хийх цаг, хугацааг тохиролцож төлөвлөсөн арга хэмжээгээ зохион байгуулж болно.

11 дүгээр зүйл. Жагсаал, цуглааныг зохион байгуулагч, түүний үүрэг

1. Жагсаал, цуглааныг санаачлагч улс төрийн нам, олон нийтийн байгууллага уг арга хэмжээнээс үүсэх үр дагаврыг биечлэн харууцах үүрэг бүхий зохион байгуулагчийг албан ёсоор томилж, энэ тухай итгэмжлэлийг жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдэлд хавсаргана.

2. Жагсаал, цуглааныг санаачлагч иргэнийг уг жагсаал, цуглааныг зохион байгуулагч гэж үзнэ.

3. Жагсаал, цуглааныг зохион байгуулагч дараахь үүрэг хүлээнэ:

1) жагсаал, цуглаан хийх газарт нийгмийн хэв журам, иргэдийн аюулгүй байдлыг хангах;

2) хот, суурин газрын нийгмийн аж ахуй, зүлэг, таримал, бусдын өмч хөрөнгөд хохирол учруулахгүй байх, жагсаал, цуглааны дараа гудамж, талбайг нэвэрлэж хэвийн байдалд оруулах;

3) халуун, хүйтэн зэвсэг, хорт болон тэсэрч дэлбэрэх бодис, орчин тойрондоо болон хүний амь нас, эрүүл мэндэд аюул учруулж болохуйц аливаа зүйл, амьтан авч явж болохгүйг жагсаал, цуглаанд оролцогчдод урьдчилан анхааруулж тийм тохиолдолд илэрвэл холбогдох байгууллагад нэн даруй мэдэгдэж шаардлагатай арга хэмжээ авахуулах;

4) жагсаал, цуглааны явцад аливаа хэлбэрээр хүч үл хэрэглэх, төр, байгууллага, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг задруулахгүй байх, бусдын нэр төр, алдар хүндийг гутаан доромжлохгүй байхыг оролцогчдод урьдчилан анхааруулж, энэ заалт зөрчигдөмөд хүрвэл нэн даруй таслан зогсоох буюу холбогдох байгууллагад мэдэгдэх;

5) согтууруулах ундаа, мансууруулах буюу хорт бодис хэрэглэсэн болон сэтгэцийн өвчтэй хүмүүс, бага насны хүүхдийг жагсаал, цуглаанд оролцуулахгүй байх, жагсаал, цуглааны явцад согтууруулах ундаа хэрэглүүлэхгүй байх;

6) жагсаал, цуглааны үеэр гудамж, замын хөдөлгөөнийг бүслэн хаах, аливаа байгууллагын хэвийн ажиллагааг алдагдуулах, дотоод хэрэгт нь оролцоход чиглэсэн үйл ажиллагаа явуулахгүй байхыг оролцогчдод урьдчилан анхааруулж, энэхүү шаардлагыг чандлан сахуулах;

7) жагсаал, цуглаанд оролцуулахын тулд бусдыг эд мөнгөөр татах, айлаган сүрдүүлэх, шахаалт дарамт үзүүлэх болон бусад хэлбэрээр албадахгүй байх.

4. Жагсаал, цуглааныг зохион байгуулагч энэ зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг зөрчсөн бол хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.

12 дугаар зүйл. Жагсаал, цуглаанд оролцогчийн үүрэг

1. Жагсаал, цуглаанд оролцогч дараахь үүрэг хүлээнэ:

1) хууль тогтоомж, нийгмийн хэв журмыг чанд сө биелүүлж, аливаа хэлбэрээр хүч хэрэглэхгүй байх, эо байгуулагчийн зүй ёсны шаардлагыг бичлон биелүүлэх

2) халуун, хүйтэн зэвсэг, хорт болон тэсэрч дэлбэрэх бодис, өрчин тойрондоо болон хүний амь нас, эрүүл мэндэд аюул учруулж болохуйц аливаа зүйл, амьтан авч явахгүй байх;

3) согтууруулах ундаа, мөвсүүруулах болон хорт бодис хэрэглэхгүй байх;

4) бага насны хүүхэд болон сэтгэцийн өвчтэй хүнийг дагуулж явахгүй байх;

5) төр, байгууллага, хувь хүний хуульч хамгаалагдсан нууцыг задруулахгүй байх, жагсаал, цуглааны үеэр хэлсэн үг, нийтэд тараасан мэдээллийнхээ үнэн зөвийг бүрэн хариуцах, жагсаал, цуглааныг хувь хүний нэр төр, алдар хүндийг гутаан доромжлох зорилгод ашиглахгүй байх;

6) жагсаал, цуглаанд оролцуулахын тулд бусдыг эд мөнгөөр татах, айлган сурдүүлэх, шахаалт дарамт үзүүлэх болон бусад хэлбэрээр албадахгүй байх.

2. Жагсаал, цуглаанд оролцогч энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн бол хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.

13 дугаар зүйл. Жагсаал, цуглаан, түүнд оролцогчдыг хамгаалах

1. Нийгмийн хэв журам хамгаалах үүрэг бүхий байгууллага нь энэ хуульд заасан журмын дагуу зохион байгуулагдаж байгаа жагсаал, цуглааны үед хэв журам хамгаалж, түүнд оролцогчдыг аливаа гэмт халдлагаас хамгаалах үүрэгтэй.

2. Жагсаал, цуглааны явцад хэв журам хамгаалах нэмэгдэл арга хэмжээ шаардлагатай бол зохион байгуулагч нь энэ тухай хүсэлтээ цагдаагийн байгууллагад гаргана.

3. Жагсаал, цуглаан зохион байгуулагч болон оролцогчид нь хэв журам, хууль ёсыг сахих талаар цагдаагийн алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

14 дүгээр зүйл. Жагсаал, цуглааныг албадан тараах

1. Дараахь тохиолдолд Засаг дарга жагсаал, цуглааныг албадан тараах шийдвэр гаргана:

1) энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу зөвшөөрөл авалгүйгээр жагсаал, цуглаан зохион байгуулсан бол;

2) зөвшөөрөл авсан боловч жагсаал, цуглаан хийх газрыг дур мэдэн өөрчилж, энэ хуулийн 7 дугаар зүйлд хориглосон газарт жагсаал, цуглаан хийж байгаа буюу хийхээр завдсан бол;

3) энэ хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан байгууллага жагсаал, цуглааныг зохион байгуулсан бол;

4) зөвшөөрөгдсөн жагсаал, цуглааны явцад түүний анхны зорилго өөрчлөгдөж, энэ хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан агуулга, шинжтэй болсон, эсхүл онц болон дайны байдал зарласан буюу байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон үед мөн зүйлийн 4 дэх хэсэгт зааснаас бусад зорилгоор жагсаал, цуглаан хийж байгаа бол;

5) Жагсаал, цуглааныг зохион байгуулагч буюу түүнд оролцогчид энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан үүргээ үл биелүүлснээс нийгмийн хэв журам алдагдаж, эмх замбараагүй байдал бий болсон буюу хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан бол.

2. Жагсаал, цуглаан хийхийг зөвшөөрсөн, эсхүл харьяалах нутаг дэвсгэр дээр нь зөвшөөрөлгүй жагсаал, цуглаан зохион байгуулагдаж байгаа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг дарга энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан тохиолдолд бий болсон нөхцөл байдлыг жагсаал, цуглаан зохион байгуулагчид мэдэгдэж, 2 цагийн дотор түүнийг тараахыг бичгээр шаардана.

3. Энэ зүйлийн 2 дэх хэсэгт заасан шаардлага авсан зохион байгуулагч жагсаал, цуглааныг сайн дураар тараахаас татгалзсан буюу татгалзаагүй боловч уг үйл ажиллагааг дурдсан хугацаа өнгөрсний дараа цаашид үргэлжлүүлбэл жагсаал, цуглааныг цагдаагийн байгууллага хуульд заасан арга, хэрэгслээр албадан тараана. Уул жагсаал, цуглааныг албадан тараахад цагдаагийн байгууллагын хүч, хэрэгсэл хүрэлцэхгүй бол Дотоодын цэргийн туслалцаа авна.

15 дугаар зүйл. Хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

1. Хуульд заасан журмын дагуу жагсаал, цуглаан зохион байгуулахад санаатайгаар саад учруулсан, жагсаал, цуглаанд оролцсоных нь төлөө иргэнийг мөрдөн мөшгөсөн, эрх чөлөөг нь хязгаарласан, аливаа хэлбэрээр гадуурхсан этгээлд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 1000—25000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

2. Энэ хуулиар хориглосон газарт, түүндэн зөвшөөрөгдөөгүй буюу зөвшөөрөл авалгүйгээр жагсаал, цуглаан зо-

хион байгуулсан, эсхүл жагсаал, цуглааны явцад түүний зорилгыг өөрчилж энэ хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт хориглосон жагсаал, цуглаан зохион байгуулсан улс төрийн нам, олон нийтийн байгууллагад 25000 хүртэл төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хууль бус жагсаал, цуглааныг зохион байгуулсан гэм буруутай зохион байгуулагчид эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 10000—25000 төгрөгөөр торгох, эсхүл 14—30 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл ногдуулна.

4. Энэ хуулийн 8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн заалтыг зөрчиж өлсгөлөн зарлахыг уриалсан буюу зохион байгуулсан гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 10000—25000 төгрөгөөр торгох, эсхүл 14—30 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл ногдуулна.

5. Энэ хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 4, 6 дахь заалтыг зөрчсөн гэм буруутай этгээдэд 15000 хүртэл төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

6. Энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 5 дахь заалтыг зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 10000—25000 төгрөгөөр торгох, эсхүл 14—30 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл ногдуулна.

7. Жагсаал, цуглааныг энэ хуульд заасан журмын дагуу албадан тараах явцад хүч хэрэглэх буюу бусад хэлбэрээр эсэргүүцэл үзүүлсэн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 10000—25000 төгрөгөөр торгох, эсхүл 14—30 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл ногдуулна.

8. Энэ зүйлийн 1—7 дахь хэсэгт заасан шийтгэлийг шүүгч шийтгэврээр ногдуулна.

9. Жагсаал, цуглааны явцад хүний амь нас, эрүүд мэнд, бусдын өмч хөрөнгөд учруулсан хохирол, түүнчлэн энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу жагсаал, цуглааныг албадан тарааснаас иргэд, байгууллагад учирсан хохирлыг жагсаал, цуглааныг зохион байгуулсан байгууллага, зохион байгуулагч, оролцогч тус тусын гэм буруутгийн хэмжээгээр хариуцаж бүрэн арилгана.

10. Жэгсвэл, цуглааныг хууль бусаар тархсан болон хууль бусаар зөвшөөрөл багтоогүйгээс зохион байгуулагч, оролцогч, байгууллага, иргэдэд учирсан хохирлыг тэр хариуцна.

11. Жэгсвэл, нутгааны үеэр нийгмийн хэв журам зөрчсөн, эмх замбараагүй байдал бий болгосон, хүний амь нас, эрүүл мэнд, бусдын өмч хөрөнгөд хохирал учруулсан этгээдэд хуульд заасан тохиолдолд эрүүгийн болон бусад хариуцлага хүлээлгэнэ.

Монгол Улсын Их Хурал
дарга

Н. БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1994 оны 06 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 51

Улаанбаатар
хот

**Ж. ЧОЙЖАНЦАНГ ҮНДСЭН ХУУЛИЙН
ЦЭЦИЙН ГИШҮҮНИЙ ҮҮРЭГТ АЖЛААС
ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ**

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1993 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 97 дугаар зарлигаар Улсын ерөнхий прокурорын орлогчоор томилогдсон Жамцын Чойжанцанг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүний үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

Дарга

Н. БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1994 оны 06 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 52

Улаанбаатар
хот

**ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН
ДҮГНЭЛТИЙН ТУХАЙ**

Шүүх байгуулах тухай хуулийн 2 дугаар зүйлийн 3 дэх хэсгийн «Багануур, Багахангай дүүргийн шүүх, Баянзүрх, Гачуурт дүүргийн шүүх, Сонгинохайрхан, Жаргалант дүүргийн шүүх, Хай-уул, Туул дүүргийн шүүх» гэсэн 1, 3, 5,

7 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэхийг хянан үзэхийг хүссэн иргэн Ж. Баярсайханы өргөдлийг хянан хэлэлцээд гаргасан Үндсэн хуулийн цэцийн 1994 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн дүгнэлтийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Шүүх байгуулах тухай хуулийн 2 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 1, 3, 5, 7 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн тухай Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

Дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛЫН
ТОГТООЛ

1994 оны 06 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 53

Улаанбаатар
хот

ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН
НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАНТАЙ
ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА
ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхийн хугацаа 2 жил болсонтой холбогдуулан сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч сонгох баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлыг энэ оны 10 дугаар сард багтаан явуулахаар тогтоосугай.

2. Хуулиар иргэдийн Хурлын Төлөөлөгчдийн тоо нь нэмэгдэж байгаа аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийг гүйцээн сонгох арга хэмжээг 1994 онд баг-

гаан явуулахыг холбогдох аймгийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд зөвшөөрсүгэй.

3. Шинээр байгуулсан Дархан уул, Орхон, Говьсүмбэр аймаг болон тэдгээрийн сумууд, Дорноговь аймгийн Замын-Үүд, Хөвсгөл аймгийн Хайх сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг байгуулах Засаг дарга нарыг томилж, тэдгээрийн Тамгын газрыг эмхлэн байгуулах ажлыг энэ оны 8 дугаар сард багтаан зохион байгуулахыг Засгийн газарт даалгасугай.

4. «Аймаг, сум байгуулах тухай» Монгол Улсын Их Хурлын 1994 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн 32 дугаар тогтоолын 10, «Сум байгуулах тухай» 1994 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн 34 дүгээр тогтоолын 4 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Дарга

Н. БАГАБАНДИ

1994 оны 06 дугаар сарын 28-ны өдөр

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛЫН
ТОГТООЛ**

1994 оны 06 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 54

Улаанбаатар
хот

**Р. ОДОНБААТАРЫГ БАЙНГЫН ХОРООНЫ
ГИШҮҮНЭЭР БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын гишүүн Рэнчинсэмбуугийн Одонбаатарыг Төсөв, санхүү, мөнгө, зээлийн бодлогын байнгын хороо, Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн бодлогын байнгын хорооны гишүүнээр тус тус баталсугай.

2. Энэ тогтоолыг 1994 оны 6 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛЫН
ТОГТООЛ

1994 оны 6 дугаар

сарын 30-ны өдөр

Дугаар 55

Уаллибаатар

хот

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ
ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ХЭСЭГТ ТАВЬСАН
ХОРИГИЙН ТУХАЙ

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим хэсэгт тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн дорлгийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 177 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн «Аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч анхан шатны шүүхийн хуулийн хүчин төгөлдөр шийдвэрт,» гэсэн заалт, мөн зүйлийн 3 дахь хэсгийн «Аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч эсэргүүцлээ хяналтын журмаар хянан хэлэлцэхээс өмнө,» гэсэн заалт, 178 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 179 дүгээр зүйл, 184 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1994 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн хоригийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

2. Энэ тогтоолыг 1994 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

1994 оны 06 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 56

Улаанбаатар
дот

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ
БАЙДЛЫН БОЛОН ГАДААД БОДЛОГЫН
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, ЦЭРГИЙН НОМЛОЛ
БАТЛАХ, НИЙТЛЭХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал, Монгол Улсын цэргийн номлолыг 1, 2, 3 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал, Монгол Улсын цэргийн номлолын хэвлэлд тавих найруулгыг «Улсын нууцын тухай» Засгийн газрын 1991 оны 206 дугаар тогтоолд нийцүүлэн боловсруулж төрийн төв хэвлэлд нийтлэхийг Улсын Их Хурлын Тамгын газарт даалгасугай.

Дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

1. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

1. Монгол Улсын Үндсэн хууль нь Монгол Улсын ард иргэд, нийгмийн бүх хэсэг бүлгийн нийтлэг ашиг сонирхлын цогцолсон илэрхийлэл мөн.

2. Монгол Улсын үндэсний аюулгүй байдал (цаашид «үндэсний аюулгүй байдал» гэх) гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод талтай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ. Үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогын үзэл бодлын үндэс нь эх оронч үндэсний үзэл байна.

3. Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолд монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй дархан байдал, эдийн засгийн харьцангуй бие даасан байдал, экологийн тэнцвэрт хөгжил, үндэсний эв нэгдэл багтана. Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхол нь төр, ард түмний онцгой анхлалд хамгаалалтад байна.

4. Үндэсний аюулгүй байдлыг хангах гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хамгаалан бэхжүүлж тал бүрийн баталгаад буй болгоход чиглэсэн төрийн бодлого, төр, түүний байгууллага, албан тушаалтнаас авч буй, иргэдээ хэрэгжүүлж буй арга хэмжээг хэлнэ. Эдгээр арга хэмжээ нь урьдчилан сэргийлэх, бүтээн байгуулах чиг хандлагатай байна. Монгол Улс нь эдийн засаг, соёл, шинжлэх ухаан-технологи, боловсрол зэрэг салбарт олон улсын хэмжээнд өрсөлдөх чадвартай байхыг чухалчилна.

Нэг. Үндэсний аюулгүй байдлын бүтэц

5. Үндэсний аюулгүй байдал нь дараахь үндсэн хэсгээс бүрдэнэ:

- 1) Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдал,
- 2) нийгэм-төрийн байгууллын аюулгүй байдал,
- 3) иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал,

- 4) эдийн засгийн аюулгүй байдал,
- 5) шинжлэх ухаан, технологийн аюулгүй байдал,
- 6) мэдээллийн аюулгүй байдал,
- 7) монгол соёл иргэншлийн аюулгүй байдал,
- 8) хүн ам, удмын саягийн аюулгүй байдал,
- 9) экологийн аюулгүй байдал,

Хоёр. Үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлүүд

6. Үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлийг эх сурвалжаар нь дотоод, гадаад, цаг хугацааны хувьд гэнэтийн, тодорхой хугацааны, түүхэн нэгэн үеийн, мөнхийн гэж тус тус ангилна. Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхол нь мөнхийн ангиллын ашиг сонирхол мөн.

7. Үндэсний аюулгүй байдалд сөрөг нөлөөлж болох хүчин зүйлийг шинж чанарын үүднээс объектив, субъектив; учруулах аюулын магадлалаар нь бодит болон болзошгүй гэж тус тус ангилна. Үндэсний аюулгүй байдлыг хангах, бэхжүүлэх бодлого нь аливаа аюулыг «болзошгүй» үед нь тодруулан тогтоож арилгах, субъектив аюулыг цаг тухайд нь арилгах замаар объектив аюулыг багасгах, урьдчилан сэргийлэхэд чиглэнэ.

8. Үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх гадаад хүчин зүйл:

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал нь олон улсын аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг мөн бөгөөд түүнээс шууд хамаарна. Улс төрийн орон зайн хувьд аюулгүй байдлыг дэлхийн, бүс нутгийн, салбар бүс нутгийн гэж ангилна.

9. Үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх дотоод хүчин зүйл:

Үндэсний аюулгүй байдлыг дотоод орон зайгаар нь улсын, бүсийн, аймаг, нийслэлийн, сум-нутгийн гэж ангилна.

Гурав. Үндэсний аюулгүй байдлыг хангах арга зам, баталгаа

10. Үндэсний аюулгүй байдлыг нийгэм, улс төр, дохион байгуулалт, эдийн засаг, дипломат, нэрэг, тагнуул, хууль зүйн аргаар дангаар буюу олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар хангана.

11. Үндэсний аюулгүй байдлыг хангах үндсэн арга хэрэгсэл нь баттай мэдээлэл, нарийн судалгаа, тооцооны үнд-

сэн дээр үйл явдлын өрнөлт, хөгжлийг урьдаас харж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах явдал мөн.

12. Үндэсний аюулгүй байдлын үндсэн баталгаа нь монголын ард түмэн өөрөө, Монгол Улсын төр мөн.

13. Үндэсний аюулгүй байдлын олон улсын баталгаа нь улс төр, хууль зүй, ёс суртахуун-сэтгэл зүйн баталгаанаас бүрдэнэ. Олон улсын баталгааг дангаар, хоёр болон олон талын арга хэмжээг хослуулан авах замаар буй болгож бэхжүүлнэ. Цэрэг-улс төрийн аюулгүй байдлын баталгааг хамтын хүчээр аюулгүй байдлыг хангах тогтолцоо бүрдүүлэх, оролцох замаар хангана.

Дөрөв. Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо

14. Үндэсний аюулгүй байдлыг хангах үүргийг Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, түүний тэргүүлсэн Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газар, хууль сахуулах болон төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагууд гүйцэтгэнэ.

15. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагууд нутгийн өөрөө удирдах байгууллагууд нь энэхүү үзэл баримтлалын үзэл санааг Монгол Улсын Үндсэн хууль, хууль тогтоомж болон эрх зүйн бусад колбогдох актаар бэхжүүлж, тус тусын эрх хэмжээний дотор хэрэгжүүлэх үүрэгтэй.

16. Улс төр, олон нийтийн байгууллагууд болон иргэд Үндэсний аюулгүй байдлыг хангах тухай хууль тогтоомж, энэхүү үзэл баримтлалыг чанд мөрдлөг болгож, тэдгээрийг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцоно.

17. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл тухайн үеийн байдлыг харгалзан энэхүү үзэл баримтлалыг хэрэгжүүлэх стратеги, тактикийг уялдуулан зохицуулах үүргийг хүлээх бөгөөд үндэсний аюулгүй байдал хэрхэн хангагдаж байгаад хяналт тавьж, Улсын Их Хуралд жил бүр мэдээлж байна.

18. Үзэл баримтлалыг хэрэгжүүлэх арга хэмжээг тухайн байгууллагууд өөрсдийн төсөвт тусгаж гүйцэтгэнэ. Тусгай арга хэмжээ авах нөхцөлд зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

Тав. Үндэсний аюулгүй байдлын мэдээллийн сан

19. Үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн бодлогыг уялдуулан зохицуулах, хэрэгжүүлэхэд шаардагдах бүх төр-

лийн мэдээллийг холбогдох эрх бүхий байгууллага, иргэд, гадаадын эх сурвалжаас олж авах бөгөөд мэдээллийн нэгдсэн санг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дэргэд байгуулна.

II. Монгол улсын оршин тогтнохын аюулгүй байдал

20. Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдал гэж Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй дархад байдал хангагдсаныг хэлнэ.

21. Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөөлж болох гадаад хүчин зүйлүүд:

1) аливаа улс, хүчин Монгол Улсын эсрэг зэвсэгт түрэмгийлэл үйлдэх буюу үйлдэхээр заналхийлэх;

2) Монгол Улсын төрийн тусгаар тогтнолыг хүчээр өөрчлөх, ард түмний үндэсний эв нэгдлийг сарниулах бодлого явуулах;

3) олон улсын эрх зүйн дагуу бусад улстай чөлөөтэй харьцахад саад хийх, дарамт шахалт үзүүлэх;

4) Монгол Улс, түүний ард иргэдийн эсрэг алаан хлдах, хорлон сүйтгэх, тагнаа турших үйл ажиллагаа явуулах, зохион байгуулах буюу тийнхүү үйл ажиллагаа явуулалыг өдөөн турхирах, туслах;

5) аливаа улс гүрэн өөрийн ашиг сонирхол, үзэл бодлыг Монгол Улсад хүчээр тулгах, маргааныг хүч хэрэглэх замаар шийдвэрлэхийг оролдох;

6) Монгол Улсыг улс төр, цэрэг, эдийн засаг, үзэл бодлын хувьд эрхшээлдээ оруулах;

7) дэлхий дахин, бүс нутаг буюу саалбар бүс нутагт манай улс оронд нөлөөлөхүйц зөрчил хямрал үүсч дайнд таагдан орох;

8) Монгол Улсын эдийн засгийг тогтворгүй болгох, төрийн эргэлт гаргуулахаар завдах буюу хийх, бусад улс орны эсрэг бодлого, үйл ажиллагаандаа түшиц болгон ашиглах;

9) улсын хилийг өөрчлөх, хууль бусаар хил нэвтрэх, хилийн зөрчил гаргах;

10) хил залгаа орнуудын хоорондын зөрчил тэмцэл, мөргөлдөөнд таагдан орох, тэдгээрийн дотоод зөрчил, хямралын уршигт нэрвэгдэх;

11) хөрш орноос дүрвэгсэд олноор орж ирэх;

12) байгаль, экологийн гай гамшиг гарах, хүн ба амьтны гоц халдварт өвчин гарч тархах.

22. Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөөлж болох дотоод хүчин зүйлүүд:

1) төрт ёс алдагдах, Монгол Улсыг бусад улсад дагаар оруулах явуулга, оролдлого хийх;

2) үндэсний эв нэгдлийг сарниулах, Монгол Улсын тусгаар тогтносон байдлыг алдагдуулах улс төр, эдийн засаг, цэргийн бодлого явуулах;

3) шашин, үндэс угсаа, нутаг орны хурц маргаан, зөрөлдөөн гарах нөхцөл байдал бий болох;

4) Монгол Улсын хүчин чадлыг сулруулах хорлон сүйтгэх, тагнай турших ажиллагаа явуулах;

5) зэвсэгт хүчин, бусад цэрэг дотроо хуваагдах, түүний байлдах чадвар, цэрэг-эх оронч үзэл алдагдах, цэрэг-иргэний талцад маргаан, зэвсэгт үйжээн, мөргөлдөөн гарах.

23. Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдлыг хангах арга зам;

Нэг. 1) аливаа улстай харилцахдаа орчин үеийн олон улсын эрх зүйн түгээмэл зарчмуудыг сахих, бусдаар сахуулах;

2) олон улсын энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн Нэгдсэн Үндэстний Байгууллага, олон улсын бусад байгууллагын үйл ажиллагааг дэмжиж, нягт хамтран ажиллах;

3) Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрмийн 51 дүгээр зүйлийн дагуу улс орноо түрэмгийллээс дангаараа буюу хамтын хүчээр хамгаалах эрх зүйн үндсийг хоёр болон олон талын шугамаар бүрдүүлэн баталгаажуулах;

4) Ази, Номхон далайн бүс нутаг, ялангуяа Зүүн-хойд Ази, Төв Азид стратегийн тогтвортой байдлыг хангах, энх тайвныг бэхжүүлэх, аюулгүй байдлын найдвартай тогтолцоог бий болгох бодлого явуулах;

5) нутаг дэвсгэрээ бусад улс орны эсрэг ашиглуулахгүй байх бодлогыг тууштай баримтлах, Монгол Улсын нэмийн зэвсэггүй бүсний статусыг олон улсын хэмжээнд баталгаажуулж, аюулгүй байдлаа улс төрийн аргаар бэхжүүлэх чухал тулгуур болгох, Төв Азийг нөмийн зэвсэггүй бүс болгох чиг баримтлах;

6) Монгол Улсын үндэсний натуур ашиг сонирхлыг хөндсөн, түүнд харшилсан болон Монгол Улсын нэр хүндийг гутлахад чиглэсэн аливаа явууллагад цаг тухайд нь

үндэслэл бүхий ишцаалт өгч, шаардлагатай гэж үзвэл төрийн бодлого, үйл ажиллагаандаа зохих ёсоор тусгаж байх;

7) гадаад улс оронтой харилцах нэг чухал суваг болох «ардын дипломат» бодлогыг өргөнөөр ашиглаж Монгол Улсыг мэддэг, дэмждэг уур амьсгалыг бусад улс оронд, нэг ялангуяа хөрш зэргэлдээ болон нөлөө бүхий улс оронд буй болгох;

8) Монгол Улсад оршин суух гадаадын иргэд, харьяалаагүй хүмүүсийн тоо, тэдний зорчин явах журмыг хуульчлан тогтоож, хяналт тавих. Монгол Улсад хууль бусаар оршин суух явдлыг гаргуулахгүй байх хяналтын тогтолцоотой болгох;

Хоёр: 1) Монгол Улс бусад улс орон, олон улсын байгууллагуудтай цэргийн салбарт хамтран ажиллаж, өөрийгөө бодлоцгүй түрэмгийлдээс урьдчилан сэргийлэх, хамтын хүчээр батлан хамгаалах бодлогодоо хөрш зэргэлдээ, гурав дахь улс гүрэн, Нэгдсэн Үндэстний Байгууллагын болон олон улсын бусад нэгдсэн зэвсэгт хүчнийг ашиглах чиг баримтлах;

2) улс орны тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хамгаалах чадвартай үндэсний зэвсэгт хүчин, бусад нэрэгтэй байх;

3) Монгол Улс өөрийгөө батлан хамгаалах зорилгоо бүх нийтийн батлан хамгаалах тогтолцоонд тулгуурлан өөрийгөө хамгаалах цэргийн номлолын дагуу хэрэгжүүлэх. Түрэмгийлэл, зэвсэгт халдлагаас гагцхүү өөрийн хүчинд тулгуурлан хамгаалахад хүрвэл өөрийгөө хамгаалах дайн явуулж, түүнд догоодод байгаа бүх хүч арга хэрэгсэл, гадаад хүчин зүйлийг өргөнөөр ашиглах;

4) цэргийн салбарт итгэлцлийг бэхжүүлэх, бүс нутгийн аюулгүй байдлыг хангах механизм буй болгох олон улсын хүчин чармайлт, хамтын ажиллагаанд бодолцооныхоо хэрээр оролцох.

III. НИЙГЭМ-ТӨРИЙН БАЙГУУЛЛЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

24. Нийгэм-төрийн байгууллын аюулгүй байдал гэж Монгол Улсын Үндсэн хуулиар бататгасан төр, нийгэм-эдийн засгийн тогтолцоо, төрийн үйл ажиллагааны үндсэн зэрчмууд, түүнчлэн хүний эрх, эрх чөлөө баталгаажсан байдлыг хэлнэ.

25. Нийгэм-төрийн байгууллын аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөөлж болох гадаад хүчин зүйлүүд:

1) Монгол Улсын төр, нийгэм, эдийн засгийн тогтолцоог буснуулахад чиглэсэн бодлого явуулах;

2) Монгол Улсын төрийн байгууламжийн нэгдмэл байдлыг алдагдуулах зорилгоор үндэс үгсээ, нийгмийн хэсэг, бүлэг, төрийн удирдлагыг хагаралдуулах, ард түмний үндэсний эв нэгдлийг саринуулах буюу чингэхийг оролдох;

3) төрийн нууц, түүний дотор цэргийн болон технологийн нууц алдагдах;

4) гадаадын тусгай албад, тэдний төлөөний хүмүүсийн зүтгээс тагнаа турших үйл ажиллагаа явуулах.

26. Нийгэм-төрийн байгууллын аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөөлж болох дотоод хүчин зүйлүүд:

1) Үндсэн хуулиар тогтоосон Монгол Улсын бүрэн эрхт байдал алдагдах;

2) төрийн эрх мэдлийг хууль бусаар авах, авахаар авдах;

3) өмчийн хэлбэрүүдийн тэгш байдал алдагдаж, өмчлөгчийн эрх зөрчигдөх;

4) төрийн байгууллага шашиг, сүм хийд төрийн хэрэгт үл оролцох зарчим алдагдах;

5) Монгол Улсын төрийн эрх мэдлийг хуваарилал зарчим алдаглах;

6) үзэл бодол, үндэс үгсээ, сүсэг бишрэл, нутаг усанраа явцууран бүлгэрхэх, талцах, төрийн удирдлагын дотор үндэсний аюулгүй байдлын асуудлаар зөрчил гаргах;

7) улс орны батлан хамгаалах чадвар, ард түмэн-цэргийн холбоо сулрах;

8) нийгэмд хууль ёс, дэг журам саяилга, хариуцлага суларч, эмх замбараагүй байдал бий болох, төрийн удирдлага, сонор сэрэмж суларч, төрийн нууц алдагдах;

9) хээл хахууль газар авч гэмт хэрэг зохион байгуулалтын шинжтэй болох;

10) стратегийн болон улсын нөөц шаахагдах, өлсгөлөн, байгалийн нойтой гамшигт нэрвэгдэх, хүн амыг олноор дөвөөх өвчин гарах.

27. Нийгэм-төрийн аюулгүй байдлыг хангах арга зам:

Нэг: 1) Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл санаа, зарчим, заалтуудад нийцсэн хууль тогтоомж гарган тууштай мөрдөх;

2) улс төрийн нам, хөдөлгөөнүүдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах улс төрийн механизм буй болгох;

3) төрийн дээд удридагыг үндэсний ашиг сонирхолд харш аливаа нөлөөнд автагдуулахгүй байх нөхцөл бүрдүүлж, сэргийлэн хамгаалах;

4) үндэсний аюулгүй байдлын үүднээс хуулиар хориглосноос бусад тохиолдолд төрийн үйл ажиллагааг ард олонд ил тод болгох.

Хоёр: 1) Монгол Улс гадаад харилцаандаа улс төрийн бодит байдлаас хандах, үндэсний язгуур ашиг сонирхол, үндэсний ашиг сонирхлоо дээдлэх, олон түнштэй байх, тууштай зарчимч байх бодлого явуулах.

Үндэсний язгуур ашиг сонирхолд аюул занал учраагүй нөхцөлд Монгол Улс эвсэлд үл нэгдэх бодлого явуулах.

Монгол Улсын ашиг сонирхол бусад улсын ашиг сонирхолтой харшилдах нөхцөлд Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг харгаалзан уян хатан шийдвэрлэж байх;

2) Монгол Улс хөрш хоёр оронтой харилцах асуудалд тэргүүн зэргийн ач холбогдол өгч, тэнцвэртэй харилцах зарчим баримтлах. Тэнцвэртэй харилцана гэж адил зай барих, бүх асуудлаар адил байр суурьтай байхыг бус, харин хоёулантай нь итгэлцлийг бэхжүүлэх, сайн хөршийн найрсаг харилцаа, харилцан ашигтай хамтын ажиллагааг бүх талаар хөгжүүлэх бодлогыг хэлнэ. Эдгээр оронтой харилцахдаа хөрш орнуудаас Монгол Улсын үндэсний ашиг сонирхол, нэн ялангуяа үндэсний язгуур ашиг сонирхлын талаар баримталж буй бодлогыг зохих ёсоор харгаалзан тусгаж байх, Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хөндөөгүй хөрш хоёр орны маргаанд эс оролцож төвийг сахих бодлого баримтлах;

3) нээлттэй гадаад бодлого явуулах. Олон улсын энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх, хамтын ажиллагааг хөгжүүлэх асуудлаар нөлөө бүхий улсуудтай зөвлөлдөж байх чиг баримталж, улс орныхоо стратегийн ач холбогдлыг нэмэгдүүлэх, нөлөө бүхий улсуудын стратегийн сонирхлыг Монголд буй болгох бодлого явуулах;

4) хөгжиж буй, далайд гарцгүй бусад улс оронтой харилцахдаа нийтлэг ашиг сонирхлоо олон улсын тавиназ хамтран хамгаалах, хэрэгжүүлэх чиг баримтлах.

IV. Иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал

28. Иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал гэж бие хүн өөрийн хийгээд эх орон, эрд түмнийхээ ашиг сонирхлын төлөө биеийн болон оюуны хүч чадвхиа бүрэн зориулах, олон улсын гэрээний дагуу хүний эрхийн асуудлаар Монгол Улсын хүлээсэн үүрэг хэрэгжих нөхцөл бүрдсэн байдлыг хэлнэ.

29. Иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөөлж болох гадаад хүчин зүйлүүд:

1) бусад улсын ивуулга, дарамт шахаалтын улмаас Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдон баталгаажоог буй ардчилал, шударга ёс, тэгш байдал, иргэдийн эрх, эрх чөлөө зөрчигдөх;

2) үндэс угсаа, шашин шүтлэг үзэл бодлын ялгаа эергээр хүн амын дотор, иргэдийн хооронд янз бүрийн арга хэлбэрээр эв нэгдлийг саринулах;

3) гадаадад алба, амины ажлаар явж байгаа, гадаадад байгаа буюу түр оршин суугаа Монгол Улсын иргэдийн эрх, эрх чөлөө хялгарлагдах, зөрчигдөх, эрх тэгш байдал алдагдах;

4) гадаадын байгууллага, албад элдэв амлалт, явуулга, ухуулгаар Монгол Улсын иргэнийг өөрийн эрхшээлд оруулах, Монгол Улсын ашиг сонирхолд харшилсан зорилгод яшиглах;

5) хоёрдмол харьяалал үүсч төрөөс иргэдийн ашиг сонирхлыг хамгаалах баталгаа алдагдах.

30. Иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөөлж болох дотоод хүчин зүйлүүд:

1) Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, түүнчлэн Монгол Улсын нэгдэн орсон буюу байгуулсан олон улсын гэрээ, конвенцид заагдсан хүний эрх ноцтойгоор зөрчигдөх;

2) Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжоор олгогдсон Монгол Улсын иргэдийн эрх, эрх чөлөөг хангахуйц улс төр, эдийн засаг, ниймийн болон бусад бодит баталгаа эс бүрдэх буюу алдагдах;

3) нийгэм, эдийн засгийн байдлын улмаас иргэдийн эх оронч сэтгэлгээ алдагдах;

31. Иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдлыг хангах арга зам:

1) Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон Монгол Улсын иргэдийн тодорхой эрх, эрх чөлөөг хууль тогтоомжоор баталгаажуулах;

2) хүний эрх, эрх чөлөөг бататган хамгаалсан олон этгээдийн гэрээ, конвенцид нэгдэж орохын зэрэгцээ өөрийн иргэдийн ашиг сонирхлыг хамгаалсан хоёр талын гэрээ, хэлэлцээр байгуулах;

3) гадаадад аялж, ивж байгаа Монгол Улсын иргэдэд тэдний эрх, үүргийн талаар эрхээ мэдэж хамгаалах талаар мэдээлэл өгдөг механизм буй болгохын дээр гадаадад суугаа Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газрын иргэдийнхээ эрхийг хамгаалах үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх;

4) улс төрийн хэлмэгдүүлэлтийн учир шалтгааныг тодотгон тогтоож, хэлмэгдэгсдийг цагаатгах, ниймэрхүү эмгэ-нэлт явдал үл давтагдах улс төр, эрх зүйн баталгааг буй болгох;

5) хүний эрх, эрх чөлөөг хамгаалах Засгийн газрын бус тогтолцооны үйл ажиллагааг дэмжих;

6) гоц халдварт өвчин гарах, Монгол Улсын хүн амын нас хүйс, нийт бүтцийн харьцаа алдагдах зэрэг хүн ам, үндэс угсаанд аюул занал учрах нөхцөлд хүний эрх, эрх чөлөөнд хуульд заасны дагуу зохих хязгаарлал тогтоож болно;

7) хоёрдмол харьяаллыг үүсгэхгүй байх хууль гаргах, олон улсын гэрээ хэлэлцээр байгуулах;

8) иргэд болон гадаадын хүмүүс эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ бусдын эрх, эрх чөлөөнд халдах, бусдыг хохироох, мөн түүнчлэн улс орны аюулгүй байдал, үндэсний язгуур ашиг сонирхолд хохирол учруулж үл болно.

V. Эдийн засгийн аюулгүй байдал

32. Эдийн засгийн аюулгүй байдал гэж дотоод нөөц бололцоогоо ашиглан нөхөн үйлдвэрлэл явуулах, ард түмнийхээ хэрэгцээг хангах, тусгаар тогтносон байдлаа бэхжүүлэх эдийн засгийн чадавхитай байх, шаардлагатай нөхцөлд улс орноо тодорхой хугацаагаар тэтгэж чадах эдийн засгийн бүтэц бүрдсэн байдлыг хэлнэ.

Эдийн засгийн аюулгүй байдал нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын тулгуур үндэс мөн.

33. Эдийн засгийн аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөөлж болох гадаад хүчин зүйлүүд:

1) гадаад худалдаа-эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх боломж хязгаарлагдах буюу хаагдах;

2) бусад улс орны түүхий эдийн хавсарга болох;

3) стратегийн ач холбогдол бүхий экспортын барааны үнэ унах, зах зээл үгүй болох;

4) эдийн засгийн стратегийн ач холбогдол бүхий салбарт нэг улсаас шууд хараат болох;

34. Эдийн засгийн аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж болох дотоод хүчин зүйлүүд:

1) экологийн бодлого алдагдаж, ус, ой мод, хөдөө аж ахуйн эдэлбэр газрын хэмжээ багасах;

2) бүс нутгийн хөгжлийн ялгаа гүнзгийрэх, эдийн засгийн тэнцвэр алдагдах;

3) монгол малын удмын сан, үр тарианы нутагшмал сөрт хомсдох;

4) гаалийн бодлого алдагдаж, Монгол Улс, ард түмний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй эд зүйлс орж ирэх, төсвийн орлогын эх үүсвэр багасах, үндэсний үйлдвэрлэлд сөргөөр нөлөөлөх;

5) улсын урсгал төсвийн алдагдал өсөх, Монгол Улсын мөнгөн тэмдэгт-төгрөгийг хамгаалах төрийн бодлого алдагдах;

6) инфляци үсрэнгүй нэмэгдэн төгрөгийн ханш унаж, амьжиргааны доод түвшингээс доогуур орлоготой айл өрхийн тоо олширох;

7) бусад улс буюу олон улсын байгууллагад өртэй болж дарамт шахаат, хараат байдалд орох;

8) гадаадын иргэд, харьяалаагүй хүмүүс Монголд олноороо суурьших, үндэсний мэргэжилтэй боловсон хүчин, ажиллах хүчин олноороо гадаадад цагаачлах;

9) ажилгүйчүүд, түүний дотор хөдөлмөрийн насны хөдөлмөрлөх чадваргүй хүн амын тоо хэт ихсэх.

35. Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах арга зам:

Нэг: Дараахь чиглэлээр төрийн нэгдсэн бодлоготой байх;

— эдийн засгийн бүтцийн өөрчлөлт;

— эдийн засгийн гадаад харилцаа;

— өр төлбөрийн асуудал;

— төсвийн бодлого;

— мөнгөний бодлого;

— шинжлэх ухаан-технологийн бодлого;

— эдийн засгийн тайлан, бүртгэл, мэдээлэл.

Хоёр: 1) эдийн засгийн аюулгүй байдлыг хангахад гүйцэтгэх үүргийг нь хөргалаан дараахь салбаруудыг стратегийн ач холбогдолтой гэж үзэх:

а) үйлдвэрлэлийн салбарт:

- хүнс, хөдөө аж ахуй;
- уул, уурхайн аж үйлдвэр;
- хөнгөн аж үйлдвэр;
- химийн аж үйлдвэр;

б) дэд бүтцийн салбарт:

- эрчим хүч;
- тээвэр;
- холбоо, мэдээлэлжүүлэлт;
- зам тээвэр;

2) дараахь чиглэлээр гадаадын зөрөнгө оруулалтыг дэхүүлэн дэмжих;

- стратегийн ач холбогдолтой салбаруудыг хөгжүүлэх;
- экспортын болон хүнсний нөөцийг нэмэгдүүлэх үйлдвэрлэлийг хөгжүүлэх;
- импортыг ордуулж болох зарим түүхий эд, техникийн эд анги, сэлбэг хэрэгсэл зэргийг дотоодлоо үйлдвэрлэх.

Гурав: Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах төрийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэхэд дараахь чиглэл баримтлах:

1) эдийн засаг, нийгмийн дэд бүтцийг хөгжүүлэх;

2) орон нутаг харьцангуй биеэ даан хөгжих нөхцөлийг бүрдүүлж чадахуйц эдийн засгийн мужлал тогтоон цогцолбороор хөгжүүлэх;

3) экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хянгдалгүй технологийн бүхий үйлдвэрлэл хөгжүүлэх чиг баримтлах;

4) хүн амыг хүнс, өргөн хэрэглээний бараагаар хангах нөөцийг жил бүр тогтоон бүрдүүлж, сэлбэг шинэтгэж байх стратегийн ач холбогдолтой зарим барааг дотоодлоо үйлдвэрлэх;

5) Монгол Уласын валютын гадаад нөөцийг 200с доошгүй сарын нийт импорттой тэнцэх хэмжээнд байлгах;

6) монгол малын удмын сан, үр тарианы нутагшмал сортыг хамгаалах;

7) дэлхийн улс орнуудтай худалдаа-эдийн засгийн харилцаа хөгжүүлэхдээ эдийн засагт, нэн ялангуяа стратегийн ач холбогдолтой салбарт нэг буюу хэсэг орны ноёрхол

тогтох, хараат байдалд орох, түүхий эдийн хавсарга болохоос сэргийлэх, Манай улстай чөлөөтэй харилцах сонирхлыг өндөр хөгжилтэй, нөлөө бүхий улс орнуудад буй болгох;

8) Монгол Улсын далайд гарах эрхийг олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр баталгаажуулах;

9) эдийн засгийн аюулгүй байдалаа хангах үүднээс хөрш орнууд, өрнө, дорнын өндөр хөгжилтэй орнуудтай хоёр болон олон талын худалдаа-эдийн засгийн эрх тэгш, харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, бүс нутгийн худалдаа-эдийн засгийн сүлжээнд өөрийн байр суурьтай болох;

10) нэг орноос авах стратегийн ач холбогдолтой түүхий эд, тоног төхөөрөмж, мэргэжилтэн, ажилчдын тоо хэмжээг үндэсний аюулгүй байдалд нөлөөлөхөөргүй байх хэмжээнд байлгах;

11) гадаад орны хөрөнгө оруулагчдад үзүүлэх аливаа хөнгөлөлт, тэдний эдийн засгийн сонирхлыг хамгаалах арга хэмжээг монголын үндэсний үйлдвэрлэгчид, хөрөнгө оруулагчдад үзүүлдэг хөнгөлөлт, эдийн засгийн нөхцөлөөс давуутай болохоос сэргийлж, хяналт тавих;

12) гадаад улс, олон улсын байгууллагуас авах зээлийн хэмжээг түүнийг төлөх хугацааны төлбөрийн боломжоос хэтрүүлэхгүй байлгах;

13) 1990 оноос өмнө авсан зээл, зээлийн хүүгийн төлбөрийг өөрийн болон зээлдүүлэгч орны ашиг сонирхол, өр анх буй болсон шалтгааныг харгалзан олон улсын жишгийн дагуу шийдвэрлэх;

14) гадаад худалдаанд экспортыг нэмэгдүүлэх бодлого явуулахдаа боловсруулалт буюу эцсийн боловсруулалт хийсэн бүтээгдэхүүн гаргах;

VI. Шинжлэх ухаан, технологийн аюулгүй байдал

36. Шинжлэх ухаан, технологийн аюулгүй байдал гэж өөрийн орны экологийн өвөрмөц нөхцөлд технологи болон мэдээлэл судалгааг улс орныхоо хөгжилд ашиглах, шинжлэх ухааны үндэсний чадамжийг дээшлүүлэх, оюуны үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг хангасан нөхцөлт байдлыг хэлнэ.

37. Шинжлэх ухаан, технологийн аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөөлж болох гадаад хүчин зүйлүүд;

1) улс орны хөгжлийн стратегийн эр холбогдол бүхий үйлдвэрлэлийн салбар нэг орны технологийн хараат байдлаартай болох;

2) шинжлэх ухаан, технологийн хөгжлөөс хойрох.

38. Шинжлэх ухаан, технологийн аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөөлж болох дотоод хүчин зүйлүүд:

1) шинжлэх ухаан, технологийн хөгжлийн төрийн нэгдсэн бодлого дутагдах;

2) түүхэн хөгжлийн явцад шалгарч буй боловч монгол үндэсний технологи алдагдах;

3) Монгол орны өнөөрмөц шинж чанартай технологи, хүн, аргамал, мал амьтны генофондын судалгаа, мэдээлэл төрийн хамгаалалтын гэднэ орхигдох, шинжлэх ухаан, технологийн нууц алдагдах;

4) эдийн засаг, эрх зүйн талтай нөхцөл, баталгаа бүрдээгүйн улмаас дэлхийн шилдэг технологи нэвтрэхгүй байх;

5) орчин үеийн шинжлэх ухаан, технологийн ололт нэвтрээгүйгээс болж үндэсний техник, технологи өрсөлдөх чадвараа алдаж хойрогдох;

6) үндэсний оюуны чадавхи, мэргэжилтэй боловсон хүчнийг улс орондоо бүрэн ашиглаж чадахгүй байх;

7) шинэ, шинэчлэгдсэн технологийг үйлдвэрлэлд ашиглах боломж, нөхцөл бүрдэхгүй байх.

39) Шинжлэх ухаан, технологийн аюулгүй байдлыг хангах арга зам:

1) шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, тэргүүлэх чиглэлийг тогтоож, үндэсний орлогын 3 хувиас доошгүй шинжлэх ухааны арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулах;

2) эрдэм шинжилгээний ажлыг хөхүүлэн дэмжих, шинжлэх ухааны нээлт, оюуны бүтээлийг баталгаажуулах, гадны технологийг монголын нөхцөлд тохируулан нэвтрүүлэх эрх зүйн баталгааг бүрдүүлэх;

3) байгалийн баялаг, хүнс, хөдөө аж ахуйн түүхийг ашиглах монголын нөхцөлд тохирсон технологийг боловсруулж нэвтрүүлэх;

4) шинжлэх ухаан, технологийн мэдээллийн үндэсний нэгдсэн сүлжээ, сантай болж, төрийн хамгаалалтад байлгах;

5) шинжлэх ухаан, техникийн ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, үйлдвэрлэлийн технологийг хөгжүүлэхэд чиглэсэн шударга өрсөлдөөнийг дэмжих.

Шинжлэх ухаан, технологийн үндэсний ач холбогдолтой судалгаа, шинжилгээний ажлыг хөгжүүлэх, технологийн шинэ шийдэл боловсруулах, үр дүнг үйлдвэрлэл, практикт нэвтрүүлэхэд амжилт гаргаж буй хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагад албан татварын хөнгөлөлт үзүүлэх, хөнгөлттэй зээл тэргүүн ээлжинд олгодог зарчим баримтлах;

6) шинжлэх ухаан технологийг хөгжүүлэхэд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх замаар шинжлэх ухаан, технологийн өрсөлдөх, хөгжих чадварыг бэхжүүлэх;

7) технологийн дэд бүтэц, орчныг буй болгох, технологийн агууламж, чадамж, статусыг зөв үнэлэх;

8) шинжлэх ухаан, технологийн оюуны чадавхи, хөрөнгө бололцоог улсын хэмжээний судалгааны төслүүдийг шийдвэрлэхэд эн түүвэнд төвлөрүүлэх;

9) боловсролын тогтолцоог байнга чанаржуулж, авьяасыг тэтгэн хөгжүүлэх;

10) өндөр мэргэшилтэй мэргэжилтэнг технологийн онц шаардлагатай чиглэлээр зориуд бэлтгэх, үндэсний эрдэмтдийг эх орондоо ажиллуулах, өсгөх оюуны болон материаллаг нөхцөл бололцоо бий болгох;

11) шинжлэх ухаан, технологийн судалгаа, боловсруулалт, үйлдвэрлэлийн салбарт ажиллах ирээдүйтэй боловсон хүчнийг ерөнхий боловсролын сургуулиас эхлэн сонгох, тэднийг хүн нэг бүрээр сургадаг, ажиллах нөхцөл боломжоор хангадаг журам нэвтрүүлэх;

12) оюуны зохиомол удирдлагын технологи, биотехнологийг тэргүүлэн хөгжүүлэх, цахим техник, цахилгаан хэрэгсэл усрах, нар саалхины гаралтай эрчим хүч ашиглах технологи эзэмших, теле-холбооны орчин үеийн технологитой нэгдсэн сүлжээ буй болгоход онцлон анхаарахын дэрэгцээ оюуны багтаамж ихтэй шинэ материалын эрэл хайгуулын судалгааг өргөжүүлэх;

13) шинжлэх ухаан, технологийн олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлж, олон улсын болон бүс нутгийн интеранд байр суурна эзлэх;

14) шинжлэх ухаан, технологийн үндэсний уламжлал, арга зүйг өвлөц авах, орчин үеийн нөхцөлд тохируулж хөгжүүлэх.

VII. Мэдээллийн аюулгүй байдал

40. Мэдээллийн аюулгүй байдал гэж төрөөс улс орны дотоод, гадаад бодит байдлыг зөв үнэлж, оновчтой шийдвэр

гаргах, Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах мэдээллээр төрийн байгууллага, ард иргэд хангагдсан Монгол Улсын талаар гадаадад мэдээлэл тархах нөхцөл хангагдсан байдлыг хэлнэ.

Мэдээллийн эрх чөлөө нь ардчиллыг хөгжүүлэн бэхжүүлэх нэг чухал хэрэгсэл мөн.

41. Мэдээллийн аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөөлж болох гадаад хүчин зүйлүүд:

1) гадаадын бодит бус мэдээлэл түгэсний уламас;

— Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын талаар бусад улсад эргэлзээ төрөх;

— аливаа улс Монгол Улсын дотоод хэрэгт оролцох;

— Монгол Улсын үндэстэн угсаатны хооронд үл итгэлцэх байдал, маргаан мөргөлдөөн гарах, улс орны дотоод байдал тогтворгүйжих;

2) мэдээллийн хувьд нэг буюу хэсэг улсаас хараат болох.

42. Мэдээллийн аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөөлж болох дотоод хүчин зүйлүүд:

1) аливаа хүчин хэвлэл мэдээллийг улс орны байдлыг хурцатгах, хувь хүн хувийн тооцоо хийх, бусдын нэр хүндийг гутаах зэвсэг болгон ашиглах;

2) мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх эрх алдагдах;

3) үндэсний аюулгүй байдал, улсыг батлан хамгаалах, нийгмийн хэв журмыг хангах зорилго бүхий төрийн нууц алдаглах;

4) хэвлэл мэдээллээр гүтгэгдсэн иргэн, байгууллага өөрийгөө хэвлэл мэдээллийн хэрэгслээр буюу шударга шүүхээр хамгаалуулах эрх хумигдах;

5) бүрэн мэдээлэл өгөхгүй байх буюу худал мэдээлэл өгөх замаар бусдыг хохироох;

6) мэдээллийн эрх чөлөө алдагдаж, мэдээлэл хаагдмал болсноос үйл явцын өрнөлт, шинжлэх ухаан, технологийн хөгжлөөс хохрох.

43. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах арга зам:

1) гадаад, дотоод байдлын тухай олон эх суввалж бүхий мэдээллийн сантай байх;

2) хэвлэл мэдээллийн байгууллага, хэрэгсэл гадаадын байгууллага буюу иргэдийн эрхшээлд орох явдлаас сэргэмжлэх;

3) хэвтэл мэдээллийг байгууллагууд үнэн бодитой мэдээ, мэдээлэл түгээх эрх зүйн үндсийг тогтоох;

4) компьютерт байгаа мэдээллийг хамгаалах улсын тогтолцоо, эрх зүйн хамгаалалт буй болгох;

5) олон улсын мэдээллийн сүлжээнд нэгдэж орох, Монгол Улсын тухай үнэн бодит мэдээллийг шуурхай түгээх;

6) хэвтэл мэдээллийн байгууллагууд ардчилал, олон ургалч үзлийг хөгжүүлэн бэхжүүлэхийг эрхэмлэх, үнэн бодит байдлыг зорнууд гуйвуулаж амиглахгүй байх;

7) Монгол Улсын тусгаар тогтнол, монгол соёл, зан заншилд зарш мэдээллийн түрэлтээс сэргэмжлэх;

8) хэвтэл мэдээллийн байгууллагууд болон мэдээллийн бусад эх сурвалжууд үндэсний аюулгүй байдлын талаар шалгагдсан мэдээ, мэдээллийг түгээх замаар аюулгүй байдлын мэдээллийн орчинг бүрдүүлэх.

VIII. Монгол соёл иргэншлийн аюулгүй байдал

44. Монгол соёл иргэншлийн аюулгүй байдал гэж монгол түмэн, монгол төр оршин тогтнож, хөгжихийн үндэс болсон үндэсний хэл бичиг, түүх, соёл, зан заншил хадгалагдах, монгол хүн ард үүрд оршин амьдрах нөхцөл хангагдсан байдлыг хэлнэ.

45. Монгол соёл иргэншлийн аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөөлж болох гадаад хүчин зүйлүүд:

1) гадаад улс, хүчнүүдийн улс төр, эдийн засаг, нийгэм-соёлын бодлогын улмаас монгол соёл иргэншлийн өнөрмөнц дүр төрх бүдгэрч бусад уусч болох нөхцөл бүрдэх;

2) үндсэрхэх, арьс өнгөөр ялгаварлин гадуурхах, фашизм зэрэг хүмүүнлэг бус үзэл суртал, шашны харгис номлолыг сурталчлах, хүчирхийлэл, аллага хядлага, садар самууныг сурталчлагч зүйлсийг ямарваа хяналтгүйгээр дэлгэрүүлэх.

46. Монгол соёл иргэншлийн аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөөлж болох дотоод хүчин зүйлүүд:

1) монгол соёл иргэншлийнхээ түүхэн уламжлалыг хэт дөвийлгөн үнэлж, бусад ард түмний соёлыг үл тоомсорлох, алсдаа улс үндэстний хувьд жожигрон ганцаардах;

2) бусад ард түмний соёл иргэншлийг хэт дөвийлгөн сохроор хуулбарлах буюу зах зээлийн эдийн засгийн болон орчин үеийн шинжлэх ухаан-техникийн дэвшлийн сөрөг үр дагавраас сэргийлэх бодлого алдагдах;

3) гадаад, дотоод байдлын улмаас нийгэмд оюуны хоосон зүй үүсэх, нийгэм оюуны хоосролд орох;

4) түүх, соёлын үнэт зүйлс хууль бусаар гадаадад гарах.

47. Монгол соёл иргэншлийн аюулгүй байдлыг хангах арга зам:

1) нүүдлийн соёл иргэншлийнхээ язгуур шинжүүдийг бататган баяжуулж, дэлгэрүүлэх идэвхтэй бодлого боловсруулан хэрэгжүүлэх. Аж ахуйн монгол иргэншил, монгол төрт ёс, эдийн болон оюуны соёл, зан заншлынхаа үнэ цэнэтэй, дэншилттэй бүхнийг өвлөн авч, нийт хүн төрөлхтний соёлын дээжистэй зүй зохистойгоор хослуулан хөгжүүлэх;

2) уйгаржин болон кирилл монгол бичгээ уламжлан эзэмших замээр монгол хэл бичгээ зүй тогтлын нь дагуу төгөлдөржүүлэх;

3) соёл гэгээрүүлэх монгол уламжлал, хүн төрөлхтний орчин цагийн жишигт нийцсэн боловсролын тогтолцоог бүрдүүлж, үндэснийхээ оюуны чадавхийг хамгаалан бэхжүүлэх;

4) ард түмнийхээ түүх, соёлын өв уламжлал, сэтгэлгээ, зан заншил, эх орныхоо байгалийг, танин мэдэх нөхцөлийг бүрдүүлэх, эх орноороо бахархах, нэр төрийг нь бүхнээс эрхэмлэх сэтгэлийг хүн бүрд, ялангуяа залуу үедээ төлөншүүлэх. Монголын түүх, шашин, соёлын судалгаа, сургалт, сурталчилгааны ажлыг төрийн байнгын анхааралд байлган дэмжих;

5) монгол соёл иргэншлийн дурсгалт зүйлсийг сурвалжлан олох, хамаалах, бүрдүүлэх, эх орондоо эгүүлэн залах, сэргээн босгох бодлого явуулах. Түүх, соёлын үнэт зүйлс хууль бусаар гадаадад гаргахаас сэрэмжлэх;

6) монгол хүний онгон байгальдаа зохицон аж төрөх эрдэм чадвар, арга билгийг хослон бариадуулагч ухаан, төрт ёс, эрдэм билгийг дээдлэх ёс, хамтач чанарыг эрхэмлэн хадгалж үлдэх;

7) аж ахуйн монгол иргэншлийн өвөрмөц арга технологи, үндэсний соёл урлагийн өв уламжлалыг сэргээн хадгалгах, тэдгээрийг туурвин бүтээгчдийн урын санг хамгаалах;

8) шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хүндэтгэж, шашин-сүм хийдийн дотоод хэрэгт төрөөс үл оролцон, жаяг номын нь дагуу чөлөөтэй явуулах. Сүм хийдийн тоо, байршил, лам санваартан нарын үнэмлэхүй тоог төрийн хяналтад байлгах;

9) шашин хоорондын харилцааны асуудлыг төрийн онцгой анхааралд байлгаж, хямрал мөргөлдөөнөөс сэргийлэх. Аливаа сүм хийдийн үйл ажиллагааг үндэсний соёл иргэншилд дор зохируулж үл учруулах хэмжээнд хууль зүйн хүрээнд байлгах;

10) дэлхийн олон оронд тархан суусан монголчуудтай холбоо харилцаагаа өргөжүүлж монгол соёл иргэншлээ хадгалж хөгжүүлэхэд нь тэдэнд туслалх. Монгол Улс нь монголчуудын гал голомт мөн бөгөөд Монгол орноо хөгжүүлэх гэсэн тэдний эрмэлзлийг дэмжих чиглэл баримтлахын зэрэгцээ уг харилцаанд улс төрийн аливаа утга агуулга оруулахад онцлон сэрэмжлэх;

11) Монголын ард түмний эн нэгдэл хүн ардын ёс суртахуун, сэтгэл санаанд сөрөг нөлөө үзүүлэхүйц арьс өнгөөр ялгагварлан гадуурхах үзэл, фашизм зэрэг хүмүүнлэг бус үзэл номлол дэлгэрэхээс сэрэмжлэн, хүчирхийлэл, аллага мэдлага, дайн, садар самуун зэрэг бусармаг явдлыг ямар нэгэн байдлаар «сурталчлагч» зүйлсийг зөвхөн хууль зүйн хүрээнд тусгай журмын дагуу үзүүлдэг, хэвлэн нийтэлдэг, түгээдэг байх.

IX. Хүн ам, удмын сангийн аюулгүй байдал

48. Хүн ам, удмын сангийн аюулгүй байдал гэж Монгол Улсын хүн амын эрүүл мэнд, удмын сан, тогтвортой өсөлт хадгалагдаж, хамгаалагдсан нөхцөл байдлыг хэлнэ.

49. Хүн удмын сангийн аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөөлж болох гадаад хүчин зүйлүүд:

1) ягаар, ус болон газрын хөрсөөр дамжин цацраг илрэхт бодис, химийн бохирдол, хүчиллэг бороо, гоц халдварт өвчин орж ирэх;

2) олон улсын хөдөлмөрийн хуваарьт байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд хөнөөлтэй үйлдвэрлэл явуулдаг болж орох;

3) гадаад худалдааны бодлого, импортын барааны чанарыг тавих хяналт суларч алдагдсаны улмаас хүн амын эрүүл мэнд, удамшилд сөргөөр нөлөөлөх хоол хүнс, хими болон өргөн хэрэглээний бараа орж ирэх.

50. Хүн ам удмын сангийн аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөөлж болох хүчин зүйлүүд:

1) хүн амын гоц халдварт өвчин гарах;

2) цус ойртож монгол хүний удмын санд сөргөөр нөлөөлөх, ийн ялангуяа оюун ухааны хомсдох болон сэтгэл мэдрэлийн өвчтэй хүний тооны эохистой харьцаа алдагдах, дэхийн улс орнуудын дундаж үзүүлэлтээс илүү гарах;

3) архиан согтуурах явдал газар авч хүн амын эрүүл мэнд, удмын санд сөрөг нөлөө үзүүлэх;

4) хүн амын нас хүйсний бүтцийн харьцаа алдагдах;

5) хүн амын дунд өдөглөөн тураал газар авах, ундны болон цэвэр усны хангамж хомсдох, бохирдох;

6) дотоодын үйлдвэрлэлд эрүүл ахуйн болон бусад тогтсон стандартыг зөрчих, хүн амын эрүүл мэндэд хөнөөлтэй хоол хүнс, өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэж аливаа хяналтгүй худалдаалах;

7) химийн бодистой харьцах замаар журмыг зөрчсөнөөс хүн амын эрүүл мэнд, удмын санд сөрөг нөлөө үзүүлэх.

51. Хүн ам, удмын сангийн аюулгүй байдлыг хангах арга зам:

1) монгол хүний удмын санд, эрүүл мэнд, хүн амын тогтвортой өсөлтийг хангахад чиглэсэн төрийн нэг бүрэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

Удмын бичиг хөтөлдөг уламжлалыг олон түмний идэвх санаачилганд тулгуурлан сэргээх, хүн бүр оюог болон өөрөөс дээш 7—9 үеэ мэддэг болох;

2) урьдчилан сэргийлэлтийг хүн амын эрүүл мэндийг хамгаалах төрийн бодлого, үйл ажиллагааны үндэс болгох;

3) цус ойртох, архиан согтуурах, мансуурах зэрэг монгол хүний удмын санд сөрөг нөлөөлөх бүхнээс сэргийлэх, монгол хүн, хүн амыг цогцолборлоор судлах асуудлыг тэргүүлэх чиглэл болгон тавих.

Оюун ухааны хомсдол болон сэтгэл мэдрэлийн өвчнөөс урьдчилан оношлох, сэргийлэх бодлого агуулах, хүн амын сэтгэл зүйн аюулгүй байдлыг хангах;

4) хөрш зэргэлдээ орны хил залгаа нутагт байрлаж буй цаураг идэвхжлийн болон химийн бохирдол, биологийн дорт нийгмийн бохирдол, тэдгээрээс гаралтай бичин тахлаас сэргийлэх хяналтын тогтолцоо бүрэлдүүлэх;

5) хүний удамшил, хүн амын эрүүл мэндэд шууд болон үлдэц нөлөө бүхий онцгой хортой химийн болон биологийн гаралтай материалыг Монгол Улсын нутаг дэвсгэрт оруулах дамжуулан тээвэрлэх, түүнчлэн гадаад орны хортой хог

хангаал булшлах, боловсруулах замаар аж ахуй эрхлэх үйл ажиллагааг хориглох;

6) хүн амын дотор удамшлын өвчин, сорог, оюун ухааны хомедолын тархалт, илэрэлтийн давтамжинд байнгын хяналт тавих;

7) хүний удмын санд сөрөг нөлөөлөх химийн бодис хүрээлэн буй орчинд хуримтлагдаж байгаа эсэхэд байнгын хяналт тавьж байх;

8) хүнсний аюулгүй байдлыг төрийн онцгой анхааралд байлгаж, хүнсний бүтээгдэхүүнд хүний эрүүл мэнд, удамшлын бүтцэд нөлөөлөх элдэв хорт бодисын хольц байгаа эсэхэд хяналт тавих, үндэсний нэгдсэн лаборатори байгуулах;

9) хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх нийгэм, биологи, орчны хүчин зүйлд хатуу хяналт тавих, эм, био бэлдмэлийн үйлдвэрлэлийн технологийг хөгжүүлж, үндэсний зайлшгүй чухал эмийн 50-иас доошгүй хувийг дотооддоо үйлдвэрлэх, юуны өмнө эх орны эрдэс, ургамал, амьтны гаралтай түүхийг эдээр эм бэлтгэх бодлого явуулах;

10) хүн амын эрүүл мэнд, эх хүүхдийн өвчлөл, нас баралтын гол үзүүлэлтүүдийг дэлхийн дундаж түвшинд хүргэн бууруулах. Эх хүүхдийн эрүүл мэндийн зарим тулгамдсан асуудлыг зөв зохистой шийдвэрлэх зорилгоор хүн амын төрөлтийг зохицуулах бодлого явуулах.

Х. Экологийн аюулгүй байдал

52. Экологийн аюулгүй байдал гэж байгаль цаг уурын өөрчлөлт болон байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах бодлогын харьцаа алдагдсанаас хүний амьдрах орчин, эдийн засагт үүсэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх нөхцөл хангагдсан байдлыг хэлнэ.

53. Экологийн аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөөлж болох гадаад хүчин зүйлүүд:

1) дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн улмаас цолжинг эрчимжих, хур тунадасын хэмжээ, дулаарчлалт өөрчлөгдөх, ган, зудтай жилийн тоо нэмэгдэх, олоны давхарга нимгэрэх;

2) хил дамжин агаар, усаар орж ирэх цацраг идэвхжил, химийн бохирдол, хүчиллэг бороо ихсэх, хүн амьтныг олноор хөнөөх өвчин тахал гарах, ой мод, бэлчээр, ургамлыг устгах хортой мэрэгчид, хорлой шавьж олширох;

3) мансууруулах болон хүний оюун ухаан, эрүүд мэндэд хортойгоор нөлөөлөх бодисын түүхий эд бэлдэх түшиц газар болон хувирах.

54. Экологийн аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөөлж болох дотоод хүчин зүйлүүд:

1) экологийн тэнцвэрт тогтолцоо алдагдах, хөрсний хлэгдэл эндрэл ихсэх, ургамал, амьтны удмын сан хомсдох;

2) ургамлын нөмрөг ядуурч ойн нөөц хомсдон мөрөн, гол нуур, газрын дөөрхи ус татарч ширгэх, нутаг бэлчээр ганди хуурайших;

3) байгалийн нөөц баялгийг сорьдох, цөмнөх байдлаар ашиглах;

4) хаягдал ихтэй техник, технологи хуримтлагдах, хортой хог хаягдал гаргадаг үйлдвэрлэл бөөгнөрөх, гадаад орны хортой хог хаягдал булшлах газар болох.

55. Экологийн аюулгүй байдлыг хангах арга зам:

1) байгаль орчноо хайрлан хамгааладаг ардын уламжлал, ёс заншлыг сэргээж бүх нийтэд түгээн төлөншүүлэх ажлыг төрийн бодлогын хэмжээнд тавих;

2) байгалийн нөхөн сэргээгдэх нөөцийн хүрээнд амьдралын хэрэгцээг бүрэн хангах, үл нөхөгдөх буюу удаан сэргэдэг нөөцийг зөвхөн улс орны хөгжлийн ашиг сонирхлын үүднээс нэмэлт хүчин зүйл болгож ашиглах зарчим баримтлах;

3) эдийн засгаа экологийн баримжаатайгаар хөгжүүлж ЭКОМАРК бүхий бүтээгдэхүүнээр дэлхийн зах зээлд тодорхой байр суурь эзлэх бодлого баримтлах;

4) газар нутгийн зарим шаардлагатай хэсгийг дэрхлан хамгаалж, бусдыг нь экологийн тэнцвэрийг барих бодлого, зөвшүүрэгтэйгээр аж ахуйн эргэлтэд аажмаар оруулах;

5) газрыг чөлөөтэй эзэмших хэлбэрээр эзэнгүйдүүлэх буюу хүн бүрд хувь оноох хэлбэрээр тасдан хуваахаас зайлсхийх, бэлчээрийг эргэж буцаалгүй талхагдалд оруулахаас сэргийлэх;

6) эдийн засгийн дэд бүтэц, байгалийн нөөцийн иж бүрдлийг багтаасан байгаль орчны тэнцвэрийг хангахуйц цогцолбор бүрдүүлэх зорилгоор засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өнөөгийн хуваарьдалтыг цаашид задалж жижигрүүлэхгүйгээр экологи-эдийн засгийн бүс бий болгох чиглэл баримтлах;

7) хот, суурин газрыг төлөвлөх, байгуулахдаа хүн амыг хэт бөөгнөрүүлж тухайн бүс нутагт байгаль орчны тэнцвэр алдагдах голомт болохоос зайлсхийх;

8) элс тогтоох, ус шингээн хадгалах бутлаг ургамлыг түлшинд хэрэглэхийг хязгаарлаж, модон материалын хэрэгцээг хангахад хөрш зэргэлдээ орнуудын боломжийг ашиглах бодлого баримтлах. Ой модыг нөхөн сэргээх, гал түймрийн аюулаас сэргийлэх, булаг, шанд, гол горхины эхийг ойжуулах, тариалангийн талбайд хамгаалалтын ойи зурвас байгуулах зэрэг цогцолбор арга хэмжээг үндэсний стратегийн зорилт болгон хэрэгжүүлэх;

9) доройтсон орчныг ургамалжуулах, ургамлын нөмрөгийн хэмжээг жилээс жилд нэмэгдүүлэх;

10) үндэсний «Улаан ном»-ыг байнга сэргээн баяжуулж дэлхийд ховордсон болон Монгол орны ховор ховордсон үлдэц, устах аюулд орсон буюу орж болзошгүй бичил биетний удмын санг хамгаалах цэгцтэй бодлого явуулах;

11) эмийн болон хүнсний, түүнчлэн техникийн үнэт ургамлыг нутагшуулах, тарималжуулах замаар үйлдвэрлэлийн хэмжээнд ашиглах, монголын унаган болон ховордсон, аж ахуйн чухал ач холбогдол бүхий амьтан, ургамлын гаралтай олзворын зүйлийг эдийн засгийн ашиг сонирхлын үүднээс гадаадад гаргахыг хязгаарлах;

12) Монгол Улсын тус улсын нутаг дэвсгэрт байгаа нуур, мөрөн гол, уст цэгүүд, усны иийт нөөц төр, ард түмний хамгаалалтад байж, усны нөөцийг хэмнэлттэй зарцуулах, хуримтлуулах, хур тунадасны ус хураах сан байгуулах ахуйн болон үйлдвэрлэлийн хэрэгцээний цэвэр усны нөөц чанарын хяналтын тогтолцоо бүрдүүлэх;

13) Монгол Улсын нутаг дэвсгэрт болон түүний хилийн ойролцоо газарт цөмийн зэвсэг турших, байрлуулахын эсрэг идэвхтэй үйл ажиллагаагаа оновчтой арга хэлбэрээр явуулах;

14) байгаль орчинд халтай нөлөө бүхий аж ахуй эрхлэх явдлыг эрх зүйн болон эдийн засгийн хөшүүргээр хязгаарлах чиглэл баримтлах;

15) озоныг саармагжуулах үйлчилгээ бүхий хий гаргадаг үйлдвэрлэл явуулахгүй байх, ийм төрлийн бүтээгдэхүүнийг хязгаарлах;

16) байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулаас сэргийлэх, тэмцэх тогтолцоо бий болгох;

17) хуурай буюу цөлжсөн бүс нутагт хүн ардынхаа амьдралыг хангах үндэсний уламжлалт технологийг судалж, уур

амьсгалын болзошгүй өөрчлөлтийн аливаа тохиолдолд үндэснийхээ амьдрах чадварыг хангах бэлтгэлтэй байх;

18) Монгол орны амьд биегийн бүрдлийн өвөрмөц голломт, шимт мандлын зангилгаа цэгүүдийг дархан газрын сүлжээнд бүрэн хамруулахын хамт тэдгээрийн заримыг нь олон улсын статустай болгож дэлхийн соёлын өвд багтаах арга хэмжээ авах;

19) Монгол Улсын нутаг дэвсгэрийг олон улсын хамгаалалттай экологийн бүс нутагт хамруулах бодлого ивуулах;

20) байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх асуудлаар олон улсын гэрээ хэлэлцээр байгуулах, олон улсын байгууллагууд, хандивлагч орнуудтай хамтран экологийн чиглэлийн төслүүд хэрэгжүүлэх замаар тэргүүний технологи оруулах, болзошгүй аливаа аюулаас урьдчилан сэргийлж ямар ч нөхцөлд хохирол багатай даван туулах тогтолцоо бий болгох.

XI. Бусад заалт

56. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тусгагдсан үндсэн бүтэн, тэдгээрийн агуулгад дэлхий дахины, бүс нутгийн болон улс орны байдал хөгжил, өрнөлтийн чиг хандлагад гарч байгаа өөрчлөлттэй уялдаж Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн санал болгосноор Улсын Их Хурал зохих нэмэлт өөрчлөлт оруулж байна.

МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Дэлхийн хоёрдугаар дайнаас хойш олон улсын харилцаанд ноёрхсон хүйтэн дайн дуусч, бие биеийгээ сөрөн зогссон хоёр туйлт ертөнцийн бүтэц задарч, олон улсын харилцааны шинэ тогтолцоо бүрэлдэх үйл явц бэлжиж байна.

Хэдийгээр дэлхийн улс түрнүүд нийгмийн хөгжлийн жам ёсоор, түүний дотор эдийн засаг, технологийн хөгжлийн шаардлагаар ойртож, харилцан уялдаа холбоогоо бэхжүүлэх нөхцөл бүрэлдэж байгаа боловч улс орнуудын шашин, үндэстэн хоорондын зөрчил нэмэгдэж үндсээрхэг үзэл газар авч, бүс нутгийн хэмжээнд болон тодорхой улс орны дотор зөрчил, мөргөлдөөн гарах магадлал багасгахгүй байна.

Дэлхийн социалист систем, Зөвлөлт Холбоот Улс задарсан нь түүний холбоотон байсан Монгол Улсын гадаад нөхцөл байдлыг эрс өөрчлөв. Эдүгээ хөрш хоёр оронд гарч буй томоохон өөрчлөлт нь Монгол Улсын гадаад орчинд шууд нөлөөлж байна.

Манай орны улс төр, нийгэм, эдийн засгийн байгууллын өөрчлөлт, шинэчлэлт улс үндэснийхээ ашиг сонирхлыг дээдэлсэн, бодит байдалд тулгуурласан гадаад бодлого явуулах аятай боломж бүрдүүлж байна.

Гадаад, дотоод эдгээр хүчин зүйлийг үндэс болгон Монгол Улсын гадаад бодлогын үзэл-баримтлалыг тодорхойлж байна.

I. Нийтлэг үндэсэл

1. Тусгаар тогтносон, бүрэн эрхт Монгол Улс нь төрийн байгууламжийн хувьд нэгдмэл, ардчилсан ёс, хүний эрх, эрх чөлөө, чөлөөт эдийн засгийг эрхэмлэсэн улс бөгөөд улс төр, газар зүйн хувьд Ази тивд хоёр их гүрний дунд оршдог, далайд гарцгүй, хөгжиж байгаа орон юм. Монгол Улсын гадаад бодлого нь тус улсын Үндсэн хуульд тодорхойлон заасан үндэсний ашиг сонирхолд тулгуурлах бөгөөд Монгол Улсын гадаад, дотоод өнөрмөц байдал нь гадаад

бодлогын зорилго, зарчим, чиглэлийг тодорхойлох үндэс болно.

2. Монгол Улсын гадаад бодлогын зорилт нь тус улс хүн төрөлхтний хөгжлийн жамыг даган бүх улс оронтой найрсаг харилцаатай байж, олон улсын хамтын нийгэмлэгт байр сууриа бэхжүүлэн, бүс нутгийн болон дэлхийн нөлөө бүхий улс гүрнүүдтэй улс төр, эдийн засгийн болон бусад ашиг сонирхлын шүтэлцээ бүхий харилцааны сүлжээ бүрдүүлэх замаар улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бат найдвартай хангах явдал мөн.

3. Монгол Улс нээлттэй, эвсэлд үл нэгдэх бодлого явуулна. Өндөр хөгжилтэй улсуудын бодит сонирхлыг Монголд бий болгох бодлого баримтлахын хамт аль нэг улсаас хэт хамааралтай буюу хараат байдалд орохоос сэрэмжилнэ. Гадаад орнууд дахь Монголын сонирхлыг улс төр-эрх зүйн аргаар бататган хамгаална.

4. Монгол Улсын гадаад бодлогыг тодорхойлохдоо олон улсын харилцааны хөгжил, дэлхий дахины болон бүс нутгийн улс төрийн байдалтай нягт уялдуулж тэргүүлэх чиглэл, зорилтыг нь тогтоохдоо уян хатан хандаж байна.

5. Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний язгуур ашиг сонирхлыг улс төр-дипломатын аргаар хангах, эдийн засаг, шинжлэх ухаан-технологийг хөгжүүлэх гадаад таатай нөхцөлийг бүрдүүлэх явдал гадаад бодлогын тэргүүлэх чиглэл байна.

6. Улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан-технологич, соёл хүмүүжилэгийн хүрээний гадаад харилцааны бодлого дотроос улс төрийн гадаад бодлого тодорхойлогч шинжтэй байна.

II. Монгол Улсын гадаад улс төрийн бодлого

7. Монгол Улсын гадаад улс төрийн бодлого нь тус улсын аюулгүй байдлыг ханган бэхжүүлэх нэг гол хэрэглүүр бөгөөд түүний үр дүнг юуны өмнө тус улсын аюулгүй байдал, тусгаар тогтнолын ашиг сонирхол хэрхэн хангагдаж, олон улсын байр суурь хэр бэхжиж, нэр хүнд нь хэрхэн өсч байгаагаар тодорхойлно.

8. Монгол Улс аливаа улстай харилцахдаа бие биеийн бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн, хилийн халдашгүй дархан байдал, өөртөө засан тогтнох бүрэн эрхийг харилцан хүндэтгэх, дотоод хэрэгт үл оролцох, хүч үл хэрэглэх, маргаантай асуудлыг эв зүйгээр шийдвэрлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, эрх тэгш харилцан ашиг-

тэй хамтран ажиллах зэрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрэмд тодорхойлж, нийтээр хүлээн зөвшөөрсөн олон улсын эрх зүйн нийтлэг зарчим, хэм хэмжээг удирдлага болгоно.

9. Монгол Улс гадаад улс төрийн бодлогодоо энхийг эрхэмлэж, улс гүрэнтэй сөргөлдөхгүй байхыг аль болохоор чухалчилж, олон тулгуурт бодлого явуулна. Үндэснийхээ ашиг сонирхлыг ямагт дээдлэхийн хамт бусад улс, туншийнхээ хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэнэ. Монгол Улсын үндэсний ашиг сонирхлыг шууд хөндөөгүй хөрш хоёр орныхоо маргаанд хөндлөнгөөс үл оролцоно. Цэргийн аливаа эвсэл, бүлэглэлд үл нэгдэх, нутаг дэвсгэр, агаар мандлаа аль нэг улсын эсрэг ашиглуулахгүй, гадаадын цэрэг, зөвсөг, түүний дотор цөмийн болон үй олноор хөнөөх бусад зэвсгийг нутаг дэвсгэртээ байрлуулахгүй байх чиг шугам баримтална.

10. Монгол Улс олон улсын тавцанд ашиг сонирхлоо хоёр болон олон талт гэрээ хэлэлцээрээр баталгаажуулна. Олон улсын эрх зүйг хүндэтгэн сахиж, гэрээ хэлэлцээрээр хүлээсэн үүргээ шударгаар биелүүлнэ.

11. Монгол Улс дэлхийн хамтын нийгэмлэгийн гишүүний хувьд бүс нутгийн болон дэлхий дахины чанартай тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн бүх нийтийн үйлсэд боломжийн хэрээр идэвхтэй хувь нэмэр оруулахыг чармайна. Чингэхдээ үндэсний ашиг сонирхол, үнэт зүйлс, тулгуур зарчмуудаа юуны өмнө удирдлага болгоно.

12. Монгол Улс гадаад улс төрийн бодлогоо хэрэгжүүлэхдээ дараахь чиглэлийг баримтална:

1) ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад бодлогын эн тэргүүний зорилт мөн бөгөөд аль нэгийг нь өрөөсгөлөөр дагахгүй, бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хамтын ажиллагаа хөгжүүлнэ. Чингэхдээ энэ хоёр оронтой харилцаж ирсэн уламжлал, эдийн засгийн хамтын ажиллагааны өвөрмөц онцлогийг харгалзана;

2) Монгол Улсын гадаад бодлогын хоёр дахь чиглэл бол АНУ, Япон, ХБНГУ зэрэг өрнө, дорнын өндөр хөгжилтэй гүрнүүдтэй найрсаг харилцаа хөгжүүлэх явдал мөн. Үүний хамт Энэтхэг, БНСУ, Тайланд, Сингапур, Турк, Дани, Нидерланд, Финланд, Австри, Швед, Швейцари, зэрэг оронтой найрсаг харилцаа хөгжүүлж, тэдгээрийн эдийн засгийн бо-

лон бусад бодит сонирхлыг Монголд бий болгон зохиостой түвшинд хүргэх бодлого баримтална;

3) Монгол Улсын гадаад бодлогын турав дахь чиглэл бол Азийн бүс нутагт байр сууриа бататгаж эндхийн улс төр, эдийн засгийн интеграцид оновчтой оролцох явдал мөн. Энэ зорилтын хүрээнд Ази, Номхон далайн чиглэл, түүний дотор Зүүн-хойд Ази, Төв Азийн чиглэлд түлхүү анхаарна. Монгол Улс бүс нутгийн аюулгүй байдлыг бэхжүүлэх асуудлаар яриа хэлэлцээ өрнүүлэх, хамтын аюулгүй байдлын механизм буй болгох үйл явцад идэвхтэй оролцоно. Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны бэлтгүүллэга (АПЕК)-д элсэн орохыг зорилно. Бүс нутгийн интеграцид орох нөхцөлийг юуны өмнө түүнд хамаарч буй улс орнуудтай хоёр талын харилцааг өргөтгөн хөгжүүлэх замаар бүрдүүлнэ;

4) Монгол Улсын гадаад бодлогын дөрөвдэх чиглэл нь Нэгдсэн Үндэстний Байгууллага болон түүний төрөлжсөн байгууллагууд, Олон улсын валютын сан, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг санхүү-эдийн засгийн байгууллагуудтай хамтран ажиллах явдал байна;

5) социалист хамтын нөхөрлөлийн гэгдэж байсан орнууд, шинээр тусгаар тогтносон улсуудтай найрсаг харилцаа хөгжүүлэх нь Монгол Улсын гадаад бодлогын тав дахь чиглэл байна. Эдгээр улстай харилцахдаа өмнөх харилцааны иашнтай өвийг бататгахыг чухалчлахын хамт харилцаагаа шинэ нөхцөлд зохицуулан хөгжүүлэх бодит боломжийг харгалзан уян хатан хандана. Тухайлбал Дорнод Европоос Польш, Унгар, Чех улстай, мөн Казахстан, Украин, Беларусь, Киргизстан, Узбекстан улстай харилцаагаа түлхүү хөгжүүлэхэд анхаарна;

6) хөгжиж байгаа орнуудтай найрсаг харилцаатай байж, нийтлэг зорилтоо шийдвэрлэх үүднээс бодит боломжийн хэмжээнд гэдгээртэй хамтран ажиллах явдал Монгол Улсын гадаад бодлогын зургаа дахь чиглэл байна. Энэ зорилтыг хоёр талын харилцааны хүрээндээс гадна голчлон олон улсын байгууллага, хөдөлгөөний хүрээнд, тухайлбал Нэгдсэн Үндэстний Байгууллага, «77»-гийн бүлэг, Эвсгэл үл нэгдэх хөдөлгөөн зэрэгт хамтран ажиллах замаар хэрэгжүүлнэ.

13. Монгол Улсын гадаад улс төрийн бодлогын чиглэлүүдийг харгалзан тус улсаас гадаад улсад суух бүрэн эрхт

төлөөлөгчийн газрын байршлыг тогтоож, гадаад улс төрийн бодлого хэрэгжүүлэх нөхцөл бүрдүүлнэ.

14. Монгол Улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газарт эдийн засаг, шинжлэх ухаан, технологийн талаар өндөр мэдлэг боловсролтой боловсон хүчин оролцуулан томилж ажиллуулах зарчим баримтална.

III. Эдийн засгийн гадаад харилцааны бодлого

15. Монгол Улсын эдийн засгийн гадаад харилцааны бодлогын үндсэн зорилго нь тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын үндсэн дээр тус Улсын эдийн засгийн хэтийн болон цаг үеийн зорилтыг зохистой шийдвэрлэхэд гадаад хүчин зүйлийг оновчтой ашиглах, улмаар улс орны эдийн засгийг бүс нутгийн интеграцид өөрийн гэсэн байр суурьтай болгоход оршино.

16. Гадаад улс орнуудтай эдийн засгийн харилцаа хөгжүүлэх, хамтран ажиллахдаа эдийн засгийн аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэх, аль нэг орноос хэт хараат байдалд орохоос сэргэмжлэхийн хамт олон улсын аж ахуйн харилцааны зарчим, хэм хэмжээг баримтлан эрх тэгш, харилцан ашигтай байх, хүдээсэн үүргээ шударгаар биелүүлэх, улс төрийн болон бусад даралт шахалтад автахгүй байх нөхцөл бүрдүүлэх бодлого явуулна.

17. Эдийн засаг, гааль, худалдааны тусгай бүс байгуулах, хамтарсан буюу гадаадын дагнасан хөрөнгө оруулалттай үйлдвэр байгуулах, концесс олгох зэрэг хөгтөлбөрийг улс төр, эдийн засгийн үр дагаврыг нь нарийн тооцож үндэсний аюулгүй байдалд хохирол учруулахгүй, эдийн засгийн үр ашигтай байхуйцаар ашиглана.

18. Үндэсний ашиг сонирхолд ихээхэн нөлөө бүхий төслийг хэрэгжүүлэхдээ хамтран ажиллах улс буюу туншийг улс төрийн ашиг сонирхолын үүднээс сонгохыг чухалчилна.

19. Гадаад өрийн асуудлыг улс орны эдийн засгийн аюулгүй байдалд хохиролгүйгээр зохицуулж, зээлийг эгүүдэн төлөх баталгааг нь нарийн тооцож зөв тогтоосны үндсэн дээр авч, үр дүнтэй ашиглана.

20. Монгол Улс эдийн засгийн гадаад харилцааг хөгжүүлэхдээ дараахь үндсэн чиглэл баримтална.

1) эдийн засгийн гадаад харилцааны үйл ажиллагааг улс орны эдийн засгийн чадавхи, экспортын чиглэлийн нөөцийг өстөн нэмэгдүүлэх, эдийн засгийн дэд бүтцийг бүрэл-

дүүлэх, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх;

2) Монгол Улсын эдийн засгийн түүхий эд зонхилсон чиглэлийг өөрчилж, оновчтой бүтцийг бүрэлдүүлэхэд чиглэсэн үндсэн салбаруудыг хөгжүүлэх шаардлагатай уялдуулан эрдсийн болон мал, амьтан, ургамлын гаралтай түүхий эдийн боловсруулалтын түвшинг хамгийн үр ашигтай хэмжээнд хүргэж, дэлхийн зах зээлд өрсөлдөх бүтээгдэхүүн үйлдвэрлэх;

3) одоо байгаа үйлдвэрүүдийг орчин үеийн шилдэг техник, технологиор шинэчлэн тоноглох, хүнс, хөнгөн үйлдвэр, уул уурхай, хими, биотехнологи, шинэ материалын зэрэг экспортын чиглэлтэй аж үйлдвэрийг өөрийн орны түүхий эдэд тулгуурлан хөгжүүлэх чиглэл баримтлах;

4) экспортын чадавхийг дээшлүүлэхдээ алт, зэс, молибден, уран зэрэг эрдэс түүхий эдийг боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бүрэн боловсруулж, дэлхийн зах зээлд өрсөлдөх бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд гадаад орнуудтай хамтран ажиллах;

5) монголын экспортын бүтээгдэхүүний зах зээлийг өргөтгөх;

6) улс орны түлш-эрчим хүч, зам тээвэр, харилцаа холбоо зэрэг дэд бүтцийн салбарыг хөгжүүлэх, далайн боомт хүрэх, дамжин өнгөрөх зам тээврийн таатай нөхцөл бүрдүүлэх;

7) олон улсын, ялангуяа Зүүн-хойд Азийн зам, тээвэр, мэдээлэл, харилцаа, холбооны сүлжээнд нэгдэж орох;

8) импортыг орлуулах бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлтэй дунд, жижиг үйлдвэрийг хөгжүүлэхэд гадаадын зээл тусламж, технологи авах бодлого баримтлах;

9) монгол орны байгаль, түүх, соёлын өв санд түшиглэн олон улсын аялал жуулчлалыг хөгжүүлэх, материалаар баазыг нь бэхжүүлж, үйлчилгээг дэлхийн түвшинд хүргэх;

10) гадаад худалдааны нэн тавламжтай нөхцөл олох, хөнгөлттэй зээл, буцалтгүй тусламж авах статусыг тодорхой хугацаанд хадгалах.

IV. Шинжлэх ухаан-технологийн гадгад харилцааны бодлого

21. Шинжлэх ухаан-технологийн гадаад харилцаа, хамтын ажиллагааны гол зорилго нь улс орны эдийн засаг,

үйлдвэрлэлийн эрчимтэй хөгжлийн хөдөлгөгч хүч болохуйц, бүс нутаг, тив, дэлхийд өрсөлдөх чадвартай үндэсний шинжлэх ухаан, техник, технологийн орчин үеийн чадавхийг бүрэлдүүлж хөгжүүлэхэд гадаад хүчин зүйлийг бүрэн ашиглах явдал мөн.

22. Улс орны хүн хүчний болон байгалийн нөөц баялаг, нийгмийн онол, сэтгэлгээний түвшин, бэлчээрийн мал аж ахуй эрхлэгчдийн өвөрмөц соёл иргэншлийн хэв шинжид тохирсон мэдлэг, оюуны сан хөмрөгийг дэлхийн шинжлэх ухаан, техник, технологийн ололтоор баяжуулах зарчмыг мөрдлөг болгоно.

23. Монгол Улс шинжлэх ухаан-технологийн салбарын гадаад харилцааны бодлогыг хэрэгжүүлэхдээ дараахь үндсэн чиглэл баримтална:

1) үйлдвэрлэл, үйлчилгээнд дэвшилт арга технологи нэвтрүүлэх. Чингэхдээ оюуны их багтаамжтай технологийг сонгон нэвтрүүлэхийг эрхэмлэх. Эрдэс түүхий эд, мал, ургамлын гаралтай түүхий эд, сэргээгдэх эрчим хүчний зэрэг технологийг нэвтрүүлэхэд түлхүү анхаарах;

2) шинжлэх ухаан-технологийн үндэсний мэдээллийн сүлжээг олон улсын мэдээллийн сүлжээнд холбох;

3) оюуны өмч, шинжлэх ухаан-техникийн салбарт хоёр болон олон талын хамтын ажиллагааг хөгжүүлэх.

V. Соёл, хүмүүнлэгийн гадаад харилцааны бодлого

24. Соёл, хүмүүнлэгийн гадаад харилцааны гол зорилго нь монгол туургатны соёл иргэншлийг хамгаалах, соёлын өвөрмөц өн уламжлалыг арвижуулж, дэлхийн соёлын нийтлэг ололтоор баяжуулах, түүх соёлын үнэт зүйлсээ сэргээх, хальж гарсан зүйлсийг сурвалжлан олох, шинэ мөхцөлд ажиллах чадвартай үндэсний боловсон хүчин бэлтгэх зэрэгт соёлын хамтын ажиллагааг чиглүүлэх, улс орноо гадаадад таниулах, Монгол Улсыг сонирхогч, талархагчдын эгмээг өргөтгөх, бусад орон дахь Монгол судлалыг хөхүүлэн дэмжих, улс түмнийг танин мэдэх, тэдэнтэй харилцан ойлголцох, итгэлцэх явдлыг нэмэгдүүлэхэд оршино.

25. Соёл, хүмүүнлэгийн салбарт хамтран ажиллахдаа төрийн болон ардын дипломатын аргыг хослуулах, хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн хүндэтгэх, эрх тэгш харилцан ашигтай байх зарчим баримтална.

26. Монгол Улс хүмүүнлэгийн салбарын гадаад харилцааг хэрэгжүүлэхдээ дараахь чиглэл баримтална:

1) гадаад орнуудтай эрх зүйн өргөн хамтын ажиллагаа хөгжүүлж, гадаадад байгаа Монгол Улсын иргэдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны эрх, ашиг сонирхол, аюулгүй байдлыг хамгаалах;

2) хилийн чанадад орших монгол үндэстнүүдтэй харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлж, хэл, соёл, уламжлалаа хадгалан хөгжүүлэхэд бие биеийгээ харилцан дэмжих, тэдний зүгээс Монгол Улсын хөгжил, дэвшилд үзүүлэх дэмжлэг туслалцааг авах;

3) Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, ард түмний эв нэгдэлд хор хөнөөд бүхий хартис урсгал, бүдгийн нөлөөлөлөөс урьдчилан сэргэмжлэх арга хэмжээ авч байх;

4) зах зээлийн эдийн засаг, улс төр, эрх зүй, менежмент, маркетинг болон тус улсын шинжлэх ухаан-техникийн дэвшлийн тэргүүлэх чиглэлээр өндөр дөгжилтэй орнуудад оюутан сургах, мэргэжлийн удирдах ажилтан, мэргэжилтэн бэлтгэхийг урьтал болгох. Чингэхдээ олон улсын тусай болон хөгжингүй орны төрөлжсөн сан, улсын ба хувийн их, дээд сургууль, байгууллагын зардлаар оюутан сургах, боловсон хүчний мэргэжил дээшлүүлэх, эрдмийн зэрэг хамгаалуулах, нарийн мэргэшлийн ажилчин бэлтгэх, гадаадаас өндөр мэргэжлийн багш, эрдэмтдийг урьж ажиллуулах зэрэг боломжийг ашиглах;

5) гадаад орны ерөнхий боловсролын болон мэргэжлийн сургалтын шилдэг арга технологи, зохион байгуулалтыг судлан тус улсын онцлогтой уян хатан хослуулан авч хэрэглэх;

6) Монголын түүх соёлын дурсгалт болон байгалийн өв, үнэт зүйлсийг нөхөн сэргээх, хамгаалах, улс түмний хүртээл болгох талар түүх, шашин, соёлын нийгэм өв бүхий Азийн орнууд, сонирхогч бусад орон, ЮНЕСКО, олон улсын холбогдох бусад байгууллагатай хамтран ажиллах;

7) боловсрол, соёл, урлаг, спорт, олон нийт, мэдээллийн олон улсын байгууллага, сангуудтай нэгдсэн харилцах, шаардлагатай гэрээнд нэгдэн орох, ижил төрлийн байгууллагуудын хооронд шууд харилцаа тогтоон хөгжүүлэх, эрдэмтэн, багш, уран бүтээлч, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгчид, тамирчид, жуулчид солилцох явдлыг дэмжих, соёл, урлаг, спортын олон улсын арга хэмжээнд үр ашигтай оролцох, нийм төрлийн арга хэмжээг эх орондоо зохиох;

8) улс орны экологийн аюулгүй байдлыг хангах, экологийн тэнцвэрийг хадгалах, байгаль орчныг хамгаалах гадаад тааламжтай нөхцөлийг бүрдүүлэх, хамтын ажиллагааг хөгжүүлэх.

Монгол Улсын Их Хурлын 1994 оны
56 дугаар тогтоолын 3 дугаар хэсэг
оралт

МОНГОЛ УЛСЫН ЦЭРГИЙН НОМЛОЛЫН ҮНДЭС

Монгол Улсын төрийн батлан хамгаалах бодлого, үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээний бүрэлдэхүүн хэсэг мөн. Энэ бодлогод үйл ажиллагааны нэг үндэс нь цэргийн номлол байна.

Цэргийн номлол нь аливаа дайн, түрэмгийллийн талаарх төрийн үзэл баримтлалын үндсийг тодорхойлох, дайны аюулыг сэрэмжлэн зайлуулах, улс орноо түрэмгийлдээс хамгаалах нөхцөлийг бүрдүүлэх, хамгаалах, эвсэгт хүчин, бусад цэргийн байгуулалт, эвсэгт тэмцэл явуулах талаар төрөөс баримтлах албан ёсны үзэл баримтлал бөгөөд зөвхөн өөрийгөө батлан хамгаалах тухай Монгол Улсын Үндсэн хуулийн зарчимд тулгуурлана.

Олон улсын харилцаанд хүйтэн дайн дуусч харилцан ойлголцох, итгэлцэх, түншлэх төлөв давамгайлах болж байгаа ч дайн, эвсэгт мөргөлдөөний аюул бүрэн арилаагүй, дэлхий даяанд түүний дотор Ази, Номхон далайн бүс нутагт хамтын аюулгүй байдлын тогтолцоо бүрдээгүй байна.

Үүнээс үүдэн дэлхийн хийгээд орон нутгийн дайн, үндэстэн хоорондын болон хилийн эвсэгт мөргөлдөөний аюул байсаар байна.

Монгол Улс үндэсний аюулгүй байдлаа хангах гадаад таатай нөхцөлийг бүрдүүлэх, аливаа дайн, түрэмгийллийн аюулыг зайлуулах, энх тайванч бодлогоо олон улсын эрх зүйн түгээмэл зарчмуудад нийцүүлж:

— цэргийн хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлэхийг маргаантай асуудлыг шийдвэрлэх арга зам гэж үзэхгүй бөгөөд аливаа хүчирхийлэл, түрэмгийллийн үр дүнг хүлээн зөвшөөрөхгүй;

— өөр улсын эсрэг ямар ч тохиолдолд зэвсэгт хүчинээ түрүүлж хэрэглэхгүй, цэргийн аюул занал бусдад учруулахгүй;

— өөрөө бусдын зэвсэгт түрэмгийлэлд өртсөнөөс бусад тохиолдолд дайн, мөргөлдөөнд оролцохгүй. Ажиглагч сайн санааны туслалцаа үзүүдэх, зуучлах, эвлэрүүлэх зэрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн дагуу Нэгдсэн Үндэстний Байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүдэх талаар хүлээсэн үүргээ биелүүлдэг.

— Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалд цэргийн шууд заналхийлэл учирсан буюу учрах нь бодитой болсноос бусад тохиолдолд цэргийн аливаа эвсэл холбоонд нэгдэхгүй;

— Монгол Улсын хуульгүйгээр гадаадын цэргийн хүчнийг өөрийн нутаг дэвсгэрт нэвтрүүлэхгүй, байрлуулахгүй, дамжин өнгөрүүлэхгүй байх бодлогыг чанд баримтална.

Монгол Улсын тусгаар тогтнол бүрэн эрхт байдалд цэргийн хүчээр заналхийлсэн, зэвсэгт халдлага, түрэмгийлэл үйлдсэн улс орон, тэдний энэхүү түрэмгийлэлд холбоотон нь болж буй этгээдийг дайснаа гэж үзнэ. Монгол Улс гаднын зэвсэгт халдлага, түрэмгийллийн эсрэг өөрийгөө хамгаалах зэвсэгт тэмцэл, шударга дайныг явуулна.

Монгол Улс дараахь нөхцөл байдлыг өөрийн эсрэг чиглэсэн түрэмгийлэл гэж үзнэ:

— аливаа улс орон манай улсын нутаг дэвсгэрт цэргийн хүчээр цөмрөн орох;

— хилийн гаднаас манай улсын эсрэг зэвсгийн хүчээр цохилт хийх;

— Монгол Улсын зэвсэгт хүчин, бусад цэргийн байгууламж, нэгтгэл, анги, салбарт цохилт хийх, халдан довтлох;

— гадаад улсын цэргийн хүчин тус улсын нутаг дэвсгэрт байрлах, дамжин өнгөрөхдөө энэ тухай Монгол Улсын хуулийг зөрчих;

— аливаа улс орон, түүнд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу урт буюу түр хугацаагаар эзэмшүүлж буй газар нутгийг бусад улс орны эсрэг зэвсэгт түрэмгийллийн зорилгоор ашиглах;

— аливаа улс орон зохион байгуулалттайгаар бэлтгэж, зэвсэглэсэн хүмүүсийг Монгол Улсад нэвтрүүлэн оруулж самуун дэгдээх, дээрэм тонуул үйлдэх, хорлон сүйтгэх, алаан хядах үйл ажиллагаа явуулах.

Монгол Улс батлан хамгаалах зорилтоо хэрэгжүүлэхдээ үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлалыг үндэс болгон улс төр-дипломатын аргыг урьдал болгоно.

Дэлхий дахины хэмжээнд болон Ази-Номхон далайн бүс нутагт аливаа дайн, зэвсэгт мөргөлдөөнийг сэрэмжлэн зайлуулах, хамтын аюулгүй байдлын тогтолцоог бүрдүүлэхэд идэвхтэй оролцох, олон түнштэй байх, үндэснийхээ язгуур ашиг сонирхлыг дээдэлж аюулгүй байдлаа улс төрийн аргаар хангах гадаад бодлогыг тууштай явуулах нь Монгол Улсын төрийн эрхэм зорилт байна.

Монгол Улс нутаг дэвсгэрээ цөмийн зэвсэггүй бүс болгож түүнийг олон этгээдийн баталгаагаар бэхжүүлэх, цөмийн зэвсгийн туршилтыг хориглох, үл дэлгэрүүлэх горимыг чанд сахнуулах бодлого, үйл ажиллагаанд идэвхтэй оролцохыг эрхэмлэнэ.

Монгол Улс үй олноор хөнөөх бусад зэвсгийг бүтээх, үйлдвэрлэх, нөөцлөн хуримтлуулах, хэрэглэхийг хориглох болон тэдгээрийг устгах олон улсын хүчин чармайлтыг идэвхтэй дэмжиж, энэ талаар бусад улс орон, олон улсын байгууллаагатай хамтран ажиллана.

Дэлхийн улс орнуудтай, нэн ялангуяа хөрш түрнүүдтэй бүх талын найрсаг харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлж, цэргийн итгэлцлийг бий болгох, үндэснийхээ язгуур ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөх аливаа үйл ажиллагаанаас зайлсхийх, сэргийлэх, түүнийг арилгах замаар гаднын цэргийн заналхийлэл үүсэх шалтгаг, шалтгаан гаргуулахгүй байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын зэвсэгт хүчин, олон улсын цэргийн байгууллага болон нөлөө бүхий улс орнуудтай цэргийн харилцаа тогтоож хөгжүүлнэ.

Батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог бүрдүүлэн бэхжүүлж, зэвсэгт хүчин, бусад цэргийн чадавхийг дээшлүүлэхэд анхаарна.

Монгол Улсын төр Үндсэн хуулиар тогтоогдсон төр, нийгмийн байгууллын үндэс, үндэсний эв нэгдлийн эсрэг чиглэсэн дотоодын нийтийн эмх замбараагүй байдал, зэв-

ит мөргөлдөөн гаргуулахгүй байх хатуу бодлого баримална.

Монгол Улсын эдийн засгийн эрчимтэй хөгжил, ямар ч үед биеэ дааж амьдрах чадавхи, шинжлэх ухаан-технологийн дэвшил, хүн амын эрүүд мэнд, боловсрол, мэргэжлийн идэр түвшин, цэргийн бэлтгэл, эх оронч үзэл зэрэг нь улсын батлан хамгаалах чадварын суурь үндэс мөн.

Монгол Улс тайван цагт улс орныхоо батлан хамгаалах зэрэгцээ шаардлага, эдийн засгийн боломжид нийцсэн цомтон, чадварлаг зэвсэгт хүчин, бусад цэрэгтэй байна.

Зэвсэгт хүчин, бусад цэргийн чиг үүрэг, байгуулалтын зарчим, бүтэц, зохион байгуулалт, удирдлага болон түүнд илба хлах журмыг хуулиар тогтоож байна.

Ерөнхий зориулалтын цэрэг нь зэвсэгт хүчний үндсэн төм, улс орныг батлан хамгаалах зорилтыг цэргийн хүчээр сэргэжүүлэх гол хүч мөн.

Ерөнхий зориулалтын цэрэг нь тайван цагт үйл ажиллагаагаа зэвсэгт хүчнийг дайчилгаагаар өргөтгөн зохион байгуулах боломжийг хангах, хүн амыг цэргийн хэрэгт сургаж бэлтгэх боловсон хүчний нөөцийг бүрдүүлэх, зэвсэг, байлдааны техник, нөөц материал, хэрэгслийн хадгалаалт, хамгаалаалт, үйлчилгээг зохион байгуулахад чиглүүлдэг.

Улсын агаарын довтолгооноос хамгаалах цэрэг нь тайван ба дайны цагт улсын агаарын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, улс орны эдийн засаг, засаг захиргааны төв болон бусад чухал бүс нутгийг дайсны дайралтаас халхлан хамгаална.

Барилгын цэрэг нь тайван цагт барилдаа, байгууламжийн ажил гүйцэтгэхийн зэрэгцээ шаардлагатай үед дайчилгааны даалгавраар хүдээсэн үүргээ биелүүлэх бэлтгэлтэй байна.

Иргэний хамгаалалтын цэрэг нь тайван ба дайны үед үйлдлийн хөдөөх зэвсгийн хөдөөд, хүн амын аюулгүй байдалд заналхийлж хүний амь олноор үрэгдэх, эрүүд мэнд хохирох, эд хөрөнгө үлэмж хэмжээгээр сүйрэхэд хүргэдэг байгалийн болон нийтийг хамарсан гамшиг, үйлдвэрийн томоохон ослоос үүссэн хөнөөлийн голомтод лэрэх ажил явуулах, хор уршгийг арилгахад оролцох үүрэгтэй байна.

Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн нь зэвсэгт хүчнийг дайчилгаагаар өргөтгөн зохион байгуулахад болон байлдааны үеийн дохирлыг нөхөн хангахад зориулагдах бөгөөд цэргийн бэлтгэл үүрэгтэн иргэдэж бүрдэнэ.

Хилийн цэрэг нь тайван пагт улсын хил хамгаалах, хил зөрчигчийг эрэх, саатуулах, дайны үед улсын хилийг хориглон хамгаалах, хил дээрх зэвсэгт халдлагыг няцаах, дайсны татнуул-хорлон сүйтгэх бүлгийг устгах зэрэг үүрэг гүйцэтгэнэ.

Дотоодын цэрэг нь тайван болон оюу байдлын үед улсын оюу чухал объектыг хамгаалах болон хууль тогтоомжоор ноогдуулсан бусад үүрэгтэй байна.

Зэвсэгт хүчин, бусад цэрэг нь болзошгүй түрэмгийллийг няцаах үүргийг биелүүлэхэд шаардагдах бэлтгэлийг тайван пагт зохих ёсоор хангасан байна.

Монгол Улс гаднын зэвсэгт түрэмгийлэлд өртвөл түүнийг янцаах, өөрийгөө хамгаалах дайныг өөрийн бүх хүч хэрэгсэл, боломжийг нэгтгэн дайчилж нийт ард түмний оролцоонд тулгуурлан явуулна. Тэгэхдээ Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн дагуу бусад улс орон, олон улсын байгууллагын тусламж дэмжлэгийг авч болно.

Монгол Улсын цэргийн номлолыг хэрэгжүүлэхэд төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, нийт аж ахуйн нэгж, байгууллага, иргэд идэвхтэй оролцоно.

Монгол Улсын цэргийн номлолыг хэрэгжүүлэх явдлыг хууль тогтоомжоор зохицуулж, түүний биелэлтэд Монгол Улсын Ерөнхийлөгч хяналт тавина.

Монгол Улсын цэргийн номлол нь дэлхий дахины болон бүс нутгийн цэрэг-улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан, техник, цэргийн хэрэгт гарч байгаа өөрчлөлттэй уялдуулан тодотгогдож байна.

МОНГОЛЫН ЦЭРГИЙН НОМЛОЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

ЭРХЭМ

— — — — —

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЯЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1994 оны 7 дугаар
сарын 05-ны өдөр

Дугаар 69

Улаанбаатар
хот

**Ж. ДҮГЭРТ МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ
БАГШ ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ**

Хүүхэд, залуучуудын болон боловсролын байгууллагад үр бүтээлтэй ажиллаж зах зээлийн харилцааны шилжилтийн үеийн хүнд нөхцөлд өнчин хүүхэд асран хүмүүжүүлэх төвийн материаллаг баазыг бэхжүүлэх, тэдний сурах, ажиллаж амьдрах авьяас чадварыг хөгжүүлэх, хөдөлмөрийн дадлага олгох орчинг шаардлагын түвшинд бүрдүүлэх ажлыг оновчтой зөв зохион байгуулахад санаачилгатай ажиллан өндөр амжилт гаргаж байгааг үнэлж Хүүхэд асран хүмүүжүүлэх төвийн захирал Жамъяншаравын Дүгэрт Монгол Улсын ГАВЬЯАТ БАГШ цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЯЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1994 оны 7 дугаар
сарын 05-ны өдөр

Дугаар 70

Улаанбаатар
хот

**ЗАРИМ БАГШ, АЖИЛЧДЫГ ОДОН,
МЕДАЛИАР ШАГНАХ ТУХАЙ**

Боловсролын байгууллагад үр бүтээлтэй ажиллаж хүүхэд, залуучуудыг сурган хүмүүжүүлэх, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх үйлсэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж их, дээд сургууль, колледж, ерөнхий боловсролын

зарим сургуулийн дор дурдсан багш, ажилчдыг одон, медалиар шагнасугай.

ХӨДӨЛМӨРИЙН ГАРЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Улсын багшийн их сургуулийн судалгаа аргачлалын институтийн орлогч захирал Дамбын **ШАГДАР**

Бүх шатны сургуульд заах математикийн хичээлийн сургалтын арга зүйг боловсронгуй болгох, математикийн улсын олимпиадыг санаачлах, түүнийг жил бүр зохион байгуулж явуулахад идэвхтэй оролцож, олон ном, сурах бичиг туурвиж, математикийн шинжлэх ухааны суурь судалгааг хөгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан учир

2. Эдийн засгийн колледжийн багш Жамъянгийн **НЯМСҮРЭН**

Нягтлан бодох бүртгэлийн хичээлийн сургалтын хөтөлбөр, заах аргыг байнга боловсронгуй болгон, оюутны сурлагын амжилт, чанарыг дээшлүүлж, хэд хэдэн сурах бичиг бичиж, санхүү, банкны мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд чухал хувь нэмэр оруулсан учир

АЛТАН ГАДАС ОДОНГООР:

1. Монгол мэдлэгийн их сургуулийн эрдэм шинжилгээний «Арианс» төвийн захирал Чимэдийн **ДОГСҮРЭН**

Хэл шинжлэлийн болон орчуулгын олон шилдэг бүтээл туурвиж, эх орныхоо газар усны нэрийн судлалыг үүсгэнэвч, эсвэрэнго хэлийг дэлгэрүүлэх үйлсийн эх суурийг тавих, нэр томъёо оноох, тогтоох, толь бичиг зохиох аргачлалыг шинжлэх ухааны үндэслэлтэй бий болгоход чухал хувь нэмэр оруулсан учир

2. Эдийн засгийн колледжийн захирал Ринчин-нэмийн АМАРЖАРГАЛ

Колледжийг удирдлага, бүтэц, зохион байгуулалт, аж ахуй, санхүүгийн хувьд бэхжүүлэх, сургалтын агуулга, арга зүйн төвшинг дэлхийн улс орны хөгжлийн жишигт хүргэх, оюутны бие дааж сурч дадлагажих цагийг нэмэгдүүлэх, тэдний мэдлэгийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг шинээр боловсруулж, хэрэгжүүлэхэд санаачилгатай ажилласнаар сургалтын чанарт эрс өөрчлөлт гарч байгаа учир

3. Эдийн засгийн колледжийн орлогч захирал Дэндэвийн ЛИЙДАА

Урьд ажиллаж байсан Дарханы Политехникум, Улаанбаатарын Бэрлэгийн техник мэргэжлийн IV сургууль зэрэг тусгай мэргэжлийн болон техник мэргэжлийн дунд сургуулийг аж ахуй, зохион байгуулалт, боловсон хүчинээр бэхжүүлэх, одоогийн ажиллаж байгаа Эдийн засгийн колледжийн материаллаг баазыг бэхжүүлэхэд чухал хувь нэмэр оруулж байгаа учир

4. Дорнод аймгийн Хэрлэн сумын 10 жилийн 1 дунд сургуулийн бага ангийн багш Мишигдоржийн ДОЛГОРСҮРЭН

Хүүхэд бүртэй биечлэн ажиллаж, хичээлийг үзүүлэн, материал өргөн ашиглан зааж сурагчдын сурлагыг чанарын тогтвортой төвшинд байлгадаг. Дааж төгсгөсөн ангийн нь сурагчид дараагийн ангиудад тогтмол амжилттай суралцдаг болон давсан анги нь монгол хэлний улс, аймгийн олимпиадад тэргүүн байр эзэлж байсан учир

5. Ховстол аймгийн Морон сумын 10 жилийн 1 дунд сургуулийн хөдөлмөрийн багш Доржийн
ЧУЛУУНБААТАР

Мужааны кабинетыг үлгэр жишээ тохижуулан хөрөөний суурь машин, будаг шүршигч аппарат зэрэг олон тоног төдөөрөмж гар багаж санаачлан хийх, хөдөлмөрийн өргөтгөсөн сургалтыг мужаан, металл боловсруулалт зэрэг чиглэлээр бригадын хэлбэрээр зохион байгуулан явуулж сургуульдаа олон зуун мянган төгрөгийн ашиг оруулж, сурагчдад жил мэргэжлийн баримжаа олгосон болон шавь нар нь өсвөрийн техникдийн улсын уралдааны алт, мөнгө, хүрэл медалиар шагнагдаж байсан учир.

6. Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 10 жилийн III дунд сургуулийн захирал Анхайн
ТЫНЫБАП

Дунд сургуулийн захирлаар олон жил үр бүтээлтэй ажиллаж Алтанцогц сум, Өлгий сумын 2, 3 дугаар сургуулиудын сурлага, хүнүүжлийн ажил, тохижилтыг аймгийн тэргүүний сургуулиудын хэмжээнд хүртэл сайжруулсан учир.

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Хөдөө аж ахуйн үндэсний их сургуулийн бэгш Цогтын СОД-
НОМЦЭРЭН

Өөрийн санаачилга, оролцоотойгоор тус улсад анх удаа гэхай, шувууны аж ахуйгаар дагнан мэргэжсэн мал зүйчдийг бэлтгэн мэргэжлийн чиглэлээр олон ном сурах бичиг туурвисан учир.

Гадаад хэлний дээд сургуулийн багш Эмээлийн ДАНДОНДОГ

Гадаад хэлний дээд сургуулийн багш Самдангийн ТӨМӨР-ОЧИР

Монгол Улсын Үндэсний их сургуулийн үйлчлэгч Даалжавын ДОЛГОР

Эдийн засгийн колледжийн үйлчлэгч Лодонгийн ХУЛГАНА

Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын 10 жилийн дунд сургуулийн багш Төмөрбекийн АБУТАЛИВ

Дээд сургуулийн орос хэлний багш, тэнхимийн эрхлэгч, деканаар олон жил үр бүтээлтэй ажиллаж, хичээлийн программ, журам олныг боловсруулж сургалтад нэвтрүүлсэн, төв, орон нутгийн сонинд зуу шахам хичээл бичиж хэвлүүлсэн, сурах бичиг болон орчуулгын хэд хэдэн ном бичсэн учир

Дээд сургуулийн багш, тэнхимийн эрхлэгчээр олон жил үр бүтээлтэй ажиллаж, орос-монгол хэлний харьцуулсан судаллын асуудлаар олон арван өгүүлэл, сурах бичиг болон орчуулгын хэд хэдэн ном бичиж сургалтын чанарыг сайжруулсны учир

Тус сургуульд 33 жил үйлчлээр ажиллаж үйлчилгээ, нэвэрлэгээг тогтмол чанартай сайн хийдэг, олон арван залуу ажилчдыг халамжлан хүмүүжүүлсэн учир

Тус колледжид 31 жил үйлчлэгчээр ажиллаж үйлчилгээ нэвэрлэгээг тогтмол чанартай хийдэг, нэвэрлэгээний материалыг хэмжээлтэй зарцуулдаг, өөрийн саналчилгаар сургуулийн байр танхимын урсгал засварыг хийж сургуульд олон мянган төгрөгийн хэмнэлт оруулсан учир

Дэлүүн сумын сургуулийн бага ангийн багшаар 32 жил тогтвор суурьшилтэй, үр бүтээлтэй ажиллаж бага ангид хэрэглэх иж бүрэн үзүүлэн, үл-

7. Дорнод аймгийн Даш-балбар сумын дунд сургуулийн математикийн багш Даш-нимын ДАНДОРЖ

8. Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын дунд сургуулийн физикийн багш Дуйнхаржавын ЯНЖМЛА

гэр жишээ тохижуулсан кабинет бий болгож, нэгдүгээр ангид математикийн хичээл заах тэргүүний арга барил эзэмшин бусад багш нарыг дагалдуулан сургахад идэвх зүтгэл гаргаж ажилласан учир

Математикийн хичээлийн үр өгөөжийг дээшлүүлэхэд бүтээлч эрэл хийж тулгуур дохио, онолын мэдлэгийг багцлах зэрэг аргыг хэрэглэснээр сурагчдын математикийн мэдлэг тогтвортой амжилтад хүрч, шавь нараас нь улс, аймгийн математикийн олимпиадад амжилттай оролцож эхний байрууд эзэлж байсан, өөрөө сурган хүмүүжүүлэх төв уншлагад байр эзэлж байсан учир

Физикийн кабинетыг иж бүрэн тохижуулж, хичээлийн сэдэв бүрээр шүүдэг авах, сурагчдаар өөрсдийг нь харилцан шалгуулах, маргаан ириллага явуулах зэрэг сургалтын арга хэлбэрүүдийг хэрэглэснээр тэдний сурлагын амжилт, чанар тогтворжиж, шавь нар нь их дээд сургуулийн уралдаант шалгалт, физикийн хичээлийн аймаг, улсын олимпиадад амжилттай оролцож байсан учир

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ

1994 оны 7 дугаар

Дугаар 71

Улаанбаатар

арын 6-ны өдөр

хот

ДҮРЭМ БАТЛАХ ТУХАЙ

1. Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Иргэний цэргийн дүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь заалтыг үндэслэн «Цэргийн цол олгох дүрэм»-ийг хавсралтын босоор баталсугай.

2. Энэ зарлиг гарахаас өмнө цэргийн цол авсан хүмүүсийн цолыг бууруулахгүй байхаар тогтоосугай.

3. Энэ зарлиг гарсантай холбогдуулан «Дүрэм батлах тухай» Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1992 оны 7 дугаар сарын 14-ний өдрийн 102 дугаар зарлигийг хүчингүй болсонд тооцсугай.

4. Цэргийн албан хаагчдын албан тушаалын ангилал, цэргийн цолны зэрэглэлийн уялдааг энэ дүрэмд нийцүүлэх арга хэмжээг 1995 онд багтаан авахыг Батлан хамгаалахын сайд (н. Жадамбаа), Тэгнүүлын төв газрын дарга (н. Сандар), Хилийн цэргийг удирдах газрын дарга (н. Сүндэв), Цагдаагийн ерөнхий газрын дарга (н. Пүрэв), Хорих байгууллагуудыг удирдах газрын дарга (н. Дэндэв)-д даалгасугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1994 оны
71 дугаар зарлигийн хавсралт

ЦЭРГИЙН ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт, Монгол Улсын аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт, Хорих байгууллагын болон хорих ил эдлүүдэх тухай Монгол Улсын хуулийн 16 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалт, Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг үндэслэн Монгол Улсын Зэвсэгт хүчин, бусад цэргийн албан хаагч, нэгдүгээр цэргийн цэргийн үүрэгтэн, Тагнуулын төв байгууллагын тусгай албаны болон бусад ажилтан, Хорих байгууллагын ажилтан, Цагдаагийн удирдах албан тушаалтанд цэргийн цол олгохдоо энэхүү дүрмийг баримтална.

2. Цэргийн албан хаагчдын албан тушаал бүр цэргийн захирах, захирагдах зэрчмыг нарийн зааглаж ялгасан цэргийн цолтой байх бөгөөд энэ нь тухайн албан тушаалын ангиллыг илэрхийлнэ.

3. Цэргийн албан хаагчид цэргийн цолыг өдөр тутам хэрэглэж, хууль тогтоомжид элсэны дагуу зохих мөнгөн хангамж эдэлнэ.

Хоёр. Цэргийн цол олгох

4. Монгол Улсын Зэвсэгт хүчин, бусад цэргийн офицер, эрлэгчийн албан тушаалд томилогдсон цэргийн албан хаагч, хууль тогтоомжид заасан бол бусад байгууллагын холбогдох албан тушаалтанд албан тушаалын нь ангилалд тохирсон цэргийн цол олгоно.

5. Дээд офицерын цэргийн цол олгох санзлыг Батлан хамгаалахын сайд Монгол Улсын Засгийн газарт уламжилна. Уг асуудлыг Монгол Улсын Засгийн газар хуралдаанаараа хэлэлцэж Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлдэг.

6. Тайван цэгт зэвсэгт хүчний ахлах, дунд офицерт цэргийн цолыг Монгол Улсын Батлан хамгаалахын сайд олгоно.

Батлан хамгаалахын сайд цэргийн албан хаагчдад хурандаагаас бусад цэргийн цол олгох эрхийг тухайн албан тушаалтанг томилох эрх бүхий захирагч, даргад олгож болно.

7. Тайван цагт бусад цэргийн ахлах, дунд офицерт цэргийн цолыг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тухайн цэргийн дарга олгоно.

8. Зэвсэгт хүчний ахлагч нарт ахлагчийн цэргийн анхны цолыг Зэвсэгт хүчний ерөнхий штабын дарга, ээлжийн цолыг шууд захирсан анги, нэгтгэлийн захирагч, тэдгээртэй адилтгах албан тушаалтан олгоно.

Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол бусад цэргийн ахлагч нарт ахлагчийн цэргийн анхны цолыг тухайн цэргийн дарга, ээлжийн цолыг шууд захирсан анги, байгууллагын захирагч, дарга олгоно.

9. Байлдагч, түрүүч нарт албан тушаалын цэргийн цолыг нэгтгэл, ангийн захирагч олгоно.

10. Хууль тогтоомжид звасны дагуу цэргийн албан хаагчидтай адилтгах албан тушаалын ангилал, цолны зэрэглэл хэрэглэдэг байгууллагын хоолбогдох албан тушаалтанд цэргийн цолыг тухайн байгууллагын дарга олгоно.

11. Офицер, ахлагчийг албан тушаал дэвшүүлж цэргийн цол олгохдоо тухайн томилох албан тушаалд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлсон шалгуур үзүүлэлтээр шалгалт авна. Шалгалт авах журмыг Батлан хамгаалахын сайд, бусад цэргийн дарга, хууль тогтоомжид звасны дагуу цэргийн албан хаагчидтай адилтгах албан тушаалын ангилал, цолны зэрэглэл хэрэглэдэг байгууллагын дарга тогтооно.

12. Офицер, ахлагчид цэргийн цол олгох асуудлыг анги нэгтгэл, байгууллагын захирагч, дарга зохих журмаар шийдвэрлэх буюу цол олгох үндэслэл, тодорхойлолт, саналаа удирдах дээд байгууллагад уламжилна.

13. Удирдах дээд байгууллага нь цол олгох үндэслэл, тодорхойлолт, саналыг судлан үзэж, тогтоосон журмын дагуу шалгалт авч шийдвэрлэнэ.

Гэхдээ сургууль, дамжаа төгсч анх офицер, ахлагчийн албан тушаалд томилогдож байгаа хүмүүст офицер, ахлагчийн анхны цол олгоно.

Хэрвээ тэдний албан тушаалын цолны зэрэг нь офицер, ахлагчийн анхны цолноос дээгүүр байвал ажлын амжилт, үр дүнг харгалзан дараагийн цол олгож болно.

14. Иргэний байгууллагад ажиллаж байгаад офицерын албан тушаалд томилогдох тохиолдолд албан тушаалын шалгуур үзүүлэлтийн дун, тухайн албан тушаалын цолны зэргийг харгалзан дунд офицерын цэргийн цол олгоно.

Хэрвээ тэдний албан тушаалын цолны зэрэг нь дунд офицерын цолноос дээгүүр байвал ажлын амжилт, үр дүнг харгалзан дараа дараагийн цол олгож болно.

15. Нэгдүгээр зэргийн цэргийн үүрэгтэнд оногдуулан данслагдсан албан тушаалын хүрэндаагаас бусад цолыг сургууль, цугларалтын дүнгээр олгож болно.

Гурав. Цэргийн цолыг хасах, бууруулах

16. Дээд офицерын цэргийн цолыг Монгол Улсын Ерөнхийлөгч, ахлах болон дунд офицерын цолыг түүнийг олгосон албан тушаалтан тус тус хасах эрхтэй.

17. Монгол Улсын Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 4, 5-д заасны дагуу цэргийн жинхэнэ албанаас бэлтгэлээр халагдсан офицер, ахлагчийн, түүвчлэн хууль тогтоомжид заасны дагуу цэргийн албан хаагчидтай адилтгаж албан тушаалын ангилал, цолны зэрэглэл хэрэглэдэг байгууллагын албаны дүрэм, сахилгыг удаа дараа зөрчсөн, гэмт хэрэг үйлдэж хорих ялаар шийтгүүлсэн ажилтны цэргийн цолыг хасч болно.

18. Тухайн албан тушаалад тэнцэхгүй байгаа офицер, ахлагч өөрөө албан тушаал буурч ажиллахыг хүсвэл түүний цэргийн цолыг бууруулж томилсон албан тушаалын цэргийн цол олгоно. Улс төрийн шалгуураар томилогддог албан тушаалтан ажлаасаа өөрчлөгдөх тохиолдолд цолыг бууруулахгүй.

19. Цэргийн цолоо хасуулсан хүн офицер, ахлагчийн албан тушаалд дахин ажиллах тохиолдолд түүнд офицер, ахлагчийн албан тушаалын дээд цол олгоно.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1994 оны 7 дугаар

Дугаар 72

Улаанбаатар

сарын 06-ны өдөр

хот

**ДЭЭД ОФИЦЕРЫН АЛБАН ТУШААЛЫН
АНГИЛАЛ, ЦЭРГИЙН ЦОЛНЫ ЗЭРЭГЛЭЛИЙГ
ТОГТООХ ТУХАЙ**

1. Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчдын эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг үндэслэн тайван цагийн орон тоонд байвал зохих «Дээд офицерын албан тушаалын ангилал, цэргийн цолны зэрэглэл»-ийг хавсралтын ёсоор тогтоосугай.

2. Энэ зарлиг гарсантай холбогдуулан «Дээд офицерын цолны зэрэг тогтоох тухай» Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1992 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн 106 дугаар зарлигийг хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэ зарлигийг гарсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1994 оны
72 дугаар зарлигийн хавсралт

**ДЭЭД ОФИЦЕРЫН АЛБАН ТУШААЛЫН АНГИЛАЛ,
ЦЭРГИЙН ЦОЛНЫ ЗЭРЭГЛЭЛ**

№	Албан тушаалын ангилал	Цэргийн цолны зэрэглэл
1.	Монгол Улсын Батлан хамгаалахын сайд	дэслэгч генерал-хурандаа генерал

- | | |
|--|--------------------------------|
| 2. Монгол Улсын Зэвсэгт хүчний ерөнхий штабын дарга, Батлан хамгаалахын дэд сайд | хошууч генерал-дэслэгч генерал |
| 3. Батлан хамгаалахын дэд сайд | хошууч генерал-дэслэгч генерал |
| 4. Цагдаагийн ерөнхий газрын дарга | хошууч генерал |
| 5. Тэгшүүлийн төв газрын дарга | хошууч генерал |
| 6. Монгол Улсын Иргэний хамгаалахын газрын дарга | хошууч генерал |
| 7. Барилгын цэргийн дарга | хурандаа-хошууч генерал |
| 8. Хилийн цэргийг удирдах газрын дарга | хошууч генерал |
| 9. Зэвсэгт хүчний ерөнхий штабын даргын орлогч нар | хурандаа-хошууч генерал |
| 10. Зэвсэгт хүчний ар талын дарга | хурандаа-хошууч генерал |
| 11. Улсыг агаарын довтолгооноос хамгаалах цэргийн командлагч | хошууч генерал |
| 12. Дивизийн захирагч | хурандаа-хошууч генерал |
| 13. Цэргийн их сургуулийн захирал | хурандаа-хошууч генерал |
| 14. Хилийн цэргийг удирдах газрын дэд дарга, хилийн цэргийн штабын дарга | хурандаа-хошууч генерал |
| 15. Тэгшүүлийн төв газрын дэд дарга | хурандаа-хошууч генерал |
| 16. Хорих байгууллагуудыг удирдах газрын дарга | хурандаа-хошууч генерал |

МОНГОЛ УАСЫН ЕРӨНХИЛЭГЧИЙН
ЗАРЛИГ

1994 оны 7 дугаар

сарын 06-ны өдөр

Дугаар 73

Улаанбаатар

хот

ЦЭРГИЙН ДЭЭД ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

Тагнуулын төв газрын дарга Далхжавын Сандагт хонзууч
генерал цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

Ц. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ**

1994 оны 4 дугаар

Дугаар 75

Улаанбаатар

сарын 6-ны өдөр

хот

ДҮРЭМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Хөдөлмөрийн хуулийн 57 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Түлш, эрчим хүчний салбарт ажиллагчдын сахилгын дүрмийг хавсралтын ёсоор баталсугай.

2. Энэ дүрмийг хэрэгжүүлэх ажлыг түлш, эрчим хүчний үйлдвэрүүдэд шуурхай зохион байгуулахыг Эрчим хүч, геологи, уул уурхайн яам (Б. ЖИГЖИД)-д даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий
сайд

П. ЖАСРАН

Эрчим хүч, геологи, уул
уурхайн сайд

Б. ЖИГЖИД

Засгийн газрын 1994 оны 75 дугаар
тогтоолын хавсралт

**ТҮЛШ, ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРТ
АЖИЛЛАГЧДЫН САХИЛГЫН ДҮРЭМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1. 1. Түлш эрчим хүчний үйлдвэрлэл нь улс орны эдийн засгийн аюулгүй байдлыг хангах гол нөхцөлийг бүрдүүлдэг учир тэдгээрт ажиллагчид нь сахилгын тусгай дүрэм (цаашид «сахилгын дүрэм» гэх)-ийг мөрдөж ажиллана.

1. 2. Дүрмийн зорилго нь түлш, эрчим хүчний салбарын үйлдвэрүүдэд Монгол Улсын хууль тогтоомж, үйлдвэрийн хөдөлмөрийн дотоод журам, техник ашиглаалт, аюулгүй ажиллагааны дүрэм, журам, зааврын хэрэгжилтийг ханган,

хүлээлгэх харилцлагыг тодорхойлж, ангамжийг хэвийн, найдвартай байлгахэд оршино.

үү дүрмийг тулш, эрчим хүчний үйлдгээ эрхэлж буй төрийн өмчийн болон отой аж ахуйн нэгж, байгууллагад » гэх) дагаж мөрдөнө.

й үйлдвэрлэл, хангамжийн үйл ажилрийн бусад хэлбэрийн аж ахуйн нэгж, дүрмийг мөрдөж болно.

Захиргааны үүрэг, эрх

х ажилд ороход нь тухайн албан йгууллагын хөдөлмөрийн дотоод жу-техник ашиглалт, аюулгүй ажилла(ох бусад хууль тогтоомжуудыг нэг байх;

техник ашиглалт, аюулгүй ажиллацаавруудын дагуу шалгалт авч эрхийн бөгөөд аюулгүй ажиллагааны талаар нч байх;

тушаал гүйцэтгэхтэй нь холбогдсон , журмаар хангаж, ажлын байранд

г төхөөрөмж, машин механизмын онцшаардлагын дагуу ашиглалт, засварын дрэм, журмыг шинээр буюу шинэчлэн гэхээс гадна ээлж хүлээлцэх, ээлжийн йранд ажиллах дэг, хяналт, шалгалт, аршрут, график, түүнчлэн үүрэг даал-нелүүлэх, эргэж мэдээлэх, мөн мэдээ йг хүлээн авах, эргэж мэдээлэх жу-ажиллагааны шагнал олгох нөхцөл, баталж мөрдүүлнэ.

үед мөрдөх ажиллагааны горимын үзүүлэлтүүдийг техник, тоног төхөө-эм бүрийн онцлогт тохируулан тогтоож

ны эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны иллагчдыг эрүүл мэндийн үзлэгт оруу-онцгой объектод ажиллагчдын эрүүл

үцлагыг тодорхойлж, ин, найдвартай байл-

1. эрчим хүчний үйлд-төрийн өмчийн болон нэгж, байгууллагад рдөнө.

ангамжийн үйл ажил-рийн аж ахуйн нэгж, ж болно.

2. эрх

д нь тухайн албан лмөрийн дотоод жу-лт, аюулгүй ажилла-тогтоомжуудыг нэг

лт, аюулгүй ажилла-шалгалт авч эрхийн ажиллагааны талаар

хтэй нь холбогдсон гэж, ажлын байранд

ини механизмын онц-аниглалт, засварын нээр буюу шинэчлэн хүлээлцэх, ээлжийн эг, хяналт, шалгалт, түүнчлэн үүрэг даал-мэдээлэх, мөн мэдээ эргэж мэдээлэх жу-агнал олгох нөхцөл, нэ.

иллагааны горимын техник, тоног төхөө-тохируулан тогтоож

юулгүй ажиллагааны эндийн үзлэгт оруу-ажиллагчдын эрүүл

2. 6. Технологиин ажиллагчдын ээлж
лан энэ талаар рапорт
ээр өгнө. Үүнд:

— дараагийн ээлж
дүүлэх бэлтгэлийг бү
— ажлын цаг дуу
ажлыг нарийвчлан ш
— хэрэв ажилтан
сон буюу гарсан аваа
долд түүнийг ажлаас
буюу анхан шатны
гүүэнэ;

— аваарь, зөрчил
ээлж солилцуулахыг
ажилтныг оролцуулан
дараа ээлж солилцуу

2.7. Ажлын байра
шат тутмаас дараахь
— ээлжийн ахлагч
дуусах үе, ажлын үрг
— тасаг, цехийн
түүнчлэн ажлын өдр
гүй удаа;

— үйлдвэрийн уд
тутамд ажлын гол го
бүх байраар 1 удаа
явуулана.

Үзлэг, шалгалтын
ган дүгнэж байна.

Үйлдвэрийн дотоо

2.8. Үйлдвэрийн
аваарь, осол гарсан
үүрэг даалгаврын б
болон шагнал урамш
лийн бүх төрлийн хэ
рэг)-ээр хамт олонд

2.9. Ажлын байра
дэвтэрт тухайн ажлы
шийдвэрийн талаар т
жид гарсан гэмтлийн

2.6. Технологиин тасралтгүй ажилла
ажиллагчдын ээлж солилцоход дараахь
лан энэ талаар рапорт, мэдээлэл авсны
ээр өгнө. Үүнд:

— дараагийн ээлжинд хэвийн ажил
дүүлэх бэлтгэлийг бүрэн хангуулсан ба
— ажлын цаг дуусахаас өмнө тухай
ажлыг нарийвчлан шалгасан байх;

— хэрэв ажилтан ажил үүргээ гүйцэ
сон буюу гарсан аваарь, зөрчлийг арилга
долд түүнийг ажлаас түр чөлөөлж, ө
буюу анхан шатны удирдагчаар уг аж
гүүэнэ;

— аваарь, зөрчил гарсан буюу гарч
ээлж солилцуулахыг хориглох бөгөөд
ажилтныг оролцуулан ажиллуулж аваарь
дараа ээлж солилцуулна.

2.7. Ажлын байранд хийх үзлэг ш
шат тутмаас дараахь хугацаанд хийж
— ээлжийн ахлагч, бригадын дарг
дуусах үе, ажлын үргэлжлэх хугацааны
— тасаг, цехийн удирдлага ажил
түүнчлэн ажлын өдрийн үргэлжлэх хуг
гүй удаа;

— үйлдвэрийн удирдлага, инженер,
тутамд ажлын гол гол байруудаар, 14 х
бүх байраар 1 удаа тус тус үзлэг хий
явуулана.

Үзлэг, шалгалтын дүнг 7, 14 хоног
ган дүгнэж байна.

Үйлдвэрийн дотоод хяналт, шалгалт

2.8. Үйлдвэрийн ажиллагааны явц,
аваарь, осол гарсан шалтгаан, түүний
үүрэг даалгаврын биелэлт, сахилгын
болон шагнал урамшил үзүүлсэн талаа
лийн бүх төрлийн хэрэгсэл (ханын сон
рэг)-ээр хамт олонд тухай бүр мэдээлж

2.9. Ажлын байранд гүйцэтгэсэн шу
дэвтэрт тухайн ажлын байранд ажилла
шийдвэрийн талаар тэмдэглэж байхыг х
жид гарсан гэмтлийн талаар тусгай д

рүүдийг бүрэн бүтэн байлгаж хадгалуулах бөгөөд дэвтрийн хуудсыг дугаарласан байна.

2. 10. Үзлэг, шалгалт хийсэн, үүрэг, даалгавар, шийдвэр хүлээн авч биелүүлсэн, ажил гүйцэтгэсэн тухайгаа тусгай дэвтэрт тэмдэглэх бөгөөд энэ нь ажлыг хугацаанд нь чанартай эвч гүйцэтгэсэн эсэхийг тодорхойлох баримт болно.

Гурав. Ажилтны үүрэг, эрх

3. 1. Гүйцэтгэх ажил, албан тушаалд тохирсон мэргэжил эзэмшиж, техник ашиглалт, аюулгүй ажиллагааны арга барилд суралцан шалгалт өгч, мэргэжлийн ба аюулгүй ажиллагааны зохих зэрэглэлийн эрхийн үнэмлэх авсан, байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, холбогдох дүрэм, заавруудыг судалж мэдсэн байна.

3. 2. Ажилтан өөрийн мэдлэг чадвар хүрэхгүй ажлыг дур мэдэн гүйцэтгэж болохгүй бөгөөд энэ дүрмийн 3, 1-д заасан шаардлагыг зөрчиж ажил, үйлдэл гүйцэтгэх даалгавар авч болохгүй.

3. 3. Тухайн ажлын байранд танигдах шаардлагыг биелүүлж тогтоосон хугацаанд эрүүл мэндийн үзлэгт орсон байна.

3. 4. Ажилд орох бүртээ аюулгүй ажиллагааны зэрэглэлийн үнэмлэх (шаардлагатай бол эрүүл мэндийн дэвтэр)-ээ шалгуулна.

3. 5. Ажлын байранд шуурхай ажиллагааны дэвтэр, үүрэг, шийдвэрийн дэвтэр, техник, тоног төхөөрөмжид гэмтэд гарсныг тэмдэглэх дэвтэр болон бусад бичиг баримтыг тогтоосон журмын дагуу хөтөлж, тэдгээрийг байнга бэлэн, бүрэн бүтэн байлган, үйлдвэр, цех, тасгийн удирдлагад тухай бүр танилцуулж, энэ тухай гарын үсэг зуруулан авч байна.

Удирдлагаас амаар болон бичгээр өгсөн үүрэг, шийдвэр бүрийг үүрэг, шийдвэрийн дэвтэрт тэмдэглэнэ.

3. 6. Ажилтан ажлын ээлж эхлэхээс 20-ноос доошгүй минутын өмнө ажлаа хүлээж авах бөгөөд хүндэтгэн үзэх шаалгааны улмаас ажилд ирж чадахгүй тохиолдолд 4-өөс доошгүй цагийн өмнө шууд удирдах ажилтандаа мэдэгдэж зөвшөөрөл авна.

3. 7. Тоног төхөөрөмж, машин механизм бүрт тогтоосон горимд заасан техник-эдийн засгийн горимын тогтоосон үзүүлэлтийг мөрдөж ажиллуулна.

3. 8. Ажлын байр, машин механизм, тоног төхөөрөмжид байнга үзлэг үйлчилгээ хийж, эрүүл ахуй, аюулгүй ажилла-

гааны зохих нөхцөлийг бүрдүүлж ажиллана. Үзлэг, үйлчилгээ хийсэн тухай тусгай дэвтэрт тэмдэглэн, удирдлагадаа танилцуулж мэдээлнэ.

3. 9. Хариуцсан ажилтай нь холбогдуулан бүх шатны удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг гүйцэтгэж, биелэлтийг хугацаанд нь эргэж мэдээлж байна.

3. 10. Ажиллагааны явцад тоног төхөөрөмж, машин механизмд гарсан эвдрэл, гэмтлийн талаар, болон түүнд хүргэж болзошгүй нөхцөл байдлын талаар түүнчлэн хэвийн бус бусад ажиллагааны талаар цаг тухайд нь дээд шатны удирдах албан тушаалтанд мэдэгдэж байхын дээр өөрийн хариуцаагүй ажлын байр, машин тоноглолын гэмтэл согогчийн талаар мэдсэн бол тэр даруй удирдах албан тушаалтанд мэдээлнэ.

3. 11. Үйлдвэрлэлийн аваарь, саатлыг арилах ажил оролцуулахаар дуудсан тохиолдолд анхны дуудлагаар ажлын байранд хүрэлцэн ирнэ.

3. 12. Хариуцсан ажилтай нь холбогдуулан олгосон ажлын хувцас, хамгаалах багаж хэрэгсэл, бусад зүйлийг зориулалтын дагуу гэмтэй хэрэглэнэ.

3. 13. Мэдээ, мэдээлэл өгөх, хэрэглэгчдийн эрэлт, хүсэлт хүлээж авах, хариу өгөхдөө аль болох бага хугацаанд товч тодорхой ярьж харилцана.

3. 14. Ээлж солилцох, ажил хүлээлцэх бүрт ээлж солигчид ажлын байр нэг бүрээр заавал хамтаа явж, тоног төхөөрөмж бүрийг хүлээлцэх бөгөөд ажлын байр эзэнгүй орхих, ажлын байранд унтах, тослох, бусадтай ирээж хуучлах, дуу чимээ гаргах, хөгжмий сонсох, телевиз үзэх, ном, сонин унших, гаргасан буюу илэрсэн зөрчил дутагдлыг нуун дарагдуулах, эвлэрэн хаацайлах зэргийг хатуу хориглоно.

Ээлж хүлээж авах хэвийн нөхцөл бүрдээгүй гэж үзвэл ээлж хүлээж авахаас татгалзах бөгөөд хэрвээ хүлээж авсан бол түүнээс үүдэх хариуцлагыг ээлж хүлээн авагч хариуцна.

3. 15. Ээлжийг дуусгалгүй хүлээлцэх, ажлын байрнаас гур хугацаагаар мөлдөх заналгүй шаардлага гарвал энэ тухайгаа удирдлагадаа мэдээлж, түүнээс зөвшөөрөл авна.

Дөрөв. Сахилгын зөрчил, хүлээлгэх, хариуцлага

4. 1. Монгол Улсын Хөдөлмөрийн болон бусад хууль тогтоомж, байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээ, ажилтны албан тушаалын

зааварт зэвсэж ажил, шаардлагууд болон техник ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрэм, заавруудыг зөрчсөн үйлдлийг сахилгын зөрчил гэж үзнэ.

4.2. Зөрчил гаргасан ажилтанд байгууллагын даргын тушаалаар дор дурдсан сахилгын шийтгэлийг ногдуулана.

а) сануулах;

б) сарын цалинг 3 хүртэл сарын хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах;

в) ажлаас халах.

4.3. Ажилтанд сахилгын шийтгэл ногдуулахад дараахь чиглэлийг баримтална. Үүнд:

а) анх удаа сахилгын зөрчил гаргасан буюу зөрчлийн улмаас бага хэмжээний хохирол учруулсан ажилтныг сануулах буюу цалинг нь бууруулах;

б) хөдөлмөрийн сахилгыг удаа дараа зөрчсөн, ажлын байранд согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн, ажилдаа согтуу ирсэн, үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжийг тоносон, эд ангийг хуагайлсан, эд хөрөнгө залуусан, өөрийн буруугаар нэг төрлийн аварга давтан гаргасан, хүндэтгэх шалтгаангүйгээр дараалсан 3 өдөр буюу сарын дотор нийлбэр дүнгээрээ 6 ба түүнээс дээш өдрийн ажил тасалсан бол ажлаас халах;

в) нэг зөрчилд сахилгын шийтгэл давхардуулан ногдуулж болохгүй бөгөөд сахилгын шийтгэл ногдуулснаас хойш 1 жилийн хугацаанд дахин сахилгын зөрчил гаргаагүй бол уг ажилтныг сахилгын шийтгэлгүйд тооцно.

4.4. Мэргэжлийн болон аюулгүй ажиллагааны зэргийн шалгалт өгөх хугацаа хэтрүүлсэн, техник ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрмийг ноцтой, эсвэл удаа дараа зөрчсөн бол тухайн ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээг үндэслэн мэргэжлийн зэргийг нь тохирох зэрэгт хүртэл бууруулж буюу бага цалинтай ажилд нийлжүүлж, албан тушаалыг нь бууруулж болно.

4.5. Захиргаа нь хөдөлмөр, технологийн сахилга зөрчсөний улмаас техник, тоног төхөөрөмж, машин механизмыг эвдэж хохирол учруулсан ажилтнаар уг хохирлыг төлүүлэх тухай асуудлыг Хөдөлмөрийн хууль, тогтоомжийн дагуу холбогдох шатны шүүхийн байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

4.6. Захиргаа ба ажилтан нь Монгол Улсын хууль тогтоомж, энэхүү дүрэм, хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих

ёсоор биелүүлээгүйгээс учруулсан хохирлыг харилцагч нөгөө талын болон хуулийн байгууллагын өмнө шууд харууцна. Тухайн зөрчил гаргасан ажилтан болон түүнд шууд буюу гүйцэтгэлийн хяналт тавьж ажиллах ажилтан хохирлыг гэм буруугийнхад хэмжээгээр харууцна.

4. 7. Дагалдан ажиллагч нь энэхүү дүрмийн шаардлагыг биелүүлж ажиллах боловч энэхүү дүрмийн дагуу харууцлага хүлээхгүй.

Тав. Бусад зүйл

5. 1. Сахилгын шийтгэлийн талаархи гомдлоо ажилтан шүүхэд гаргаж болно.

5. 2. Сахилгын шийтгэлийн талаар гомдол гаргасан нь түүнийг биелүүлэхээс татгалзах үндэслэл болохгүй.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 4 дүгээр

Дугаар 76

Улаанбаатар

сарын 6-ны өдөр

ХОТ

АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Архидан согтууралттай тэмцэх тухай Монгол Улсын хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Архидан согтууралт үүсэн гарч байгаа нийгэм, эдийн засаг, ёс-суртахууны учир шалтгааныг үндэслэлтэй судалж, түүнийг таслан зогсооход чиглэсэн арга хэмжээг холбогдох ам, тусгай газар болон шинжилгээ судалгааны байгууллагуудыг оролцуулан 1994 оны II улиралд багтаан боловсруулж хэрэгжүүлэхийг Хууль зүйн сайд Н. Лувсанжавт даалгасугай.

2. «Согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэхэд зөвшөөрөл олгох, хяналт тавих журам»-ыг I дүгээр хавсралтын, «Согтууруулах ундаа импортлох, худалдах, түүгээр үйлчлэх,

хяналт тавих журам»-ыг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

3. Эрүүлжүүлэх байрын хүчин чадлыг нэмэгдүүлэх, унаагаар хангах асуудлыг 1994 оны эхний хагаст багтаан шийдвэрлэхийг нийслэлийн Засаг дарга Ц. Баасанжав, Цагдаагийн ерөнхий газар (Б. ПҮРЭВ)-т үүрэг болгосугай.

4. Аймгийн Засаг дарга, хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны дарга нарт даалгах нь:

а) эрүүлжүүлэх байрыг тохижуулах, зохих унаагаар үйлчлэхэд шаардагдах зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсүгэй;

б) нэгдсэн эмнэлэгт наркологийн тусламж үзүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлсүгэй.

5. Архид довтох өвчтэй хүмүүсийг эмчлэх мэргэжлийн боловсон хүчин, эм, хэрэгслээр хангах арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн яам (П. НЯМДАВАА)-д даалгасугай.

6. Импортлохыг хориглох согтууруулах ундааны жагсаалт, согтууруулах ундааны стандартын шалгуур үзүүлэлтийг стандартчилал, эрүүл ахуйн мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн энэ оны II улиралд багтаан баталж гаргахын хамт шаардлагатай тодотгол, өөрчлөлтийг тухай бүр хийж байхыг Худалдаа, үйлдвэрийн яам (Ц. ЦОГТ)-д үүрэг болгосугай.

7. Архидан согтуурахын хор хөнөөлийг сурталчилсан сурталчилгааг тогтмол нэвтрүүлж байхыг Радио, телевизийн хэрэг эрхлэх газар (Б. ӨВГӨНХҮҮ)-т даалгасугай.

8. Төрийн хүндэтгэлийн доог барих болон ёслол хүндэтгэлийн бусад арга хэмжээг зохион байгуулахад согтууруулах ундаа хэрэглэх журмыг 3 дугаар хавсралтын ёсоор баталсугай.

9. Энэ тогтоол гарсантай холбогдуулан:

а) «Тогтоолын заалтад өөрчлөлт оруулах тухай» Засгийн газрын 1993 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 24 дүгээр тогтоол, «Журам, жагсаалт батлах тухай» Засгийн газрын 1991 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 260 дугаар тогтоолыг 2 дугаар хавсралтын «Архи, бусад төрлийн согтууруулах ундаа бэлтгэх» гэсэн хэсгийг тус тус хүчингүй болгосугай;

б) «Зарим нэрийн барааг улсын хилээр нэвтрүүлэхийг журамлах тухай» Засгийн газрын 1993 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тогтоолыг 2 дугаар хавсралтад дараахь нэмэлт оруулсугай:

Бариа бүтээгдэхүүний нэр	Хилээр нэвтрэх алба	Тодорхойлолт олгох байгууллаага
8. Спирт	Оруулах	Хүнс, хөдөө аж ахуйн яам
9. Спиртаас бусад бүх төрлийн согтууруулах ундаа	Оруулах	Аймаг, нийслэлийн Засаг дарга, хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны дарга

Монгол Улсын Ерөнхий сайд
Хууль зүйн сайд
Хүнс, хөдөө аж ахуйн сайд
Худалдаа, үйлдвэрийн сайд

П. ЖАСРАЙ
Н. ЛУВСАНЖАВ
Ц. ӨӨЛД
Ц. ЦОГТ

Засгийн газрын 1994 оны 76 дугаар тогтоолын 1 дүгээр хэсрэлт

СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭХЭД ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. «Архидаг согтуурахтай тэмцэх тухай» Монгол Улсын хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэхэд зөвшөөрөл олгох, хяналт тавихад энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулах гадаадын төрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, олон улсын болон гадаадын үйлдвэрийн газар, байгууллагад энэ журам нэгэн адил хамаарна.

1.3. Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр согтууруулах ундаа үйлдвэрлэх, олгосон зөвшөөрлийг бусдад дамжуулан ашиглуулахыг хориглоно.

Хоёр. Зөвшөөрөл олгох журам

2. 1. Согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэхэд дараахь нөхцөлийг бүрдүүлсэн байна:

а) үйлдвэрлэлийг ажиллуулах нэгэлтийн үйлдвэрлэлийн мэргэжлийн хүнийг бэлтгэсэн байх;

б) ажилчдад мэргэжлийн зөвлөмж, зааварчилгаа өгч тодорхойлолт гаргасан байх;

в) эрүүл ахуй, ариун цэвэр, техникийн болон галын аюулгүй байдал, даралтат савны ашиглалтын шаардлагыг хангаж, мэргэжлийн холбогдох байгууллагаар шалгуулж дүгнэлт гаргуулсан үйлдвэрлэлийн байртай байх;

г) бүтээгдэхүүн үйлдвэрлэх техник, технологийн баталгааг хангах, үүний тулд суурилуулах тоног төхөөрөмжийн техник, технологийн баталгаат үзүүлэлт, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд мөрдөх батлагдсан стандарт, технологийн болон лабораторийн шинжилгээний заавар, ариун цэвэр, техникийн аюулгүй ажиллагааны дүрэм, бүтээгдэхүүний чанарын өдөр тутмын хяналт явуулах лабораторийн нөхцөл, хэрэглэх багаж төхөөрөмж, урвалжийг бүрдүүлж, энэ тухай тодорхойлолтыг гаргасан байх;

д) үйлдвэрийн барилга, инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн угсралтын зургийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж батлуулсан байх.

2. 2. Согтууруулах ундаа үйлдвэрлэх тухай өргөдлийг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана. Өргөдөлд үйлдвэрлэл эрхлэх нөхцөлийг хангасан тухай баримт бичгүүд, үйлдвэрлэлийн эдийн засгийн тооцоо, тухайн орон нутгийн Засаг даргын санаал, тодорхойлолтыг хавсаргасан байна.

2. 3. Өргөдлийг Хүнс, хөдөө аж ахуйн яам хүлээн авч энэхүү журмын дагуу хянаад шаардлага хангасан гэж үзвэл үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрөл гаргуулахаар Засгийн газарт оруулж шийдвэрлүүлнэ.

2. 4. Засгийн газраас согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрөл олгосон аж ахуйн нэгжид Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас Улсын эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын газар, тухайн орон нутгийн Засаг даргын Тамгын газар, гал түймрийг эсэргүүцэх газартай хамтран үйлдвэрийн байр, технологийн тоног төхөөрөмжийн угсралт, лабораторийн нөхцөл, ариун цэвэр, эрүүл ахуй, техникийн болон галын аюулгүй байдлыг шалгаж дүгнэлт гаргана.

Уг дүгнэлтийг үндэслэн зохих шаардлага хангасан аж ахуйн нэгжид Хүнс, хөдөө аж ахуйн сайдын тушаалаар үйлдвэрлэл эрхлэх гэрчилгээг олгож улсын бүртгэлд бүртгэнэ. Олгох гэрчилгээнд согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэх шийдвэр, байршил, үйлдвэрлэх бүтээгдэхүүний төрөл, бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхлэх хугаанааг заана.

Гурав. Хяналт тавих

3.1. Согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ дээжийг улирал тутамд Үндэсний стандартчилал, хэмжил зүйн төв, Улсын эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын газраар шинжлүүлэн, дүгнэлт гаргуулж байна.

3.2. Үйлдвэр нь бүтээгдэхүүнийхээ стандартад заагдсан үзүүлэлтийг үйлдвэрлэлийн технологийн үе шат бүрт тодорхойлж бүртгэл хөтөлнө.

3.3. Хүнс, хөдөө аж ахуйн яам, Үндэсний стандартчилал, хэмжил зүйн төв, Улсын эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын газар, түүний орон нутгийн салбарууд хамтран согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхэлж байгаа аж ахуйн нэгжийн техник, технологи, үйлдвэрлэлийн эрүүл ахуй, ариун цэвэр, бүтээгдэхүүний чанарт жил бүр шалгалт явуулж, дүгнэлт гарган үйлдвэрлэлийг үргэлжлүүлэх эсэхийг Хүнс, хөдөө аж ахуйн сайдын тушаалаар шийдвэрлэж байна.

3.4. Бүтээгдэхүүний чанар, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь хэрэглэгчдийн эрх ашгийг хохироож байгаа нь тогтоогдвол холбогдох мэргэжлийн хяналтын байгууллагуудаас үйлдвэрлэлийг түр зогсоож зөрчлийг арилгуулах талаар зохих арга хэмжээ авна. Зөрчлийг давтах буюу ноцтой зөрчил гаргасан нь тогтоогдвол асуудлыг нүүхийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.

Дөрөв. Бусад зүйл

4.1. Согтууруулах ундаа үйлдвэрлэх зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж нь байршлаа өөрчлөн тухайн аймаг, хотоос өөр аймаг, хотод шилжих, өөрийн салбарыг шинээр нээн ажиллуулах тохиолдолд уг үйлдвэрлэлийг шинээр эрхлэгчийн нэгэн адил материал бүрдүүлж энэхүү журмын 2 дугаар бүлэгт заасны дагуу шийдвэрлүүлнэ.

4.2. Энэ журмыг мөрдөх явцад үйлдвэрлэгч нь зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага, мэргэжлийн хяналтын бай-

гууллагуудын дүгнэлт, шийдвэрийг эс зөвшөөрч байгаа бол гомдлоо дээд шатны байгууллагад, эсвэл шүүхэд гаргаж болно. Дээд шатны байгууллага гомдлыг хүлээн авсан өдөрөөс эхлэн 14 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.

Засгийн газрын 1994 оны 76 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

СОГТУУРУУЛАХ УНДАА ИМПОРТЛОХ, ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. «Архидан согтуурахтай тэмцэх тухай» Монгол Улсын хуулийг хэрэгжүүлэх зорилгоор согтууруулах ундааг импортлох, худалдах, түүгээр үйлчлэх, хяналт тавихад энэхүү журмыг баримтална.

1.2. Олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулах гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, олон улсын болон гадаадын үйлдвэрийн газар, байгууллагад энэ журам нэгэн адил хямаарна.

Хоёр. Согтууруулах ундааг импортлох

2.1. Аж ахуйн нэгжид согтууруулах ундаа импортлох зөвшөөрлийг аймаг, нийслэлийн Засаг дарга, улсын зэрэглэлтэй хотын захиралчийн тодорхойлолтыг үндэслэн Худалдаа, үйлдвэрийн яам олгоно.

2.2. Согтууруулах ундааг импортлох зөвшөөрөл авахаас өмнө уг согтууруулах ундааны дээжийг стандартчилал, эрүүд ахуйн мэргэжлийн хяналтын байгууллагаар урьдчилэн шинжлүүлж дүгнэлт гаргуулсан байна.

Олон улсын стандартын шаардлага хангасан тухай үйлдвэрлэгчийн чанарын батаартай согтууруулах ундааг импортлоход урьдчилэн шинжлүүлж дүгнэлт гаргуулах шаардлагагүй.

2.3. Согтууруулах ундааг импортоор худалдан авах гэрээ нь олон улсын худалдааны нийтлэг журам болон тус

улсын гадаад худалдаанд мөрдөж буй шаардлагыг бүрэн хангасан байна.

2. 4. Аж ахуйн нэгжүүд согтууруулах ундааг импортлох зөвшөөрөл авахад дараахь баримт бичгийг бүрдүүлнэ:

а) согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөд олгосон тухай Засаг даргын захирамжийн хуулбар;

б) импортлох согтууруулах ундааны талаархи Үндэсний стандартчилал, хэмжил зүйн төв, Улсын эрүүд ахуй, халдвар судлалын хяналтын газрын дүгнэлт;

в) гадаадын фирм, компанитай байгуулсан гэрээ (эх хувь);

г) уг аж ахуйн нэгжийн тухай татварын албаны тодорхойлолт;

д) аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ.

2. 5. Дээрх баримт бичгийг хинан үзэж Худалдаа, үйлдвэрийн яамны зах зээлийн зохицуулалтын газраас аж ахуйн нэгжүүдэд зөвшөөрлийн хуудас олгоно. Зөвшөөрлийн хуудсыг хувилах ба ямар нэгэн засвар оруулахыг хориглоно.

2. 6. Зөвшөөрлийн хуудсанд заагдсанаас өөр нэр төрлийн болон шинжилгээгүй, илүү хэмжээний согтууруулах ундааг импортлоор оруулж ирэхийг хориглоно.

Согтууруулах ундаа үйлдвэрлэх зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж үйлдвэрлэлийн түүхий эд болгон ашиглах зорилгоор спирт импортлоход Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас тодорхойлолт гаргуулсан байна.

Гурав. Согтууруулах ундаа хүлээн авах, худалдах, түүгээр үйлчлэх

3. 1. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх байгууллагууд нь тухайн аймаг, сум, дүүргийн Засаг дарга, улсын зэрэглэлтэй хотын захирагчийн албан ёсны зөвшөөрлөөр үйл ажиллагаа явуулна.

3. 2. Албан ёсны зөвшөөрөлгүйгээр, эсвэл зөвшөөрөлд дааснаас өөр газарт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглоно.

3. 3. Согтууруулах ундааг хүлээн авахдаа үйлдвэрлэх, импортлох зөвшөөрөл, бүтээгдэхүүний чанарын баталгаажуулалт, шошго, үйлдвэрлэсэн он, сар, өдөр, стандартчиллын хийгээд хүнсний эрүүд ахуйн хяналтын байгууллагын дүгнэлт зэргийг магадлахаас гадна гаалийн болон худалдааны татвар төлсөн эсэхийг шалган үзнэ.

3. 4. «Архидан согтуурахтай тэмцэх тухай» Монгол Улсын хууль, согтууруулах ундаа үйлдвэрлэх журам болон энэхүү журмыг зөрчиж үйлдвэрлэсэн буюу импортлосон, татвар төлөөгүй, хяналтын шинжилгээ хийлгээгүй, бүтээгдэхүүний чанарын гол үзүүлэлт болох флэвк, химийн бүрэлдэхүүн лабораторийн шинжилгээнд тусгагдаагүй бол уг согтууруулах ундааг хүлээн авах, худалдаа, үйлчилгээнд гаргахыг хориглоно.

3. 5. Согтууруулах ундааг худалдах, түүгээр үйлчлэх ажилд 18 нас хүрээгүй хүн авч ажиллуулахыг 18 нас хүрээгүй, эсхүл согтуу хүнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглоно.

3. 6. Дэлгүүрүүдэд согтууруулах ундааг дахин савлах буюу жүнз, шилэн аягаар худалдахыг хориглоно.

3. 7. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх байгууллагууд нь оршин байгаа нутаг дэвсгэрийнхээ цагдаагийн байгууллагад бүртгүүлсэн байна.

Дөрөв. Согтууруулах ундааны импорт, худалдаалалт, үйлчилгээнд тавих хяналт

4. 1. Согтууруулах ундааны импорт, худалдаалалтад тавих хяналтыг Худалдаа, үйлдвэрийн яам, хууль тогтоомжинд заагдсан мэргэжлийн хяналтын бусад байгууллагууд, улсын байцаагчид гүйцэтгэнэ.

4. 2. Худалдаа, үйлдвэрийн хянан байцаах газар нь согтууруулах ундааг импортлох, худалдах, түүгээр үйлчлэх үйлчилгээгээнд дараахь чиглэлээр хяналт тавина:

а) согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхэд олгосон зөвшөөрлийн үйлчлэх хугацаа хүчинтэй байгаа эсэх;

б) согтууруулах ундааны шонгод барааны тэмдэг, оноосон нэр, улсын стандарт, хатуулаг, нэр төрөл, үйлдвэрлэсэн он, сар, өдрийг бүрэн тэмдэглэсэн эсэх;

в) согтууруулах ундаа нь стандарт, эрүүд ахуйн шинжилгээтэй эсэх;

г) аж ахуйн нэгжид олгосон согтууруулах ундаа импортлох зөвшөөрөл, татвар төлөлт;

д) согтууруулах ундаагаар үйлчилж байгаа газруудын ажилчдын насны хязгаарлалт.

4.3. Хуулийн заалтууд болон энэхүү журмыг зөрчсөн аж ахуйн нэгж, байгууллага, гэм буруутай этгээдэд худалдаа, үйлдвэрийн улсын хянан байнгагч, хууль тогтоомжид заагдсан бусад эрх бүхий албан тушаалтны зохих хариуцлага оногдуулна.

4.4. Хяналт шалгалтын үр дүнгийн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдэгдэж байна.

Засгийн газрын 1994 оны 76 дугаар
тогтоолын 3 дугаар хэсгээр

ТӨРИЙН ХҮНДЭТГЭЛИЙН ЗООГ БАРИХ БОЛОН ЕСЛОЛ ХҮНДЭТГЭЛИЙН БУСАД АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД СОГТУУРУУЛАХ УНДАА ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

1. Архиван согтуурахтай тэмцэх тухай Монгол Улсын хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын 1994 оны 10 дугаар тогтоолын 5 дугаар зүйлд заасны дагуу Төрийн хүндэтгэлийн зоог барих болон ёслол хүндэтгэлийн бусад арга хэмжээ (цаашид «ёслол хүндэтгэлийн арга хэмжээ» гэнэ)-г зохион байгуулахад согтууруулах ундааг хэрэглэхэд энэхүү журмыг мөрднө.

2. Ёслол хүндэтгэлийн арга хэмжээнд согтууруулах ундааг дэлхийн улс орнуудад нийтээр мөрддөг дипломат ёс журам, тухайн зочин, төлөөлөгчийн үндэсний зан заншилд нийцүүлэн хэрэглэнэ.

3. Ёслол хүндэтгэлийн бүх арга хэмжээнд хэрэглэх цагаан архи нь зөвхөн эх орны үйлдвэрийн бүтээгдэхүүн байна.

4. Ёслол хүндэтгэлийн арга хэмжээнүүдэд хэрэглэх согтууруулах ундааны нэг хүнд ногдох хэмжээ дор дурдсанаас өлүүгүй байна (граммаар):

а) Хүндэтгэлийн зоог

- цагаан архи — 100
- дарс (улаан, цагаан төрөл тус бүр) — 75
- шарз — 25

б) Дайллага

— цагаан архи	— 100
— дарс	— 75
— шарз	— 25
— пиво	— 300

в) Цайллага (кино үзлэг, хүлээн авалт)

— цагаан архи	— 75
— пиво	— 300

г) Зоог, дайллага, цайллаганы өмнө барих аспиритив

— Цагаан архи	— 25
---------------	------

д) Гэрээ, хэлэлцээр, протокол, бусад баримт бичигт гарын үсэг зурсны дараахь ёслол

— оргилуун дарс	— 75
-----------------	------

5. Төрийн дээд шагнал гардуулсны дараа оргилуун дарс хэрэглэх бол нэг хүнд ногдох хэмжээ нь 75 граммаас хэтрэхгүй байна.

6. Гадаадын зочин, төлөөлөгчийн зиндаа, тухайн үйл явдлын ач холбогдлыг харгалзан ёслол хүндэтгэлийн арга хэмжээнд хэрэглэх согтууруулах ундааны хэмжээг энэ журамд нийцүүлж урьдчилсан тооцоог гаргуулан батлуулж, гүйцэтгэлийн байдалд Төрийн ёслолын алба, Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газар, Гадаад харилцааны яамны Ёслолын хэлтэс тус тус хяналт тавина.

7. Яам, тусгай газар, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, хотуудын Ардын Хурлын гүйцэтгэл захиргаад болон төрийн өмчийн төсөвт байгууллагуудын шугамаар зохион байгуулагдах ёслол хүндэтгэлийн арга хэмжээнд согтууруулах ундаа хэрэглэх, түүнд хяналт тавихад энэхүү журмыг мөрдлөг болгоно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 4 дүгээр

Улаанбаатар

сарын 25-ны өдөр

Дугаар 78

хот

ХИЛИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. «Хилийн хяналтын албаны ажлыг зохицуулах журам»-ыг энэ тогтоолын 1 дүгээр хавсралтын ёсоор баталсугай.

2. Хилийн худалдаа, бараа солилцоо хийх, хилээр нэвтрүүлэх бараа материалын чанарт хяналт тавих журам гаргаж мөрдүүлэхийн хамт хилийн боомтын үйл ажиллагаатай холбогдсон асуудлыг зохицуулан шийдвэрлэх үүрэг бүхий Хилийн боомтын асуудал эрхэлсэн орон тооны бүс зөвлөлийг 2 дугаар хавсралтад заасан бүрэлдэхүүнтэйгээр байгуулж ажиллуулахаар тогтоосугай.

3. Хилийн боомтуудад эхний ээлжинд шаардлагатай барилга байгууламж, талбайг энэ онд багтаан байгуулж, хяналтын албадаас үйл ажиллагаагаа явуулах нөхцөл бүрдүүлэхийг холбогдох аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Хилийн цэргийн холбоог сайжруулах үндсэн дээр хилийн болон гүний хяналтын байгууллагуудын хооронд мэдээллийн нэгдсэн сүлжээ байгуулах, түүнчлэн экспорт, импортын бүтээгдэхүүнд чанарын болон эрүүл ахуйн сорилт туршилт хийх лабораториудын техник хэрэгслийг сайжруулах, хүч чадлыг нь нэмэгдүүлэх асуудлыг хамтран шийдвэрлэхийг Үндэсний хөгжлийн газар (Ч. УЛААН), Сангийн нам (Д. ДАВААСАМБУУ), Хилийн цэргийг удирдах газар (Н. СҮНДЭВ)-т даалгасугай.

5. Ачаа, зорингч тээвэрлэх шаардлага хангасан гэврийн хэрэгслээр үлс хооронд тээвэр гүйцэтгэх сонирхолтой аж ахуйн нэгжүүдийг сонгож шалгаруулан эрх олгож, тэдний үйл ажиллагаанд зохих хяналт тавьж ажиллахыг Дэд бүтцийн хөгжлийн яам (Р. САНДАЛХАН), Хилийн цэргийг удирдах газар (Н. СҮНДЭВ)-т даалгасугай.

6. Олон улсын болон өөрийн орны чанар, стандартын шаардлага хангаагүй, хүний эрүүл мэнд, байгаль орчин, амьтанд хортой нөлөө үзүүлэх химийн бодис, өргөн хэрэглээний бараа, хүнсний бүтээгдэхүүн импортоор оруулах, худалдаалахыг таслан зогсоох иж бүрэн арга хэмжээг хамтран авч хэрэгжүүлэхийг Худалдаа, үйлдвэрийн нам (Н. ЦОГТ), Гаалийн ерөнхий газар (Г. СЭСЭЭР), Хилийн цэргийг удирдах газар (Н. СҮНДЭВ)-т даалгасугай.

7. Импортоор авах бараа, бүтээгдэхүүн үндэсний стандартад төхирөөгүй буюу түүнийг тухайн орны экспортын барааны чанарын хяналтын албаар хянуулж холбогдох зөвшөөрөл гэрчилгээ аваагүй, түүнчлэн гаалийн шалгалтаар согот гэмтэлтэй байж болзошгүй сэжиг илэрсэн бол гүний шалгалтад хамруулан зохих шинжилгээ хийлгэж, шинжилгээний дүгнэлт гарахаас өмнө хүлээн авагчид нь олгохгүй байхыг дээр агуулахын хадгаламжийн хөлс, шинжилгээний болон бусад зардлыг тухайн барааг гэрээлэгч аж ахуйн нэгж, байгууллагаас гаргуулан авч байхыг Гаалийн ерөнхий газар (Г. СЭСЭЭР)-т даалгасугай.

8. Харилцан нийлүүлэх барааны чанар, баталгаажуулалт, сорилтын талаархи асуудлаар Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын холбогдох байгууллагатай хэлэлцээ хийх ажлын хэсгийг зохих мэргэжлийн хүмүүсийн бүрэлдэхүүнтэйгээр ажиллуулж дээрх орнуудтай санал тохиролцсон хэлэлцээрийн төслийг 1994 оны II улиралд багтаан Застийн газарт оруулахыг Худалдаа, үйлдвэрийн нам (Н. ЦОГТ)-д даалгасугай.

9. Импортын бүтээгдэхүүний чанарт сорилт туршилт хийж шалгах гүний хяналтыг зохион байгуулж, улсын хилээр их хэмжээгээр оруулсан, чанар нь түргэн мууддаг болон чанарын талаар эргэлзээтэй, нотлох баримт бичиггүй бүтээгдэхүүнээс стандарт хэмжил зүй, эрүүл ахуйн болон мал эмнэлэг, ургамал, хорно цээрийн хяналтын байцаагчид үнэ төлбөргүйгээр дээж авч эрх бүхий улсын экспертиз лабораторид шинжилгээ сорилт хийлгэн дүгнэлт гаргуулсны дараа худалдан борлуулж байх журмыг 1994 оны 5 дугаар сарын 01-нээс эхлэн мөрдүүлэхээр тогтоосугай.

10. Улсын мал эмнэлэг, ургамлын хорно цээр, эрүүл ахуй, халдвар судлалын хилийн хяналтын албаны зардлын төсвийн санхүүжилтийг Улсын мал эмнэлгийн албаны ерөнхий газар, Ургамал хамгаалах хорно цээрийн улсын алба, Улсын эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын газрын мэдээл

хуваарилж байхын хамт эрүүл ахуй, халдвар судлалын болон чанарын сорилт туршилтын лабораториудыг төв, орон нутагт буй болгохтой холбогдсон хөрөнгийн эх үүсвэрийг жил жилийн төсвийн төсөлд тусгаж байхыг Хүнс, хөдөө аж ахуйн яам (Ц. ӨӨЛД), Эрүүл мэндийн яам (П. НЯМДАВАА), Сангийн яам (Д. ДАВААСАМБУУ)-д зөвшөөрсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд
Батлан хамгаалахын сайд
Худалдаа, үйлдвэрийн сайд
Хүнс, хөдөө аж ахуйн сайд
Эрүүл мэндийн сайд
Сангийн сайд

П. ЖАСРАЙ
Ш. ЖАДАМБАА
Ц. ЦОГТ
Ц. ӨӨЛД
П. НЯМДАВАА
Д. ДАВААСАМБУУ

Засгийн газрын 1994 оны 78 дугаар
төгтөөллийн 1 дүгээр хэвсгэл

ХИЛИЙН ХИНАЛТЫН АЛБАДЫН АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

1. Хилийн боомтод ажиллаж байгаа хилийн хиналтын байгууллагууд шалгалт явуулахдаа энэхүү журмыг баримтгална. Уг журам нь хилийн хиналтын байгууллагуудын өдөр тутмын ажлыг зохицуулна.

2. Хил хамгаалах байгууллага нь хилийн боомтод ажиллах хиналтын албадын өдөр тутмын ажлыг зохицуулан удирдана.

3. Өдөр тутмын ажлыг зохицуулан удирдахад дараахь үйл ажиллагааг хамааруулна:

— мэргэжлийн хиналтын албаны үйл ажиллагааны үндсэн зарчмын дагуу тухайн цагийн байдлад зохицуулан шалгалт явуулах ерөнхий горимыг тогтооход;

— шаардлагатай цэг, газарт хүч хэрэгслийг төвлөрүүлж хамтарсан ажиллагааг явуулах;

— хиналтын албадын хүсэлтээр гүнзгийрүүлсэн шалгалт хийх нөхцөлийг бүрдүүлэх;

— хиналтын байцаагчдын ажлын цэг ашиглалт, үүргээ биелүүлж байгаа байдлаар ашиглалт тавьж цалин хөлс, шагнал

урамшлыг тухай бүр олгож байхын хамт мэргэжлийн удирдах дээд байгууллагатай байнгын холбоотой ажиллах.

4. Хилийн хяналтын байгууллагууд дараахь дарааллаар холбогдох хууль тогтоомж, ажиллах журмын дагуу хариуцсан чиглэлээрээ шалгалт явуулна:

а) улсын хилээр гарах хөдөлгөөний чиглэлд:

— эрүүл ахуй, халдвар судлал;

— мал эмнэлэг;

— ургамлын хорно цээр;

— гааль;

— хилийн шалган нэвтрүүлэх.

б) улсын хилээр орох хөдөлгөөний чиглэлд:

— хилийн шалган нэвтрүүлэх;

— эрүүл ахуй, халдвар судлал;

— мал эмнэлэг;

— ургамлын хорно цээр;

— гааль.

Мэргэжлийн хяналтын албад шалгаж дууссаны дараа ачаа бараа, тээврийн хэрэгсэлийг нутгийн гүнд нэвтрүүлэх зөвшөөрлийг хилийн шалган нэвтрүүлэх байгууллага олгоно.

5. Эрүүл ахуй, халдвар судлалын, мал эмнэлгийн, ургамал, хорно цээрийн улсын байцаагчдыг томилж, ажлаас чөлөөлөх, сургаж даялагажуулах, тэдний нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжлийн удирдлагаар хангах үүргийг Хүнс, хөдөө аж ахуйн яам, Эрүүл мэндийн яам хариуцах бөгөөд улсын байцаагчдын цалингийн санг тухайн хилийн хороо, ангиудад шилжүүлж байна.

Засгийн газрын 1994 онм 78 дугаар
тогтоолмы 2 дугаар хавсралт

ХИЛИЙН БООМТЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга

— Засгийн газрын шадар сайд
(төрийн захиргааны удирдлагын асуудал эрхэлсэн)

Зөвлөлийн гишүүд:

- Гадаад харилцааны дэд сайд;
- Хүнс, хөдөө аж ахуйн дэд сайд;
- Эрүүл мэндийн дэд сайд;
- Дэд бүтцийн хөгжлийн дэд сайд;
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга;
- Хилийн цэргийг удирдах газрын дарга;
- Гаалийн ерөнхий газрын дарга;
- Таснуулын төв газрын дэд дарга;
- Хүнс, хөдөө аж ахуйн яамны Улсын мал эмнэлгийн албаны ерөнхий газрын дарга;
- Хүнс, хөдөө аж ахуйн яамны Ургамал хамгаалах хорио цээрийн улсын албаны дарга;
- Эрүүл мэндийн яамны Эрүүл ахуй, халдвар судлалын улсын хяналтын газрын дарга, улсын ерөнхий байцаагч;
- Үндэсний хөгжлийн газрын харьяа Үндэсний стандартчилал, хэмжил зүйн төвийн захирал;
- Цагдаагийн ерөнхий газрын Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвийн дарга.

Нарийн бичгийн дарга

- Хилийн цэргийг удирдах газрын шалган нэвтрүүлэх хэлтсийн дарга.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 4 дүгээр

Улаанбаатар

сарын 25-ны өдөр

Дугаар 79

хот

«ЧИНГИС ХААН» ЗОЧИД БУУДЛЫН БАРИЛГЫН АЖЛЫГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

«Чингис хаан» зочид буудлын барилгыг барьж дуусгах ажил удаашралтай, санхүүгийн нэмэгдэл эх үүсвэр шаардлагатай байгааг харгалзан гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах нөхцөл бий болгох зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. «Чингис хаан» зочид буудлын барилга угсралтын ажлыг санхүүжүүлэхээр төсвөөс гаргасан хөрөнгийн хэмжээг түүнтэй ижил төстэй зочид буудлын дэлхийн зах зээлийн үнийн жишгийг харгалзан 1994 оны 4 дүгээр сарын 30-ны байдлаар 15,0 (арван тав) сая ам. доллартай тэнцэх төгрөгөөр тооцож тогтоох тухай Худалдаа, үйлдвэрийн яамны саналыг зөвшөөрсүгэй.

Үүнтэй холбогдуулан уг хөрөнгийг Засгийн газрын урт хугацааны зээлийн хэлбэрт шилжүүлэн үлдээж, зочид буудлын орлогоос төлүүлэх нарийвчилсан хуваарь, гэрээг түүнийг хувьчлан авч эзэмшигчидтэй байгуулахыг Сангийн яам (Д. ДАВААСАМБУУ), Худалдаа, үйлдвэрийн яам (Ц. ЦОГТ)-д даалгасугай.

2. «Чингис хаан» зочид буудлыг барьж дуусгахад болон зээлийн өрийг төлөхөд шаардагдах хөрөнгө, хувьцаа эзэмшигчдын оруулсан хөрөнгийн хэмжээг бодолцон нэмж шаардагдах хөрөнгийн хэмжээгээр хувьцаа гаргаж худалдах замаар хөрөнгийн нэмэгдэл эх үүсвэр олж уг зочид буудлыг энэ онд багтаан барьж дуусгах арга хэмжээ авахыг Худалдаа, үйлдвэрийн яам (Ц. ЦОГТ), Засгийн газрын Өмч хувьчлалын комисс (Л. ЭНЭБИШ)-т даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан «Чингис хаан» зочид буудлыг хувьчлах талаар авах зарим арга хэмжээний

тухай» Монгол Улсын Засгийн газрын 1992 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 76 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн а, б, г заалтыг хүчингүй болсонд тооцугай.

Монгол Улсын Ерөнхий сайд
Худалдаа, үйлдвэрийн сайд
Салгивийн сайд

П. ЖАСРАЙ
Ц. ЦОГТ
Д. ДАВААСАМБУУ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 4 дүгээр
сарын 23-ны өдөр

Дугаар 80

Улаанбаатар
хот

ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Улсын Их Хурлаас Засгийн газрын үндсэн болон дэд бүтцийн тусгай газрыг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан «Улсын хилийн шугамыг шалгахтай холбогдсон зарим арга хэмжээний тухай» Засгийн газрын 1992 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн 55 дугаар тогтоолын хавсралтад дурдсан «Монгол Улс, Оросын Холбооны Улсын хоорондын улсын хилийг шалгах Монгол-Оросын хамтарсан комиссын Монголын хэсгийн бүрэлдэхүүн»-ий «Монголын хэсгийн дэд дарга-Улсын аюулгүй байдлыг хангах ерөнхий газрын тэргүүн дэд бөгөөд хилийн цэргийн дарга, хошууч генерал Ч. Сэндр (хавсран)» гэснийг «Монголын хэсгийн дэд дарга — Монгол Улсын Хилийн цэргийг удирдах газрын дарга, хурандаа П. Сүндэв (хавсран)» гэж өөрчилсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд
Гадаад харилцааны сайд
Бутлан хамгаалахын сайд

П. ЖАСРАЙ
Ц. ГОМБОСҮРЭН
Ш. ЖАДАМБАА

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН
ХУУЛИЙН ЦЭЦИЙН
ДҮГНЭЛТ**

1994 оны 7 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 07

Улаанбаатар
хот

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР ҮНДСЭН
ХУУЛЬ ЗӨРЧСӨН, ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН
ТУХАЙ ХУУЛЬ ҮНДСЭН ХУУЛЬ ЗӨРЧСӨН ТУХАЙ
МАРГААНЫГ ХЯНАН ХЭЛЭЛЦСЭН ТУХАЙ**

Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг 1994 оны 7 дугаар сарын 25-нд Төрийн ордны 251 дүгээр өрөөнд үйлдэв. Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн хуралдааныг Цэцийн гишүүн Л. Баасан даргаалж гишүүдэд Г. Нямдоо, Ц. Цолмон, С. Жапцан (ялтгэгч), Ж. Бямбаа нарын бүрэлдэхүүнтэй хийв.

Цэцийн хуралдааны нарийн бичгийн даргаар Цэцийн нарийн бичгийн дарга Б. Цэндээхүү оролцов.

Цэцийн хуралдаанд маргагч талуудыг төлөөлж Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн Г. Ганболд, Улсын Ерөнхий Прокурорын газрын ажилтан Г. Баясгалан, Улсын Ерөнхий Прокурор Н. Ганбаяр нар болон гомдол гаргагч иргэн Д. Бямбасүрэн оролцов.

Д. Бямбасүрэн Үндсэн хуулийн Цэцэд ирүүлсэн өргөдөлдөө: Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дүгээр заалтын дагуу намайг эрүүгийн хариуцлагад татсан үндэслэлийг шалгуулах болон үндэслэлгүй гаргасан шийдвэрээ хүчингүй болгох асуудлыг Улсын Ерөнхий Прокурор ноён Н. Ганбаярт 1994 оны 5 дугаар сарын 27-нд тавьсан юм.

Ерөнхий Прокурор Монгол Улсын Прокурорын байгууллагын хуулийн 28 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийн заалтыг зөрчиж, надад харну өгөхгүйгээр миний тавьсан асуудлыг хэрэг үүсгэсэн прокурорт шилжүүлснээрээ Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан иргэн миний эрхийг зөрчсөн гэж үзэж Ерөнхий Прокурорын энэ үйлдэлд зохих үнэлэлт өгөхийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хүсч байна.

Миний эсрэг үүсгэсэн үндэслэлгүй хэргийг прокурорын байгууллага санаачлан мөрдөн байцаах ажиллагааг про-

курор Х. Алтанзүрх явуулах өрөлдлөгө хийлээ. Энэ нь Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хуулийн 14 дүгээр зүйл Монгол Улсын үндсэн хуулийн 56 дугаар зүйлийг зөрчсөнтэй холбоотой гэж үзэж байна. Энэ асуудлыг хянан шийдвэрлэж өгөхийг хүсье.

Монгол Улсын Ерөнхий Прокурор өөрт нь өргөн барьсан баримт материалаас прокурорууд мөрдөн байцаалт явуулж байгааг болон тэр нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцэхгүй байгааг мэдэж байсан гэдэгт эргэлзэхгүй байна.

Монгол Улсын Ерөнхий Прокурор үйл ажиллагаандаа Монгол Улсын үндсэн хуулийн 56 дугаар зүйлийг зөрчсөн тухай асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхийг хүсье» гэжээ.

Иргэн Д. Бямбасүрэн өргөдлийнхөө дагуу Цэцэд өгсөн нэмэлт тайлбартаа: Ерөнхий Прокурор 1993 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/46 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулан «Алт, дилерийн хэрэг» гэдгийг мөрдөх үүрэг өгч, ийм шийдвэр гаргаснаараа Үндсэн хуулийн 56 дугаар зүйлийг зөрчиж, өөртөө мөрдөн байцаах бүтэц бий болгосон. Прокурор Алтанзүрх мөрдөн байцаах ажиллагаа явуулсан бөгөөд турван удаагийн уулзалтын эцэст 1994 оны 6 дугаар сарын 24-нд «Би хэргээ мөрдсөн» гэж мэдэгдсэн. Төрийн төв хэвлэл «Ардын эрх» сонин 1994 оны 5 дугаар сарын 25-ны дугаарт намайг хэрэгт татсан тухай мэдээг «Улсын Ерөнхий прокурорын газарт» гэсэн хаягаар нийтэлсэн бөгөөд мөн сонин 5 дугаар сарын 25-ны дугаарт мөн ийм хаягаар гарсан мэдээнд Улсын Ерөнхий Прокурорын орлогч Ж. Чойжанпан тайлбар өгч ярицлага өгөхдөө прокурор мөрдөн байцаалт явуулсныг шууд болон шууд бусаар нотолсон. Ерөнхий Прокурор надад хариу өгөөгүйгээрээ Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 12 дахь хэсгийг давхар зөрчсөн юм. Прокурорын байгууллага бодит баримтыг огоорон хэрэг зохиож мөрдөн байцаалт явуулах нь аль ч илрэлээрээ Үндсэн хуулийг хөсөрдүүлж, туйлын харамсалтай үр дагаварт хүргэж болох тул түүнээс сэрэмжлэхэд хүчин чармайлт тавих нь миний иргэний үүрэг мөн гэж үзэх тул үүнийг товлуулав гэжээ.

Монгол Улсын Ерөнхий Прокурор Н. Ганбаяр Үндсэн хуулийн Цэцэд өгсөн тодорхойлолтодоо: «Надад ирүүлсэн Д. Бямбасүрэнгийн өргөдлийг хүлээн авч танилцаад дараа өдөр нь «Бямбасүрэнгийн өргөдлийг хэргийн материалд нь хавсаргах, харин ялагдагчаар татсан үндэслэлээ түүнд сайн танилцуул» гэсэн ам хариуг Д. Бямбасүрэнг ялагдагчаар татсан прокурор Х. Алтанзүрхэд өгсөн болно. Төрийн албан

тушаалтны хувьд надад ирүүлсэн гомдолд хуулийн дагуу харну өгөх ёстой.

Бямбасүрэн нэгэнт ялагдагчаар татагдсан учраас түүний гомдлыг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаагаар зохицуулах ёстой гэж бодож байна. Ноглох баримт шалгуулах тухай Д. Бямбасүрэнгийн хүсэлтийг ажлын хэсэг авсан гэж ойлгож байна. «Алт диллерийн» гэгдэх хэргийн мөрдөн байцаалтын ажиллагааг Улсын Бага Хурлаас өгсөн чиглэлийн дагуу Улсын Ерөнхий Прокурорын газрын хяналтын дор мөрдөн байцаах газартай хамтран шалгаж дуусгаж байна. Энэ хэргийг гол нь мөрдөн байцаах газар мөрдөн байцаалт явуулж, Прокурорын байгууллага мөрдөн шалгах зарим ажиллагаанд оролцож байгаа юм. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих гэдэг нь энэ талаар тодорхой шийдвэр гаргана гэсэн үг. Шийдвэр гаргахгүй бол хяналт тавьж чадахгүй. Анх «Алт диллерийн» гэгдэх энэ хэргийг хуучин Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн харьяаллын дагуу шалгаж эхэлсэн. Улсын Дээд шүүхээс 1993 онд Улсын Прокурорын газарт нэмэлт мөрдөн байцаалт хийлгэхээр буцаасан. Тэгээд ч цагдаагийн удирдлага энэ хэргийг алаагүй юм. Нэгэнт эхэлсэн хэргийг цаг алдалгүй шуурхай дуусгах, нөгөө талаас энэ мөрдөн байцаалтыг мөрдөн байцаах газартай хамтарч дуусгах нь Эрүүгийн байцаан шийтгэх хуульд харшлахгүй гэж үзсэн гэжээ.

Иргэн Д. Бямбасүрэн Цэцэд өгсөн тодорхойлолтдоо «Прокурор Х. Алтанзүрхийн хууль бус ажиллагааны талаар Улсын Ерөнхий Прокурор ноён Ганбаярт өргөдөл бичиж түүнийг зогсоохыг хүссэн.

Харин Ерөнхий Прокурор надад харну өгөөгүй. Миний бичсэн өргөдлийг Х. Алтанзүрхэд өгч хавтаст хэрэгт халгалуулан.

Х. Алтанзүрх «Ерөнхий прокурор таны өргөдөлд бичгээр харну өгөхгүй хавтаст хэрэгт нь хий. Хэрэгт татсан үндэслэлээ тайлбарлаж өгөөрэй» гэж хэлсэн гэсэн юм. Ингэцнээрээ Ерөнхий Прокурор Н. Ганбаяр төрийн байгууллагад, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх, ноглох баримтыг шалгуулах иргэн миний эрхийг зөрчсөн юм.

Монгол Улсын Үндсэн хуульд прокурорын байгууллагын чиг үүргийг тодорхой заасан. Гэтэл прокурорын байгууллага эрүүгийн хэрэгт мөрдөн байцаалт явуулж, энэ тухайгаа төрийн хэвлэлээр зарлан мэдээлсэн нь тодорхой. 1994 оны

5 дугаар сарын 24-нд Х. Алтанзүрх хэрэгт татсан тогтоолоо уншиж өгөөд гарын үсэг дур гэсэн боловч би эсэргүүцсэн.

Дэрэмийг цагдаагийн мөрдөн байцаагч гэдгийг танилцуулаагүй учир би мэдээгүй. Сая л тогтоолоос мэдлээ. Прокурор Х. Алтанзүрхийн үйл ажиллагаа бол Үндсэн хуульд заасан эрхээ хэтрүүлсэн явдал мөн. Ерөнхий Прокурор энэ үйл ажиллагааг мэдэж, бүр цаашилбал удирдан чиглүүлж байснаараа тэр Үндсэн хуулийн 56 дугаар зүйлийг зөрчиж байна гэж үзэх үндэстэй. Дөрвөн удаагийн уулзалтын үеэр байцаалтыг Х. Алтанзүрх гардан явуулсан. Сууачийн удаа Х. Алтанзүрх мөрдөн байцаалт ингээд дууссан гэж хэлсэн. Би протоколд гарын үсэг зураагүй гэжээ.

Мөрдөн байцаагч Д. Дэрэм «Миний бие 1993 оны 10 дугаар сарын 25-наас Хүдэрчулуун нарт холбогдох хэрэгт мөрдөн байцаагчаар ажиллаж байна. 1994 оны 5 дугаар сарын 24-нд Д. Бямбасүрэнд ял сонгох тогтоолыг би үйлдсэн. Түүнээс хойшхи уулзалтанд би оролцоогүй болно» гэжээ.

Прокурор Х. Алтанзүрх Цэцэд өгсөн тодорхойлолтоо «Ерөнхий Прокурорын 1994 оны А/13 тушаалаар Хүдэрчулуун нарт холбогдох хэргийг мөрдөх ажлын хэсэгт орж Д. Содном, Гунгаадорж, Бямбасүрэн нартай холбоотой асуудлыг мөрдөн шийдвэрлэх чиглэлтэй мөрдөн байцаалт явуулсан. Мөрдөн байцаалт явуулахдаа тухайн үед хүчин төгөлдөр байсан Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн заалт, Прокурорын хуулийн 1 дэх хэсгийн 6, 2-ыг удирдлага болгодог. Би 5 дугаар сарын 24-нд Д. Бямбасүрэнг яллагдагчаар татсан. Мөрдөн байцаах ажиллагааг би гардан явуулсан. Үндсэн хуульд байгаа хяналт тавих гэдэг бол мөрдөн байцаалт явуулахгүй гэсэн үг биш юм.

Прокурорын хуульд мөрдөн шалгах ажиллагаа явуулж болно гэж заасан. Энэ бол мөрдөн байцаалт явуулахыг хэлж байгаа юм. Бямбасүрэнг 5 дугаар сарын 24, 6 дугаар сарын 8, 20, 22-ны өдрүүдэд дөрвөн удаа байцаасан» гэжээ.

Удсын Ерөнхий Прокурор Н. Ганбаяр Цэцэд өгсөн тодорхойлолтоо Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах зарим ажиллагааг явуулахад оролцох гэдэг нь тэдгээрийг хуулийн дагуу явуулж байгаа эсэхийг хянахын тулд хэргийн газрын үзлэгт оролцох, нүүрэлдүүлэн байцаахад байлцах гэх мэт үйл ажиллагааг хэлнэ. Прокурорын байгууллага хуульд заасан үндэслэл, журмын дагуу мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулж болно» гэжээ.

Прокурорын хууль, түүнд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс тавьсан хоригийг Хууль зүйн байнгын хороо, Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүдэх үед Ц. Шаравдорж, Д. Батбаатар, Ц. Төрмандах, Б. Ганболд, Ж. Бямбадорж нарын гишүүд прокурорт хэрэг мөрдөх чиг үүрэг байх ёсгүй гэсэн саналтай байжээ. Харин гишүүн С. Нарангэрэл, Д. Лүндээжанцан, С. Төмөр нар эсрэг саналтай байсан нь хэлэлцүүлгийн протоколоос харагдаж байна.

Цэцийн хуралдаанд оролцож Монгол Улсын Ерөнхий прокурор Н. Ганбаяр хэлсэн үгэндээ «Прокурорын байгууллага мөрдөн байцаалт явуулсан нь Цэцийн аич хэлэлцэх асуудал биш юм. Прокурор хяналт тавьж байж үндэслэлтэй шийдвэр гаргана. Прокурорын байгууллага мөрдөн байцаалт явуулах талаар миний бие зохион байгуулалтын шинжтэй тушаал гаргасан Бямбасүрэн өргөдөлд хариу өгөөгүй гэж Цэцэд гомдол гаргасан. Бямбасүрэнг байцаасан асуудал бол шийдвэр биш бөгөөд нотлох баримтыг цуглуулж байгаа асуудал юм. Бямбасүрэнг яллагдагчаар татсан учир түүний гомдлыг Эрүүгийн байцаан шийтгэх ажлалагааны журмаар шийдвэрлэх ёстой.

Яллагдагч бүрийн гомдлыг Улсын Ерөнхий прокурор аич шийдвэрлэхгүй. Би Бямбасүрэнгийн өргөдлийг хүлээж ашигт бичгээр цохолт хийж хяналт тавьж байсан прокурор Алтанзүрхэд шилжүүлсэн. Би зохих журмын дагуу хариу өгсөн.

Бямбасүрэнгийн гаргаж байгаа гомдлыг шүүх дээр эргэж шийдэх асуудал юм. Бямбасүрэнгийн эрхийг хязгаарласан үйл ажиллагаа явуулаагүй. Тэр сонин хэвлэлээр бичиж байсан. Харин Бямбасүрэн мөрдөн байцаалтын нууцыг задруулсан» гэжээ.

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Г. Ганболд Цэцийн хуралдаанд оролцож хэлсэн үгэндээ «Прокурорын байгууллагын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6, 2 дахь хэсгийн заалтууд нь бүхэлдээ хүний эрх, эрх чөлөө, халдашгүй байдлыг хангах Прокурорын хяналтын чухал арга юм. Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хууль зөрчигдөх явдлыг таслан зогсооход ач холбогдолтой үйл ажиллагаа учраас Прокурорын тухай хуулийн дээр дурдсан заалтууд Үндсэн хууль зөрчөөгүй нь тодорхой байна» гэжээ.

Иргэн Д. Бямбасүрэн цэцийн хуралдаанд оролцож гаргасан галбартаа «Ерөнхий Прокурор өөрийн тушаалаар

мөрдөн байцаах ажлын хэсэг байгуулах замаар хуульд заагаагүй эрх эдлэх боломжийг прокуроруудад олгож Үндсэн хуулийн 56 дугаар зүйлийг зөрчсөн нь эргэлзээгүй юм. Прокурорын байгууллага тухайлбал прокурор Х. Алтанзүрх Үндсэн хуулийн Хавсралт хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтын дагуу хүчингүй болсон хууль хэрэглэж мөрдөн байцаалт явуулсныг таслан зогсоох талаар миний тавьсан хүсэлтийг ойшоогоогүй юм.

Үндсэн хуулийн Цэнтэй харьцахад намайг «ялалдагч» хэмээн нэрлэсэн, одоо ч нэрлэсээр байгаа нь Ерөнхий Прокурор өөрөө энэ гүтгэлтийн хэрэгт шууд оролцогч нь болж байгааг нотолж байна. Миний бие Ерөнхий Прокурор Ганбаярт өгсөн өргөдөлдөө Засгийн газрын үйл ажиллагааны тайланг 1992 оны 1 дүгээр сард Улсын Их Хуралд хэлэлцэх үед арбитражийн гүйлгээний алдагдал, уг асуудалд Засгийн газар хэрхэн хөндсөн тухай дэлгэрэнгүй хэлэлцээд 1992 оны 1 дүгээр сарын 22-нд тогтоол гаргаж Засгийн газарт итгэх шийдвэр гаргасныг анхаарахыг хүссэн. Үүнийг эе анхаарцаар Ерөнхий прокурор Монгол Улс 1974 онд нэгдэн орсон «Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт»-ын 15-ын 1 дүгээр зүйлийг зөрчиж миний иргэний эрхийг хөсөрдүүлсэн юм.

Тэр улсын Их Хурлын дээрх шийдвэрийг анхаарах хүсэлтийг аваагүйгээр олон улсын пактыг зөрчиж, тэгснээр Хавсралт хуулийг зөрчлөө» гэжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн хуралдаанд оролцож өгч буй дээрх тайлбарууд Улсын Ерөнхий Прокурор Н. Ганбаяр Үндсэн хуулийн заалтуудыг зөрчиж, тэр үйлдэл нь хүний эрхийг хөсөрдүүлж, прокурорын байгууллагын үйл ажиллагааг завхруулах агуулгатай байгааг нотолж уг асуудлыг Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн, 3-ын дагуу хянан шийдвэрлэж, туслах зорилготой билээ» гэжээ.

Хянавал:

Изг. Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн б, 2 дахь хэсэгт заасны дагуу прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах зарим ажиллагаа явуулахад оролцох, хуульд заасан үндэслэл, журмын дагуу мөрдөн шалгах ажиллагаа явуулах нь халдашгүй, чөлөөтэй байх, хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөнгөх, эрх чөлөөг хилгаарлахыг хориглох зэрэг Үндсэн хуульд заа-

сан иргэний эрхийг баталгаажуулах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах үйл ажиллагаанд хууль ёс зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсооход чиглэсэн Прокурорын хяналтын арга учир Монгол Улсын Үндсэн хуулийн 56 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчөөгүй байх тул энэ талаар гаргасан иргэн Д. Бямбасүрэнгийн гомдлыг хангах үндэслэлгүй байна.

Хоёр. Монгол Улсын Ерөнхий прокурор Н. Ганбаяр төрийн албан тушаалтнахаа хувьд иргэн Д. Бямбасүрэнгээс доод шатны прокурорын тодорхой үйл ажиллагаатай холбогдуулан түүнд ирүүлсэн гомдлыг хүлээн авсан атаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу хянан шийдвэрлэж харну өгөөгүй байгаа нь тогтоогдсон тул Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 12 дахь заалтыг зөрчсөн гэж үзэх үндэстэй байна.

Гурав. Монгол Улсын Үндсэн хуульд Шүүх засаглалын хүрээнд Прокурорын байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг нарийвчлан тогтоож өгсөнтэй уялдан Үндсэн хуулийн хавсралт хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Прокурорт мөрдөн байцаах эрх олгож, түүнийг хяналтын үүрэгт нь багтааж байсан Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн холбогдох заалтууд Үндсэн хууль батлагдсан үеэс хүчингүй болсон, мөн түүнчлэн Улсын Бага Хурлын 1992 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн 36 дугаар тогтоолын дагуу Прокурорын мөрдөн байцаах албыг орон тоо, төсөн, эд хөрөнгийн хамт 1992 оны 7 дугаар сарын 1-ний дотор Цагдаагийн Ерөнхий газарт шилжүүлэх замаар Прокурорын байгууллагын үйл ажиллагааг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлсэн бодит нөхцөл байдлыг үд хайхран Ерөнхий Прокурор Н. Ганбаяр «Алт, диллерийн» тэгдэх эрүүгийн хэргийг мөрдөх ажлыг зохион байгуулан явуулах түүнд хяналт тавих ажлын хэсгийг 1993 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/46 тоот тушаалаараа байгуулан ажилдуулснаар прокурорууд мөрдөн байцаалтын тодорхой үйл ажиллагааг биечлэн явуулах улмаар прокурорын хяналтын агуулга алдагдах болсон нь хүний эрх, эрх чөлөө зөрчигдөхөд хүрч болзошгүй гэсэн иргэн Д. Бямбасүрэнгийн гомдлыг хүлээн авах үндэслэлтэй байна.

Дөрөв. Иргэн Д. Бямбасүрэн Үндсэн хуулийн Цэцэд хандаж Улсын Ерөнхий Прокурор Н. Ганбаяр Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт заасан «... нотлох баримтыг шалгуулах . . . тухай иргэн миний эрхийг зөрчлөө гэсэн

гомдол гаргасан нь түүнд эрүүгийн хэрэг үүсгэсэнтэй холбоотой асуудал тул шүүхийн журмаар хянан шийдвэрлэгдэх учраас түүнийг хангах үндэслэлгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг удирдлага болгон Үндсэн хуулийн Цэцийн хуралдаанаас дараахь дүгнэлтийг гаргав.

1. Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6-гийн «хэрэг бүртгэх, мөрдөн байцаах зарим ажиллагааг явуулахад оролцох», мөн зүйлийн 2 дахь хэсгийн «Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавихдаа Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан үндэслэл, журмын дагуу мөрдөн шалгах ажиллагааг явуулж болно» гэсэн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн 56 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчөөгүй байна.

2. Монгол Улсын Ерөнхий прокурор Н. Ганбаяр Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 12 дахь заалт, 56 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн гэж үзэв.

3. Иргэн Д. Бямбасүрэнгийн өргөдөлд байгаа Улсын Ерөнхий Прокурор Н. Ганбаяр нотлох баримтыг шалгуулах тухай миний хүсэлтийг үл хэрэгсэн Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дүгээр заалтыг зөрчлөө гэсэн гомдлыг хэрэгсэхгүй болгосугай.

4. Манай дүгнэлтийг хэрхэн шийдсэн тухай хариуг Улсын Их Хурлын 1994 оны намрын чуулганы ажиллагаа эхэлснээс хойш 15 хоногийн дотор мэдэгдэхийг Монгол Улсын Их Хуралд уламжилж байна.

Дарга
гоцгууд

А. БААСАН
Г. НЯМДОО
Ц. ЦОЛМОН
Ж. БЯМБАА
С. ЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, ГАДААД БОДЛОГЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, ЦЭРГИЙН НОМЛОЛЫН ҮНДСИЙН ҮНДСЭН АГУУЛГА

Улс төр, эдийн засаг, цэрэг нийгэм-оюун санааны болон бусад бараг бүх салбарыг хамарч байсан «Хүйтэн дайн» дуусч улс гүрнүүд эрх тэнц, чөлөөтэй хамтарч ажиллах өргөн боломж нээгдэж, олон улсын харилцааны шинэ тогтолцоо бүрэлдэх үйл явц бэхжиж байна. Хэдийгээр дэлхийн улс гүрнүүд нийгмийн хөгжлийн жам ёсоор харилцан уялдаа холбоогоо бэхжүүлж байгаа боловч үндсэрхэг үзэл газар авч, үндэстэн ястан, шашин хоорондын зөрчил нэмэгдэж зөрчил мөргөлдөөн гарсаар байна.

Олон улсын байдал хэдий нйм ороо бусгаж байгаа ч Монгол Улсын хувьд аюулгүй байдал хангахад бүхэлдээ таатай нөхцөл бүрдэж байгаа энэ нэг үед Үндэсний аюулгүй байдлыг (цаашид ҮАБ гэж товчлов) үзэл баримтлалыг Улсын Их Хурал батлан гаргав.

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлд Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлно гэж заасан. Түүнчлэн ҮАБ-ын Зөвлөл нь Улсын Их Хурлаас баталсан ҮАБ-ын үзэл баримтлалыг баримтлан үйл ажиллагаагаа явуулахаар ҮАБ Зөвлөлийн тухай хуульд мөн заасан юм. Үүнээс үндэслэн Монгол Улсын Үндсэн хуулийн хүрээнд төрийн дотоод, гадаад бодлогын гол үндсүүдийг тодорхойлж, Монгол Улсын ашиг сонирхол, ялангуяа улс орныхоо язгуур ашиг сонирхлыг хамгаалан бэхжүүлэх арга замыг тодорхойлох шаардлага тавигдсан болно.

Энэ ч учраас Монгол Улсад хэтдээ учирч болзошгүй аюул занал, түүнээс урьдчилан сэргийлэх арга механизм талаар цэгцтэй нэг мөр ойлголт бодлогыг боловсруулан, аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлс, аюулгүй байдлыг хангах арга зам, түүний баталгаа зэргийг уг үзэл баримтлалд тодорхой тусгажээ.

ҮАБ-ын үзэл баримтлалд Монгол Улсын Үндсэн хууль нь Монгол Улсын ард иргэд, нийгмийн бүх хэсэг бүлгийн нийтлэг ашиг сонирхлын цогцолсон илэрхийлэл болохыг зааж Монгол Улсын үндэсний аюулгүй байдал нь Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ хэмээн тодорхойлж өгсөн байна. Нийтлэг ашиг сонирхлын

дотроос манай улс, ард түмэнд амни чухал ач холбогдолтойг нь язгуур ашиг сонирхол гэж ялган зааж бэхжүүлсэн бөгөөд түүнд монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг, дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, Улсын хилийн халдаангүй дархай байдал, эдийн засгийн харьцангуй бие даасан байдал, экологийн тэнцвэрт хөгжил, үндэсний эв нэгдэл тус тус багтахгаар заажээ.

Манай улсын өвөрмөц байдал, хөгжлийн төлөв, шаардлагыг харгалзан УАБ-ын бүтцийг дараахь байдлаар тогтоожээ. Үүнд:

- 1) Монгол Улсын оршин тогтохын аюулгүй байдал;
- 2) нийгэм-төрийн байгууллын аюулгүй байдал;
- 3) иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал;
- 4) эдийн засгийн аюулгүй байдал;
- 5) шинжлэх ухаан, технологийн аюулгүй байдал;
- 6) мэдээллийн аюулгүй байдал;
- 7) монгол соёл иргэншлийн аюулгүй байдал;
- 8) хүн ам, удмын сангийн аюулгүй байдал;
- 9) экологийн аюулгүй байдал гэсэн 9 хэсгээс бүрдэж байна.

Эд үзэл баримтлалд бэхжүүлсэн нэг чухал зүйл бол дээр дурдсанчлан аливаа аюул заналыг тулаанд нөмрөөд ирсэн хойно нь бус, харин бодж өгвөл эртнээс таним илрүүлж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах явдал мөн гэсэн баримтлал юм. Үүнийг иш үндэс болгон УАБ-д нөлөөлөх хүчин зүйлийг эх сурвалжаар нь гэдвэл, дотоод гэж үндсэнд нь хоёр ангилж, УАБ-ын бүтцийн хэсэг тус бүр дээр дээрх ангиллын дагуу сөрөг нөлөөлж болох хүчин зүйлүүдийг нь тодорхойлсон болно.

Үндэсний аюулгүй байдлын үндсэн баталгаа нь монголын ард түмэн өөрөө, Монгол Улсын төр мөн болохыг тодорхойлон заасан явдал нь үндэсний аюулгүй байдлыг хангахад төр, түүний бүх байгууллага, албан тушаалтан, улс төр, олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгж төдийгүй ард иргэд ном идэвхтэй оролцох ёстойг харуулж байна.

УАБ-ыг хангах арга зам нь нийгэм, улс төр, зохион байгуулалт, эдийн засаг, дипломат, цэрэг, тагнуул, хууль зүйн аргаар дангаар бузюу олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар хангах явдал байх. УАБ-ыг хангах үндсэн арга хэрэгсэл нь багтай мэдээлэл, нарийн судалгаа, тооцоо-

ны үндсэн дээр үйл ивдлын өрнөлт, хөгжлийг урьдаас харж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах явдал мөнхийг эд үзэл баримтлалд бэхжүүлсэн юм. Үүнийг иш үндэс болгон УАБ-ын бүтцийн хэсэг тус бүрд аюулгүй байдлыг хангах арга замыг нэгбүрчлэн тодорхойлж өгчээ. (Үүнийг Үндэсний Аюулгүй Байдлын үзэл баримтлалын 23, 27, 31, 35, 39, 43, 47, 51, 55 дугаар зүйлүүдээс үзнэ үү).

УАБ-ыг хангах тогтолцоонд Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, түүний тэргүүлсэн Үндэсний Аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газар, хууль сахиулах болон төрийн захиргааны төв, орон нутгийн бүх байгууллага багтаж УАБ-ын үзэл баримтлалын заалтыг хэрэгжүүлэх ажлыг гүйцэтгэх ёстой юм. Ингэхдээ төрийн эдгээр байгууллагууд болон нутгийн өөрөө удирдах байгууллагууд нь УАБ-ын үзэл баримтлалын үзэл санааг Монгол Улсын Үндсэн хууль, хууль тогтоомж болон эрх зүйн бусад холбогдох актаар бэхжүүлж, тус тусын эрх хэмжээний дотор хэрэгжүүлэх үүргийг хүлээнэ.

УАБ-ын үзэл баримтлалыг хэрэгжүүлэх стратеги, тактикийг уялдуулан зохицуулах үүргийг Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөл хүлээх бөгөөд УАБ хэрхэн хангагдаж байгаад хяналт тавьж Улсын Их Хуралд жил бүр мэдээлж байхаар эд үзэл баримтлалд заасан юм.

Түүнчлэн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх арга хэмжээг тухайн байгууллагууд өөрсдийн төсөвт тусгаж гүйцэтгэж байх, тусгай арга хэмжээ авах нөхцөлд зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр заасан нь УАБ-ын үзэл баримтлалыг хэрэгжүүлэх зохион байгуулалт, эдийн засгийн баталгааг бэхжүүлсэн хэрэг юм.

УАБ-ын үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд УАБ-ын мэдээллийн сан чухал үүрэгтэй бөгөөд УАБ-ыг хангах төрийн бодлогыг уялдуулан зохицуулах, хэрэгжүүлэхэд шаардагдах бүх төрлийн мэдээллийг холбогдох эрх бүхий байгууллага, иргэд гадаадын эх сурвалжаас олж авахыг эд үзэл баримтлалд заасан байна. Энэхүү мэдээллийн нэгдсэн сан нь Монгол Улсын УАБ-ын Зөвлөлийн дэргэд байх юм.

УАБ-ын үзэл баримтлал нь хөгжил хөдөлгөөнгүй зүйл биш бөгөөд Монгол Улсын УАБ-ын үзэл баримтлалд тусгагдсан үндсэн бүтэц, тэдгээрийн агуулгад дэлхий дахины, бүс нутгийн болон улс орны байдал, хөгжил, өрнөлтийн чиг хандлагад гарч байгаа өөрчлөлттэй уялдаж, УАБ-ын Зөвлөлийн

синал болгосноор Улсын Их Хурал зохих нэмэлт өөрчлөлт оруулж байх юм.

ҮАБ-ын үзэл баримтлал нь Монгол Улсын өвөрмөц байдал, аюулгүй байдлаа ханган бэхжүүлэх бодит бололцоог зохих ёсоор тусгасан Монгол Улсын ашиг сонирхлыг хөндсөн хөгжил дэвшил, соёл иргэншилтэй холбогдсон бүх асуудлыг тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын нэгэн адил засаг төр, ард иргэдийн хараа хяналтад байлгаж, аливаа аюулыг урьдчилан харж, сэрэмжлэн зайлуулах арга замыг тодорхойлон бэхжүүлсэн улс төр, хууль зүйн чухал ач холбогдолтой баримт бичиг мөн.

ҮАБ-ын үзэл баримтлалын хүрээнд Монгол Улсын гадаад бодлогын зорилго, чиглэл, зарчмыг тодорхойлсон баримт бичиг бол Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал юм.

Энэхүү үзэл баримтлалыг Монгол Улсын ҮАБ-ын үзэл баримтлал, Монгол Улсын цэргийн номлолын үндэстэй хамт Улсын Их Хурлын 1994 оны хаврын чуулганаар батлан гаргав.

Эд үзэл баримтлал нь оршил хэсэг, нийтлэг үндэслэл, Монгол Улсын гадаад улс төрийн бодлого, эдийн засгийн гадаад харилцааны бодлого, шинжлэх ухаан-технологийн гадаад харилцааны бодлого, соёл, хүмүүнлэгийн гадаад харилцааны бодлого гэсэн хэсгүүдээс бүрдэж байна. Монгол Улсын Гадаад нөхцөл байдал өөрчлөгдөж манай орны улс төр, нийгэм, эдийн засгийн байгуулалын өөрчлөлт, шинэчлэлт улс үндэснийхээ ашиг сонирхлыг дээдэлсэн, бодит байдалд тулгуурласан гадаад бодлого явуулах аятай боломж бүрдэж байгаа тэрэг гаднаад, дотоод хүчин зүйлүүдийг үндэс болгон Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалыг тодорхойлсон юм.

Тус улс хүн төрөлхтөний хөгжлийн жамыг датан бүх улс оронтой найрсаг харилцаатай байж, олон улсын хамтын нийгэмлэгт байр суурна бэхжүүлэн бүс нутгийн болон дэлхийн нөлөө бүхий улс гүрнүүдтэй улс төр, эдийн засгийн болон бусад ашиг сонирхлын нүгэлцээ бүхий харилцааны сүлжээ бүрдүүлэх замаар улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бат найдвартай хангах явдал мөн гэж Монгол Улсын гадаад бодлогын зорилтыг эд үзэл баримтлалд тодорхойлжээ. Үзэл баримтлалд Монгол Улс нээлттэй, эвсгэлд үл нэгдэх бодлого явуулна гэж зассан.

Нээлттэй бодлого гэдэг нь улс төр, эдийн засаг, шинж-

лэх ухаан, технологи, мэдээлэл, соёл, хүмүүнлэгийн гэх мэтчилэн бүхий л салбарт нээлттэй байхыг хэлнэ.

Ингэхдээ өндөр хөгжилтэй улсуудын бодит сонирхлыг өөрийн оронд бий болгох бодлого баримтлахын хамт аль нэг улсаас хэт хамааралтай буюу хараат байдалд орохоос сэрэмжлэх, гадаад орнууд дахь монголын сонирхлыг улс төр, эрх зүйн аргаар бататган хамгаалах, тус улсын гадаад бодлогыг тодорхойлохдоо олон улсын харилцааны хөгжил, дэлхий дахины болон бүс нутгийн улс төрийн байдалтай нягт уялдуулж тэргүүлэх чиглэл, зорилгыг нь тогтооходоо уян хатан хандаж байх зэрэг Монгол Улсын гадаад бодлогодоо баримталж байх зарчмуудыг ямагт удирдлага болгож байх ёстой.

Эвсэлд үл нэгдэх бодлого өргөн хүрээтэй ойлголт бөгөөд үзэл баримтлалд цэргийн аливаа эвсэлд үл нэгдэх тэр утгаар нь авч үзэсний зэрэгцээ хоёр хөршийнхөө аль нэгтэй гэрэг-улс төрийн холбоотны харилцаанд орж нөгөө хөршийнхөө эсрэг эвсэхгүй байх; эвсэл бусад улс гүрэнтэй тийм холбоонд орж, хоёр хөршийнхөө эсрэг үйл ажиллагаа явуулахгүй байхыг ойлгох нь зүйтэй юм.

Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний язгуур ашиг сонирхлыг улс төр-дипломатын аргаар хангах, эдийн засаг шинжлэх ухаан-технологийг хөгжүүлэх гадаад таатай нөхцөлийг бүрдүүлэх явдал гадаад бодлогын тэргүүлэх чиглэл нь байх бөгөөд улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан-технологич, соёл хүмүүнлэгийн хүрээний гадаад харилцааны бодлого дотроос улс төрийн гадаад бодлого тодорхойлогч шинжтэй байна гэдгийг эд үзэл баримтлалд тодорхойлжээ.

Эд үзэл баримтлалд Монгол Улсын гадаад улс төрийн бодлого (II хэсэг), эдийн засгийн гадаад харилцааны бодлого (III хэсэг), шинжлэх ухаан-технологийн гадаад харилцааны бодлого (IV хэсэг), соёл, хүмүүнлэгийн гадаад харилцааны бодлого (V хэсэг)-ыг тус бүрд нь тодорхойлж энэ асуудлаар тус улсын баримтлах зарчим, гол чиглэлүүдийг нэгбүрчлэн заан бэхжүүлсэн нь тус улсын гадаад бодлогыг боловсруулах, тодорхойлох, хэрэгжүүлэх бүх субъектийн үйл ажиллагааны нэг гол удирдамж нь болох юм.

Үндэсний Аюулгүй байдлын талаарх цогцолбор баримт бичгийн нэг болох Монгол Улсын Цэргийн номлолыг Улсын Их Хурал мөн батлан гаргасан билээ. Монгол Улсын төрийн батлан хамгаалах бодлого, үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээний бүрэлдэхүүн хэсэг юм.

Энэ бодлого, үйл ажиллагааны нэг үндэс нь цэргийн номлол байдаг.

Цэргийн номлол нь аливаа дайн, түрэмгийллийн талаарх төрийн үзэл баримтлалын үндсийг тодорхойлох, дайны аюулыг сэрэмжлэн зайлуулах, улс орноо түрэмгийллээс хамгаалах нөхцөлийг бүрдүүлэх, хамгаалах, зэвсэгт хүчин, бусад цэргийн байгуулалт, зэвсэгт тэмцэл явуулах талаарх төрийн бодлогын албан ёсны үзэл баримтлал юм.

Монгол Улсын цэргийн номлолын үндэст «зөвхөн өөрийгөө батлан хамгаалах тухай Монгол Улсын Үндсэн хуулийн зарчимд тулгуурлана» хэмээн Монгол Улсын батлан хамгаалах бодлогыг тодорхойлов. Цэргийн хүч хэрэглэх буюу хэрэргээхээр заналхийлэхийг маргаантай асуудлыг шийдвэрлэх арга зам гэж үзэхгүй бөгөөд аливаа хүчирхийлэл, түрэмгийллийн үр дүн хүлээн зөвшөөрөхгүй байх, өөр улсын эсрэг ямар ч тохиолдолд зэвсэгт хүчнээ түрүүлж хэрэглэхгүй, цэргийн аюул занал бусдад учруулахгүй, өөрөө бусдын зэвсэгт түрэмгийлэлд өртсөнөөс бусад тохиолдолд дайн, мөргөлдөөнд оролцохгүй гэдгээ эл номлолд заан бэхжүүлжээ. Харин ажиглагч, сайн санааны туслаацаа үзүүлэх, зуучлах, эвлэрүүлэх зэрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн дагуу Нэгдсэн Үндэстний Байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх талаар хүлээсэн үүргээ биелүүлэх юм. Тус улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалд цэргийн шууд заналхийлэл учирсан буюу учрах нь бодитой болсноос бусад тохиолдолд цэргийн аливаа эвсэл холбоонд нэгдэхгүй байх, Монгол Улсын хуульгүйгээр гадаадын цэргийн хүчийг өөрийн нутаг дэвсгэрт нэвтрүүдэхгүй, байрлуулахгүй, дамжин өнгөрүүлэхгүй байх бодлогыг чанд баримтлахаар заажээ.

Монгол Улс хэнийг дайснаа гэж үзэх нэг гэвэл, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалд цэргийн хүчээр заналхийлсэн, зэвсэгт халдлага, түрэмгийлэл үйлдсэн улс орон, тэдний энэхүү түрэмгийлэлд холбоотон нь болж буй этгээдийг л дайснаа гэж үзнэ.

Монгол Улс батлан хамгаалах зорилтоо хэрэгжүүлэхдээ улс төр-дипломатын аргыг урьдлаа болгох бодлого баримтлах юм.

Эл номлолд батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог бүрдүүлэн бэхжүүлэх, Монгол Улс тайван цагт улс орныхоо батлан хамгаалах хэрэгцээ шаардлага, эдийн засгийн боломжид нийцсэн номхон, чадварлаг зэвсэгт хүчин, бусад цэрэгтэй

байхаар заасан юм. Тухайлбал, ерөнхий зориулалтын цэрэг нь зэвсэгт хүчний үндсэн цөм, улс орныг батлан хамгаалах зорилтыг цэргийн хүчээр хэрэгжүүлэх гол хүч нь байх, улсын агаарын довтолгооноос хамгаалах цэрэг нь тайван ба дайны цагт улсын агаарын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, улс орны эдийн засаг, засаг захиргааны төв болон бусад чухал бүс нутгийг дайсны дайралтаас халхлан хамгаалах, барилгын цэрэг нь тайван цагт барилга, байгууламжийн ажил гүйцэтгэхийн зэрэгцээ шаардлагатай үед дайчилгааны даалгавраар хүлээсэн үүргээ биелүүлэх бэлтгэлтэй байх гэх мэтээр зэвсэгт хүчний бүтцэд орж буй ерөнхий зориулалтын, улсын агаарын довтолгооноос хамгаалах, барилгын иргэний хамгаалалтын, дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний болон бусад цэрэгт багтаж буй хилийн ба дотоодын цэргийн тайван ба дайны үед гүйцэтгэх чиглэл, зориулалтыг нэгбүрчлэн тодорхойлсон байна.

Монгол Улс гаднын зэвсэгт гүрэмгийлэлд өртвөл түүнийг няцаах, өөрийгөө хамгаалах дайныг өөрийн бүх хүч хэрэгсэл, боломжийг нэгтгэн дайчилж нийт ард түмний оролцоонд тулгуурлан явуулах, тэгэхдээ Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн дагуу бусад улс орон, олон улсын байгууллагын тусламж дэмжлэгийг авч болохыг заасан юм. Монгол Улсын цэргийн номлолыг хэрэгжүүлэхэд зөвхөн цэргийн байгууллагууд төдийгүй төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, нийт аж ахуйн нэгж, байгууллага, иргэд идэвхтэй оролцох үүрэгтэй юм.

Улсын Их Хурлын Гадаад бодлого,
азуудгүй байдлын байнгын хорооны
аарга Д. Лүндээжанцан

СЭТГҮҮЛЭГНИН ЗӨВЛӨЛ:

Ерөнхий зөвлөгч Н. Ринчиндорж
Нарийн бичгийн дарга Сан. Жаргалсайхан
Гиншүүд Т. Баасансүрэн
Ч. Баяуу

Техник редактор Т. Сарантуяа
Уншиж хянасан Сан. Жаргалсайхан
Б. Янжинмахам

Үйлдвэрт шилжүүлсэн 1994 оны 8-р сарын 30-нд,
Өрөлтөд 1994 оны 9-р сарын 6-нд, Хэвлэлтэнд
1994 оны 10-р сарын 18-нд, Хэвлэлийн хуу-
даг 7.5, Хэвлэсэн тоо 3685 ширхэг.

Засгийн газрын хэвлэх үйлдвэр